

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 3 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 – 4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5 – 113

- Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын мэдээлэл сонсох*

7 – 82
- Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох*

82 – 113

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 3 дугаар сарын 17-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 45 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батбаяр, П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Ч.Ундрэм;

Тасалсан: Ж.Батсуурь, Х.Баттулга, Б.Батцэцэг, С.Ганбаатар, Х.Жангабыл, Ж.Золжаргал, Ц.Мөнхтуяа.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун хоёр дахь асуудал буюу Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсох асуудлыг хэлэлцэх асуудлын дарааллын эхэнд хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа үг хэлэв.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулууны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Нэг.Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Боловсролын дэд сайд Д.Гантулга, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Ж.Хунан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Л.Төгсбаяр, Боловсролын яамны Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга А.Халиунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Буянбат, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн

газрын дарга Л.Бадамцэцэг, мөн газрын Дотоод аудит, мониторингийн газрын дарга Ц.Үүрцайх, Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Ойнбаяр, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга Д.Будзаан, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч Ж.Азжаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч С.Пүрэвсайхан, Боловсролын сайдын зөвлөх Ц.Алтансор нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Н.Наранцогт, зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, Б.Батцэцэг, ажилтан Д.Оюун, У.Наранбуян нар байлцав.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан “хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах” заалтын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Боловсролын дэд сайд Д.Гантулга нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Б.Пунсалмаа, Г.Лувсанжамц, Ж.Галбадрах, О.Саранчулуун нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Боловсролын дэд сайд Д.Гантулга, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул, Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга Б.Баярсайхан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Буянбат, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Адьяасүрэн, Боловсролын сайдын зөвлөх Ц.Алтансор нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, С.Замира, О.Саранчулуун, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, мөн газрын Эд

хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Болормаа, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, мөн яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батзориг, мөн газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн шинжээч Б.Хосбаяр, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Г.Баярсайхан, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын дарга Б.Энхбаяр, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцны дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч З.Ганбат, Нийслэлийн Хууль, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Сарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхэлсэн газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Н.Наранцогт, зөвлөх Л.Зулцэцэг, референт Г.Нямсүрэн, С.Уянга, Б.Батцэцэг, ажилтан Д.Оюун, У.Наранбуян нар байлцав.

Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 4 цаг 12 минут үргэлжилж, 25 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 57 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 17-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
12 цаг 45 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Байнгын хорооныхоо эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

2026 оны хаврын чуулган нээгдсэний дараа хамгийн анхны Байнгын хороо буюу манай Өргөдлийн байнгын хорооны хуралдаан эхлэх гэж байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Нийт 25 гишүүнээс 13 буюу 52 хувийн ирцтэй байна.

Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн ирсэн, Жанчивын Галбадрах гишүүн ирсэн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн ирсэн, Мягмардашийн Сарнай гишүүн ирсэн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн ирсэн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн, Дүгэрийн Рэгдэл гишүүн ирсэн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг ирсэн байна, Далайн Батбаяр гишүүн томилолттой, Чинбатын Ундррам гишүүн гадаад томилолттой, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн орон нутагт томилолттой гэсэн байна.

Тэгээд цөмөөрөө мэдэж байгаа. Ирц, санал хураалтын асуудал дээр дэгтэй, ёс зүйтэй болъё гээд хууль ороод ирсэн байгаа. Энэ үед манай гишүүд Байнгын хорооныхоо хуралдаанд оролцох асуудал дээр хариуцлагатай хандана байх гэж бодож байна.

Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар өнөөдөр хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хоёр асуудал байна.

Нэгдүгээрт, Орон сууц захиалах худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээлэл сонсоно.

Энэ асуудлаар бид намрын чуулганы эцэст хаврын чуулганаар хийх хяналт шалгалт буюу хуулийн хэрэгжилттэй холбоотой ажлын цаглаварт энэ орон сууц захиалга худалдан авах харилцаан дээр доголдол гарч байгаа.

Залилангийн асуудал гарч байгаа асуудлууд дээр маш их иргэдийн өргөдөл ирсэн.

Энэ өргөдөл дээр ажиллаж, хууль тогтоомжийн биелэлтээс гадна хийдэл хаанаа байгаад байна гэдгийг олж тогтоож, бодлогын шийдэл гаргах ажлыг Өргөдлийн байнгын хороо хаврын чуулганы төлөвлөгөөнд оруулсны дагуу өнөөдөр мэдээлэл сонсох гэж байна.

Хоёрдугаар асуудал, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсролын яамны мэдээллийг сонсоно.

Нийгэмд эмзэглүүлсэн асуудлууд зөндөө байна. Үүнийг шуугиад өнгөрдөг биш, мэдээллээ сонсож, бодлогын шийдэл, цаашид авах арга хэмжээний тухай ажил хэрэгч, хамтарч ярилцах хэрэгтэй байна гэдэг утгаар өнөөдөр энэ хоёр асуудлыг хэлэлцэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу? О.Саранчулуун гишүүн үг хэлье. О.Саранчулуун гишүүний микрофоныг өгөөрэй.

О.Саранчулуун: Хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчлөөд, барилгын асуудлыг дараа нь оруулаад эхлээд дээрэлхэлт, хүчирхийллийн асуудлыг хэлэлцэх саналтай байна.

О.Номинчимэг: Хэлэлцэх асуудалтай холбоотой Д.Ганбаа гишүүний микрофон.

Д.Ганмаа: Тэгээд ер нь ингээд 12.00 цагаас эхлэх хурал цагийн дараа эхэлдэг. Дараагийн хуралтайгаа зэрэгцдэг иймэрхүү юмаа бодолцоод, ирвэл ирнэ гэдгээ хэлээд, ирэхгүй бол ирэхгүй гэдгээ мэдэгддэг баймаар байна.

Бие биенийгээ хүлээгээд хараагаад сууж байдаг баймааргүй байна.

О.Номинчимэг: Өнөөдрөөс угаасаа бүгд иргэд харж байгаа. Байнгын хороо чуулганы ирцийн асуудал. Тийм ээ. Энэ үед манай гишүүд хариуцлагатай хандаж, бусдадаа хүндэтгэлтэй хандана биз ээ.

Хоёр гишүүнээс дараалал хэлэлцэх асуудлын дараалал солихтой холбогдуулж горимын санал гарч байна.

Тэгэхээр горимын саналаар санал хураалт явуулах уу? Эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. /алх цохив/

Горимын санал гарсантай холбогдуулан Байнгын хороо чуулган эхэлснээс хойш эхний санал хураалт учраас эхлээд бүртгэлийн санал хураалт явуулъя. /алх цохив/

Бүртгэлийн санал хураалт дээр орсон гишүүд орж байна. Тийм ээ. Ингэхээр О.Саранчулуун гишүүн болон Д.Ганбаа гишүүний гаргасан горимын саналаар буюу өнөөдрийн хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилж эхний асуудлаар хүүхэд үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой мэдээллийг сонсьё гэсэн саналаар санал хураалт. /алх цохив/

Горимын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

69.2 буюу хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт орж эхний асуудлаа хэлэлцэж эхэлье.

**Нэг.Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан
хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх,
хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх
Боловсролын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд,
Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын
мэдээлэл сонсох**

Нэгдүгээр асуудал. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах заалтын хэрэгжилтийн талаарх Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын дэд сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр сайд өөрөө ирсэн байгаа учраас мэдээлэл сонсоно.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан “хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах” заалтын хэрэгжилтийн талаарх эхлээд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир сайдын мэдээллийг сонсьё.

Тилеуахын Аубакир сайдыг мэдээлэл хийхийг урьж байна. Микрофоныг нээнэ үү.

Т.Аубакир: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний товч мэдээллийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлаас 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хууль Шинэчилсэн найруулга 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулийн шинэчлэлээр хүүхэд хамгааллын тогтолцоо, хүүхэд хамгааллын үйлчилгээг өргөжүүлсэн.

Хуулийн 23 дугаар зүйлд боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудлыг тусгасан бөгөөд үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, гомдол мэдээллийг хүлээн авч шийдвэрлэн ажиллахыг боловсролын салбарт үүрэгжүүлсэн байдаг.

Тухайлбал хуулийн 23 дугаар зүйл боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, тухайлбал боловсролын орчинд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, хамгаалах, гомдол мэдээлэл хүлээн авах, нээлттэй суваг ажиллуулах, хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагчийн хүүхдийн эрх, зан үйлийг засах, нийгэмшүүлэхэд чиглэсэн сургалтад хамруулах зэргээр боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын зохицуулалт бий болгосон.

108 хүүхдийн шуурхай тусламж хамгааллын төвд 2024-2026 оны 3 дугаар сарын 13-ны байдлаар үе тэнгийн дээрэлхэлтийн нийт 2300 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс 214 дуудлага мэдээлэлд анхан шатын сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлж, 2086 дуудлага мэдээллийг 21 аймаг, 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хэлтсүүдэд шилжүүлэн хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажилласан бөгөөд 2026 оны 3 дугаар сарын 13-ны байдлаар байдлаар 131 дуудлага мэдээлэл дээр ажилласан байна.

Нийт ирсэн 2300 дуудлагын 24.6 хувь нь эмэгтэй, 75.4 хувь нь эрэгтэй хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн байгаа ба –

- 2-оос 5 насны 50 хүүхэд,
- 6-аас 10 насны 415 хүүхэд,
- 11-ээс 14 насны 1075 хүүхэд,
- 15-аас 18 насны 563 хүүхэд байгаа бөгөөд –

- 11-ээс 14 насны хүүхдүүд үе тэнгийн хүчирхийлэл, дарамтад өртдөг нь дийлэнх хувийг эзэлж эзэлж байгаа юм.

Үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн орчноор нь авч үзвэл нийт 2300 дуудлагын

- 69.6 хувь нь боловсролын орчинд,
- 21.1 хувь нь олон нийтийн арга хэмжээ, үйлчилгээ, гудамж талбайн орчинд,
- 8.9 хувь нь гэр бүлийн орчинд,
- 0.4 хувь нь хэвлэл мэдээлэл, цахим орчин, эрүүл мэнд, хүүхэд хамгааллын үйлчилгээний орчинд тус тус үйлдэгдсэн байгаа буюу дийлэнх хувь нь боловсролын орчинд үйлдэгдэж байна.

Дуудлага мэдээлэл өгсөн эх сурвалжаар нь авч үзвэл –

- 1272 буюу 55.3 хувийг Гэмтэл согог судлалын үндэсний төв,
- 488 буюу 21.2 хувийг эцэг, эх,
- 250 буюу 10.8 хувийг хүүхэд өөрөө,
- 152 буюу 6.6 хувийг ах, эгч нар нь болон хүүхдийн өмнө үүрэг хүлээгч нар нь мэдээлсэн байдаг.

Дээрх дуудлага мэдээллээс харахад үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж байгаа нийт хүүхдийн 50-иас дээш хувь нь аливаа гэмтэл бэртэл авч Гэмтэл согог судлалын үндэсний төвд очиж үйлчилгээ авснаар бүртгэгдэж байна.

Үе тэнгийн дээрэлхэлтэд хэрхэн өртүүлж байгаа төрлөөр нь авч үзвэл –

- 1791 буюу 77.8 хувь нь бие махбодод халдаж,
- 231 буюу 10 хувьд нь удаан хугацаанд давтамжтай байдлаар дээрэлхэж буюу дэвтэр номыг авч шидэх, хувцсан дээр юм асгах, зурах, үг хэл амаар байнга доромжлох зэрэг үйлдлийг хийж,
- 113 буюу 4.9 хувь нь хэл амаар доромжилж,
- 79 буюу 3.4 хувь нь анги хамт олноос ялгаварлан гадуурхах,
- 15 буюу 0.6 хувьд мөнгийг нь дээрэмдэх, цахим орчинд доромжлох, дээрэлхэх хэлбэрээр үе тэнгийн дээрэлхэлт хүчирхийллийг үйлдэж байна.

Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2023, 2024, 2025 онд “Найз байя”, “Чи ганцаараа биш”, “Нууцтай байх эрх”, “Нэгдүгээрт хүүхэд”, “Зөв байя”, “Хамтдаа хамгаалъя”, “Цахим орчинд эерэг байя” зэрэг 92 төрлийн сургалт, нөлөөллийн ажил, Цагдаагийн ерөнхий газартай хамтран үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” аяныг үндэсний хэмжээнд, “Монголын сайн дурынхны холбоо” төрийн бус байгууллагатай хамтран “Because I am a Girl” 1000 охидын арга хэмжээ, “Ирээдүйд зөв иргэн болж төлөвших”, “Зөв танаас эхэлнэ” өдөрлөгийг зохион байгуулсан.

Мөн 2025 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам харьяа 9 дүүргийн хэлтсүүд, шүүхийн академи, дүүргүүдийн эрүүгийн хэргийн анхан шатын шүүхүүд хамтран 2025 онд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 24 мянга гаруй сурагчдад “Хүний эрхээс хүүхдийн эрх эхэлнэ”, “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг сургалтуудыг шүүхийн танхимд зохион байгуулсан.

- ▶ 2023-2025 онд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дээр дурдсан арга хэмжээний хүрээнд 290 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор 578 мянга 654 хүүхдэд 168 мянга 883 эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан байна.

Үе тэнгийн дээрэлхэлт гэдэг бол манай гишүүд сайн мэдэж байгаа. Энэ дээр боловсролын салбар буюу хүүхдүүдийн орчинд гол төлөв нөлөөллийн ажлыг байнга зохион байгуулах ёстой.

Тийм учраас нөлөөллийн ажлуудыг салбар яамдуудтай хамтран байнга зохион байгуулж байна.

Мөн үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр дүнг дээшлүүлэх, одоо үүсээд байгаа нөхцөл байдал салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагуудын даргын 2026 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 04/217 тоот чиглэлийг 21 аймаг, 9 дүүргийн удирдлагуудад хүргүүлж, Цагдаагийн ерөнхий газрын хамтарсан уулзалтыг 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, 3 агентлагийн даргын зөвлөмж бүхий хамтарсан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Баянзүрх, Хан-Уул дүүргийн хүүхдийн эрхийн хууль зүйн хороод хуралдаж нэр холбогдсон сургуулиудын хүүхэд хамгааллын багт үүрэг чиглэл өгөх, дүүргийн хэмжээнд үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч байна. Үүнд:

1.Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах нь нэн чухал байгаа бөгөөд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх саналтай байна.

Хүүхдийн эрх хамгааллын салбар дундын ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, Хүүхдийн эрх хамгааллын төлөвлөгөө 2026-2030 он боловсруулан баталж хэрэгжүүлэхээр салбар дундын ажлын хэсэг байгуулах шатад явж байна.

2.Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаарх илрүүлэлтийг сайжруулах чиглэлээрх дараах арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах шаардлагатай байна гэж үзэж байна.

- ▶ **Нэгдүгээрт**, “108” шуурхай тусламж хамгааллын төвд ирсэн

боловсролын орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллийн гэмт хэргийн шинжтэй дуудлагыг боловсролын салбарт, эсвэл сургуулийн нийгмийн ажилтанд программаар болон утсаар шуурхай шилжүүлж кэйстэй ажиллах боломжийг бүрдүүлэх.

Энэ хүрээнд сургуулийн нийгмийн ажилтны “108” утас руу нэвтрэх эрхийг өгөх, эсвэл боловсролын салбарын программтай холболт хийх ажил хийгдэх ёстой.

- ▶ **Хоёрдугаарт**, үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн тохиолдлыг илрүүлэх аяныг үе шаттай зохион байгуулж, шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийх.
- ▶ **Гуравдугаарт**, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.2.3-д заасны дагуу сургууль бүр хүчирхийллийн үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах нээлттэй суваг ажиллуулах.
- ▶ **Дөрөвдүгээрт**, хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээг боловсролын сургалтын байгууллага, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, дотуур байр зэрэг олон нийтийн үйлчилгээний газар, гудамж талбайд зохион байгуулах.

3.Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23.11-д заасны дагуу сургуулийн эцэг, эхийн зөвлөлийн хүүхдийн эрх, хамгааллын талаарх төлөвлөгөөг батлан эцэг, эхчүүдийг сургаж бэлтгэх, ахмад ажилтан, сайн дурын ажилтны оролцоотой сургууль, гудамж талбай, олон нийтийн үйлчилгээний газарт эргүүлийн ажлыг зохион байгуулах.

Дараа нь “Хүүхдээ сонсьё” сарын аяныг бүх байгууллага, хуулийн этгээдийн эцэг, эхийн зөвлөл, хүүхэд хамгааллын багаар дамжуулан улирал тутам зохион байгуулах.

Хүүхдүүдийн өөрсдийн санаачлан хэрэгжүүлсэн “Найз байя” зорилтот арга хэмжээг үе шаттай тогтмол зохион байгуулах, Хүүхэд хамгааллын тухай хуулийн

- 23.4.3-д хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд холбогдсон болон хохирогч, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжихтэй уулзалт зохион байгуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх,
- 23.4.4-д хохирогч хүүхдийг сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд нэн даруй хамруулах,
- 23.4.5 хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхдэд дараах арга хэмжээг шат дараатай хэрэглэх гэсэн заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд хийсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, гарын авлага, сургалт хангалтгүй байна гэж үзэж байна.

Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам болон харьяалах агентлаг, төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулж, сургууль дээр хэрэгжүүлэх хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч болон холбогдсон хүүхэд, түүний эцэг, эхэд зориулсан урт богино хугацааны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, халамжийн нийгмийн ажилтныг сургах, чадавхжуулах ажлыг 4, 5 сард зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

4.Сургууль дээрх Хүүхдийн оролцооны клуб, Суралцагчийн зөвлөлийн сурагчдыг хүүхдийн эрх, хүний эрх, цахим орчны зохистой хэрэглээ, үе тэнгийн дээрэлхлийн хор нөлөө ба таньж мэдээлэх талаар сургалт зохион байгуулж, хүүхдээр дамжуулан суралцагчдад нөлөөлөх ажлыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

5.Хүүхдийн эрхийн улсын байцаагч, боловсролын салбарын улсын байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын төлөвлөгөөний хүрээнд аймаг, нийслэл, дүүргийн түвшинд сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын хэрэгжилтийг шалгах хамтарсан удирдамж батлан хэрэгжүүлэх.

6.Хүүхэд, гэр бүлийн салбар, хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, салбарын болон бусад салбарын мэргэжилтнийг сургаж чадавхжуулах, кэйс шийдвэрлэлтэд хяналт тавих, мөшгөх, судалгаа шинжилгээ хийх ажил хангалттай хийгдээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 49, 50, 51 дүгээр зүйлд заасан хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна.

7.Мэргэшсэн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж хүүхэд, гэр бүлтэй ажиллах, нийгмийн ажил үйлчилгээг сайжруулах.

8.Өсвөр насныхны сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсрол, гэр бүл, эрүүл мэндийн, төрийн захиргааны байгууллагууд болон мэргэжлийн төрийн бус байгууллагууд хамтран боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.

9.Байгууллага, хуулийн этгээд бүр хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах, хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хүүхдийн эрх зөрчигдөх, эрсдэлт нөхцөлд орох бүхий л орчныг илрүүлэн засах аян зохион байгуулах.

10.Засаг дарга, хамтарсан баг нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд эрсдэлтэй газруудад зөрчлийг илрүүлэх, хяналт тавих шаардлагатай гэж үзэж байна.

Ингээд дүгнэлт хийгээд тодорхой хэмжээнд бид санал болгож байгаа төлөвлөгөөнүүдээ танилцууллаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Т.Аубакир сайдад баярлалаа.

Яамдаас танилцуулж байгаа мэдээллийг урьдчилан өчигдөр Өргөдлийн байнгын хорооны гишүүддээ тараасан байгаа. Та бүхэн авсан байх гэж очно.

Дараагийнх нь Хүүхэд хамгааллын тухай хуульд Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах гэсэн заалтын хэрэгжилтийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр таныг мэдээлэл хийхийг урьж байна.

Б.Энхбаяр сайдын микрофоныг нээж өгнө үү.

Б.Энхбаяр: Слайд байна уу? Слайд байгаа болов уу? Слайдаар хаана ажиллуулж байгаа билээ. Слайд би бас дэлгэцэд слайд бэлдэж ирсэн байгаа.

О.Номинчимэг: Гишүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг Powerpoint мэдээллийг бас тараасан байгаа. Бүгдэд нь файлаар бас очсон байгаа. Тийм ээ.

Дэлгэцэд өгөх боломж байна уу? Ажлын албаныхнаас. Дэлгэцэд гялс оруулчих.

Тэгвэл сайдын мэдээллийг дараа нь болоод, эхлээд боловсролын мэдээллийг. Тэр хооронд РРТ-ийг нь тавихыг бэлдье. Тэгэх үү. Цаг авах нь. Тэгвэл одоо угаасаа гурван яамдаас, сайдуудаас мэдээлэл сонсож байгаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд заасан “хүүхэд үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ авах” гэдэг заалт байгаа.

Энэ заалтын хэрэгжилтийн талаарх Боловсролын дэд сайдын мэдээллийг сонсьё. Боловсролын дэд сайд Донровын Гантулга таныг мэдээлэл хийхийг урьж байна.

Боловсролын дэд сайд 4 дүгээр микрофон. Д.Гантулга дэд сайдын микрофоныг нээж өгнө үү.

Д.Гантулга: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг эрье.

Би Хүүхэд хамгааллын тухай хуулийн боловсролын салбар дахь хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хийе.

► **Нэгдүгээрт, Салбарын мэдээлэл.**

2025-2026 оны хичээлийн жилд 2437 боловсролын сургалтын байгууллагад 1.2 сая гаруй суралцагч суралцаж, 114 мянга 146 багш, ажилтан ажиллаж байна. Үүнээс –

- ➔ сургуулийн өмнөх боловсролын нийт 1399 байгууллагад 258 мянга 849 хүүхэд,
- ➔ ерөнхий боловсролын нийт 900 орчим сургуульд 819 мянга 907 суралцагч, үүнээс –
 - ➔ 378 мянга 408 буюу 46.2 хүн бага ангид,
 - ➔ 290 мянга 628 буюу 35.4 хувь нь дунд ангид,
 - ➔ 150 мянга 871 буюу 18.4 хувь нь ахлах ангийн суралцагчид байна.
- Боловсрол нөхөх болох хөтөлбөрөөр нийт 4241 суралцагч,
- мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллага болон политехникийн 70 орчим коллежид 41 мянга 584 суралцагч,
- төрийн болон хувийн өмчийн 68 их сургууль, коллежид нийт 161 мянга 891 суралцагч тус тус суралцаж байна.

Боловсролын ерөнхий хууль батлагдсанаар сургууль, цэцэрлэг анх удаа хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулсан тусгай зардалтай болж Боловсролын байгууллагын орчинд хүүхдийн аюулгүй байдал хамгааллыг бодитойгоор хангах санхүүгийн болон эрх зүйн зохицуулалт бүрдсэн.

Ингэснээр хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулах, багш, ажилтны чадавхыг бэхжүүлэх, хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх боломж бүрдэж, хүүхэд хамгааллын тогтолцоог сургууль, цэцэрлэгийн түвшинд бэхжүүлэх бодлогын ач холбогдолтой алхам болсон.

Засгийн газрын 2024 оны хувьсах зардлын дундаж хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай 39, 53 дугаар тогтоолоор баталсан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшихэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж хэмжээ, түүний бүрэлдэхүүнд хүүхэд хамгааллын зардлыг байршлаас шалтгаалсан итгэлцүүлээр тооцон олгож байна.

Боловсролын сайдын 2024 оны заавар шинэчлэн батлах тухай А/279 дүгээр тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан хүүхэд хамгааллын зардал төлөвлөх, хуваарилах зааврын дагуу цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын баг үйл ажиллагаандаа зарцуулж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52.6-д Засгийн газрын гишүүд эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын чиглэлээр хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүр төсөвтөө тусгуулах арга хэмжээ авч ажилласаар ирсэн.

Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 онд боловсролын салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээнд 4.8 тэрбум төгрөг зарцуулсан бол 2026 онд 8.2 тэрбум төгрөгийг төсөвт тусгаад байна.

Хүүхэд хамгааллын зардлын 50-иас доошгүй хувийг урьдчилан сэргийлэх, 30 хүртэлх хувийг хамгаалах, нөхөн сэргээх, 20 хүртэлх хувийг шуурхай тусламжийн үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөдөг.

Цэцэрлэг, сургуулийн хүчин чадал, байршлаар тооцож хүүхэд хамгааллын зардлыг 2025 онд олгосон байдлыг авч үзвэл цөөн хүүхэдтэй цэцэрлэг 2 сая орчим төгрөг, хамгийн олон хүүхэдтэй цэцэрлэг 71.8 сая төгрөгийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тухайд цөөн суралцагчтай сургууль 3.7 сая төгрөг, хамгийн олон суралцагчтай сургууль 205.4 сая төгрөгийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд зарцуулаад байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуульд анх удаа боловсролын сэтгэл зүйч ажиллуулж эхэлсэн.

- ▶ 2024-2025 оны хичээлийн жилд 421 сэтгэл зүйч ажиллаж байсан бол энэ хичээлийн жилд 799 сэтгэл зүйч болж, 378 ерөнхий боловсролын сургууль шинээр сэтгэл зүйчтэй болоод байна.
- ▶ 2024-2025 оны хичээлийн жилд нийт 953 нийгмийн ажилтан ажиллаж байсан бол энэ хичээлийн жилд 978 болж, 25 нийгмийн ажилтнаар нэмэгдсэн.
- ▶ 2022-2023 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээний тайланг Боловсрол, шинжлэх ухааны сайдын маягт түүний нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай 2022 оны А/313 дугаар тушаалаар баталсан үнэлгээний маягтаар авч эхэлсэн.
- ▶ 2024-2025 оны хичээлийн жилийн сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын тайлангаас дурдвал ерөнхий боловсролын 886 сургуульд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж, 7939 хүүхэд хүүхэд хамгааллын багийн гишүүд ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нь 748 мянга 378 суралцагчийн 58 мянга 055 нь дунд, өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.

Үүний 16 мянга 117 суралцагч нь үе тэнгийн дээрэлхэлтэнд өртсөн байна.

Хүүхэд хамгааллын шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх хүрээнд 5165 суралцагчийг бусад байгууллагын хамгааллын үйлчилгээнд холбон зуучилж, 47 мянга 541 суралцагчийг нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулж, 698 мянга 983 суралцагч, 379 мянга 454 багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, 310 мянга 826 суралцагч, 224 мянга 194 багш, ажилтан, эцэг, эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгч ажиллалаа.

Энэхүү маягтыг Хүүхэд хамгааллын тухай хуульд нийцүүлэх, шинэчлэх шаардлага үүсэж байгаа.

► **Хоёрдугаарт, Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн талаар.**

Хүүхэд хамгааллын тухай хуулийн –

- 23.1-д боловсролын сургалтын байгууллага, “Насан туршийн суралцахуйн төв”, сүм, хийдийн шашны сургууль, хүүхэд хамгааллын бодлого, түүний хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.
- 23.2-т энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлж, 13 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль хүүхэд хамгааллын бодлого төлөвлөгөөний дагуу хамтарсан багаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Боловсролын сайдын 2025 оны 12 сарын 01-ний А/567 тоот тушаалаар баталсан зааврын хэрэгжилтийг хангах зорилгоор 21 аймгийн Боловсролын газар, нийслэлийн 9 дүүргийн боловсролын хэлтсийн хүүхдийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургах боловсрол хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө, чиглэлийг өгч ажиллаж байна.

Боловсролын ерөнхий газраас боловсролын сургалтын байгууллагын орчин, дотуур байранд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээг тасралтгүй аван ажиллаж байна.

Цэцэрлэг, сургуулийн хүүхэд хамгааллын баг сургуулийн орчинд болон сургуулиас зохион байгуулж байгаа бүхий л арга хэмжээнд хүүхдэд ээлтэй, аюулгүй байдлын стандартыг мөрдүүлж, эрсдэлтэй сургалт, үйл ажиллагааг зогсоох, татгалзах, хяналтын тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн төв, Монголын Хүүхдийн анагаахын академитай хамтран

нийслэлийн ерөнхий боловсролын 35, 49, 57, “Эрдмийн өргөө”, 95, 96 дугаар сургуулийн 30 суралцагчийг үндэсний сургагчаар бэлтгэн нийслэлийн 200 суралцагчийг өсвөр үеийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, үе тэнгийн төлөөлөгчөөр бэлтгэн ажиллаж байна.

Боловсролын байгууллагууд хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор нээлттэй сувгийг бий болгож, тогтвортой ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж, энэ хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудаас авсан судалгаагаар 59.2 хувь нь хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар гомдол, мэдээллийг гар утас ашиглан цахим хэлбэрээр илгээх, хүлээн авах, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарын оролцоо хяналтыг нэмэгдүүлэх боломжтой, хэрэгжүүлэх илүү үр дүнтэй гэсэн санал өгсөн.

Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд аюулгүй цахим орчин зэрэг олон төрлийн аян, сургалтуудыг зохион байгуулж, суралцагч, эцэг эхийг хамруулахын зэрэгцээ хүчирхийлэл, дээрэлхэлтийн талаар гомдол хүлээн авах чимээгүй итгэл нээлттэй сувгийг ажиллуулах бэлтгэл ажлыг ханган техникийн шийдлийг яг одоо туршиж байна.

Хичээлийн жилийн турш хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай 5126 дуудлага, мэдээлэл ирсэн бөгөөд 2185 дуудлага хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдэгдсэн нь тогтоогдож, 2941 дуудлага, мэдээлэл хүүхдийн эсрэг хүчирхийллийн дуудлага болох нь тогтоогдоогүй болно.

Мөн хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нэн даруй мэдэгдэх хуулийн заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд сургуулийн захиргаа болон багш нар мэдэгдэх ажиллагааны тэмдэглэл, цахим болон хувийн ирцийн хөтлөн ажиллаж байна.

Энэ нь зөвхөн хяналт биш хүүхдийн аюулгүй байдал алдагдсан тохиолдолд багш сургуулийг хамгаалах эрх зүй, хууль зүйн баримт бичиг болно.

Өнгөрсөн хичээлийн жилд суралцагчийн хөгжил хамгааллын чиглэлээр 15 хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 4765 багш, ажилтан 305653 суралцагч хамрагдлаа.

Хүүхэд хамгааллын багийн гишүүдийн сургалтад Хүүхэд хамгааллын тухай хуулийн 36.4, 47.3 дугаар заалтыг танилцуулсан бөгөөд тус хичээлийн жилд иргэн болон суралцагчийн мэдээлэл задруулсан асуудал бүртгэгдээгүй.

Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа 580 гаруй сэтгэл зүйч нь 423 мянга 400 суралцагч, 198 мянга 750 эцэг эх, асран хамгаалагч, 56 мянга 300 багш, ажилтанд сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлсэн. Үүнээс хүүхэд хамгааллын нөхөн сэргээх үйлчилгээний сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан 19 мянга 202 сурагч байна.

Хүүхэд хамгааллын тухай 23 дугаар зүйлд Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллыг өргөжүүлж, боловсролын сургалтын байгууллага, “Насан туршийн суралцахуйн төв”, сүм, хийдийн шашны сургууль, хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байх, боловсролын орчинд үе тэнгийн дээрэлхэлт, хүүхдийн эрхийн зөрчлийн мөрөөр авах арга хэмжээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, хэрэгжилтэд тавих чиг үүргийг Боловсролын яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яамтай хамтран хэрэгжүүлэхээр заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, боловсролын сургалтын байгууллага, сүм, хийдийн орчны аюулгүй нөхцөл байдалд үнэлгээ хийх журам, боловсролын орчин дахь хүүхэд хамгаалал, үйлчилгээний нийтлэг шаардлагыг тус тус хамтран боловсруулж байна.

Хэдийгээр боловсролын салбар дээр хүүхэд хамгааллын чиглэлээр харьцангуй арга хэмжээ нэлээн ихээр хэрэгжиж байгаа ч гэсэн бодит байдал дээр бас энэ хангалтгүй байна. Иймд яг өнөөдрийн байдлаар хүүхэд хамгааллын “Аюулгүй сүлжээ” гэдэг үндэсний загварыг боловсруулж ажиллахаар ажиллаж байна.

Энэ нь үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлыг –

- ▶ сургуулийн түвшинд,
- ▶ хүүхдийн түвшинд,
- ▶ эцэг, эхийн түвшинд,
- ▶ үндэсний түвшинд –

гэсэн 4 түвшинд авч хэрэгжүүлдэг цогц арга хэмжээ.

Тэгэхээр энэ талаар мэдээллийг Байнгын хорооны гишүүд бас нэмэлт мэдээлэл сонин дээр гарсан байгаа. Манай яамныхан тарааж өгнө. Тараагаад өгсөн байгаа юм байна.

Мөн хоёрдугаарт нийгмийн сүлжээн дэх хүүхдийн оролцоог зохицуулах хуулийн төслийг үзэл баримтлал нь батлагдсан. Хуулийн төслийг ирэх долоо хоног юм уу, тэрний дараагийн Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар манай яамнаас ажиллаж байна.

Энэ нь мөн үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой, ялангуяа цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэлттэй эсрэг авах нэлээн дорвитой арга хэмжээ болно гэж үзэж байна. Баярлалаа. Танилцуулга дууслаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Донровын Гантулга дэд сайдад баярлалаа.

Ингээд сүүлийн буюу Хууль зүй, дотоод хэргийн сайдын Хүүхэд хамгааллын тухай хуульд “Хүүхэд гэмт хэрэг, зөрчил хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг авах” гэж заасан заалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг сонсьё.

Баттөмөрийн Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Та бүхэнд танилцуулга, мэдээллээ слайд хэлбэрээр танилцуулж байна.

Эхний слайдад манай улс дахь ер нь хүүхэд хамгааллын тогтолцоо, зохион байгуулалт маань ямар зохион байгуулалттай ажилладаг вэ гэдгийг Та бүхэнд харуулж байна.

Монгол Улсын Засгийн газар хуулийн хэрэгжилтийг Улсын Их Хурлын өмнө хариуцаж байна.

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, хүүхэд гэр бүл, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн яам ажиллаж байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажлын алба бүх яамдын төлөөллийг оролцуулж ажилладаг.

Яг анхан шатад нутгийн өөрөө удирдах байгууллагын хүрээнд Засаг дарга нар энэ асуудлыг хариуцаж байна. Засаг дарга нарын яг доор хамтарсан баг хэлбэрээр салбар дундын хэлбэрээр ажилладаг.

Яг хүүхэд хамгаалалтай холбоотой асуудал дээр хамгийн сүүлийн баганад байгаа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хүүхэд хамгааллын асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд чиг үүргийн дагуу хариуцаж ажилладаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажил зөвлөлийн дэргэд 2017 оноос эхлээд Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийг байгуулж ажиллуулж байгаа. Энэ нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2016 оны 10 сард Улсын Их Хурлаас анх удаа баталсан.

10 жилийн хугацаанд хэрэгжиж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлыг гэмт хэрэг юм, зөрчил юм гэж манай улс ял шийтгэл ногдуулаад 10 жилийн хугацаа болж байгаа гэсэн үг.

Энэ хүрээнд олон асуудлууд яригддаг. Тодорхой үр дүнгүүд нэлээн гарч ажиллаж байгаа.

Засгийн газрын түвшинд миний бие сая сайдаар томилогдоод Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, түүний харьяанд байгаа бие даасан 5 дэд зөвлөлийг нэгтгэх нь зүйтэй гэсэн ийм бодлого барьж Засгийн газрын хуралдаанд асуудал оруулах гэж байгаа.

Энэ хүрээнд хүчирхийлэлтэй тэмцэх урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагааны 2026-2030 оны төлөвлөгөө гэдгийг төслийг боловсруулж дууссан. Одоо яамдаас санал авагдах ажлууд хийгдэж байгаа гэдгийг Та бүхэнд хэлье.

Эрх зүйн бодлогын хүрээнд ямар асуудлууд байна вэ гэхээр хамгийн гол нь бид Гэр бүлийн тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барьсан.

Би Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдох чуулганы хуралдаанд бас хэлж байсан. Сайдаар томилогдоод миний хамгийн анхны өргөн барих хууль бол Гэр бүлийн хууль байна гэж хэлж байсан. Яг үүний дагуу долоо хоногийн дараа Засгийн газрын хуралдаанаар Гэр бүлийн тухай хууль болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барьж, намрын чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэсэн.

Одоо Улсын Их Хурал хаврын чуулганаар бас хугацаа алдалгүй энэ хуулийн төслийг батлах шаардлагатай байгаа. Яагаад гэхээр шүүгчид маань зарлагдаад, эхнээсээ томилогдоод байгаа. Гэр бүл, хүүхдийн асуудлыг бие дааж хянан шийдвэрлэх энэ процесс нь хуульчлагдаагүй байгаа.

Тийм учраас энэ гэр бүлийн шүүх маань манай улсад яг ажиллаж эхлээгүй. Энэ процессын хуулиа хүлээгдээд байгаа юм.

Нөгөө талаар эрхэм гишүүдийн анхааралд хандуулах шаардлагатай нэг асуудал бол Гэр бүлийн хүүхдийн шүүхийг манай улс анх бие даасан хэлбэрээр байгуулчхаад байдаг. Өөрөөр хэлбэл энэ хүүхдийн асуудлууд дээр илүү гэр бүл, хүүхдийн нандин харилцааг ойлгох мэргэшсэн, түүнтэй хил нэвтрэлцэх ийм бие даасан шүүгчтэй болж байгаа гэдэг нь энэ асуудлыг нэлээн анхаарч байна гэсэн үг.

Энэ дээр байрны асуудал нэлээн тулгамдсан асуудал байгаа. Мэдээж бүх шатны шүүгчид байр сав, ширээ сандлаас эхлээд хүндрэл байгаа гэдгийг ойлгож байгаа.

Бидний өргөн барьсан хуульд жишээлбэл нийслэл Улаанбаатар хотын хувьд тойргийн нэг шүүх байхаар хуулийн төслөө өргөн барьсан. Энэ шүүх маань хаана байх вэ гэдэг асуудал байгаа. Санаагаар болдог бол энд дандаа гэр бүлийн асуудлууд, хүүхдүүд бас зарим тохиолдолд ирж үйлчлүүлэх гээд байгаа учраас тийм нэг шорон, гяндан шиг хашаа, хэрэм цайз, цэрэг цагдаа болсон ийм орчинд

биш илүү тийм таатай, хүүхэд сэтгэл зүйн хувьд ямарваа нэгэн байдлаар дарамт учруулахааргүй ийм зураг төсөлтэй орчинтой шүүхийг нэг загвар олоод байгуулах юм гэсэн хувь хүний мөрөөдөл байгаа.

Тэр ч утгаараа өмнө нь би Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр энэ шүүхийн байрыг баривал яасан юм бэ гээд газрын асуудлыг нь хөөцөлдөөд явж байсан юм.

Тэгээд сая юм хийгдээгүй өнгөрсөн байсан юм. Байрных нь асуудлыг нь одоо бол Шүүхийн ерөнхий зөвлөл. Х.Баасанжаргал гишүүний танилцсан байх. Тийм ээ. Баянхошуунд гэж байгаа биз дээ. Сонгинохайрхан дүүргийн захад байгаад байгаа байхгүй юу. Нэг ийм байр яриад байгаа юм.

Тэгээд тэр бол надад бас нэг их таалагдаж өгөхгүй. Болж өгвөл уг нь Шүүхийн ерөнхий зөвлөлийг би одоо энд Хууль зүйн сайдын хувьд гэхээсээ илүү Их Хурлын гишүүний хувьд миний санал бол.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн одоо байрлаж байгаа байр Монгол Улс дахь яг шүүх хуралдааны зориулалтаар барьсан цорын ганц байр юм. Зураг төсөл нь. Энд Шүүхийн ерөнхий зөвлөлийнхөн өөрсдөө байрлаад 16 жил болж байна л даа. Тасганы овоон дээр байдаг. Гаднаа авто зогсоолтой. Эргэн тойронд нь бас нэг тийм илүү дутуу баар сав байгаад байдаггүй ийм байр байгаа юм.

Тийм учраас нэгэнт хүн оффис бол хааж суусан болно. Яг иргэдэд үйлчилгээ үзүүлдэг газар биш.

Тэгэхээр Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө Гэр бүлийн шүүхийнхээ шүүхдээ өөрийнхөө байрыг өгөөд өөрсдөө хаана ч суусан яадаг юм. Тэр Сонгинохайрхан дүүргийн захад байсан ч болно шүү дээ. Энэ чинь оффис юм чинь. Нэг ийм шийдэл байвал яасан юм бэ гэж бодож явдаг юм. Тэгээд хэлэх гэхээр шүүх эрх мэдэлд бас нөлөөлсөн ч бол гээд ч байгаа юм шиг, тулгасан ч болох гээд байгаа юм шиг. Нөгөө гишүүдийг нь байр савнаас нь хөөх гээд ч байгаа юм шиг бол гээд.

Тэгээд би нэгэнт Улсын Их Хурал дээр энэ асуудал яригдаж байгаа учраас би өөрийнхөө саналыг хэлж байгаа юм. Та бүхэн үүнийг болгоож хүлээж аваарай гэдгийг хэлье.

Саяын хэлсэнчлэн Хууль зүй, дотоод хэргийн сайд бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхдийн эрхийн асуудлыг хариуцдаг. Энэ чиглэлээр манай улсад ахиц дэвшил гарч байгаа юу гэвэл гарч байгаа.

2015 онд баталсан 2017 оны 7 сарын 01-нээс үйлчилж эхэлсэн Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Хүүхдийн эсрэг гэмт хэрэг гэдэг бие даасан бүлэг анх удаа хуульчлагдсан юм.

Ингээд хүүхдийн өөрийнх нь холбогдсон болон хохирогч болсон хэрэг учралын асуудлуудыг нэлээн анхаарсан. Хүүхдийн эсрэг, ялангуяа бэлгийн

хүчирхийлэлтэй холбоотой хэргийг. Хэрвээ Та бүхэн санаж байгаа бол би 2023 оны 10 сард Хууль зүй, дотоод хэргийн сайдаар өмнө нь томилогдож байсан. Тэр үед бас нэлээн ноцтой хэргүүд гарч байсан. Ингээд тэр үед Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор хүүхдийн бэлгийн эсрэг гэмт хэргүүдийг Эрүүгийн хуульд чангалах ийм ял шийтгэлийн бодлогыг оруулж ирээд батлуулаад 11 сараас үйлчилж эхэлсэн байдаг юм.

Одоо яг хүүхдийн эсрэг бэлгийн эрх чөлөөнийх нь эсрэг гэмт хэрэг Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хамгийн дээд ялын төрөлдөө тулсан байгаа гэдгийг би хэлэх гэж байгаа юм. Хамгийн дээд ялын төрөлдөө. Одоо үүнээс илүү цааш чангалах тийм хууль зүйн тааздаа бол тулсан. Ял шийтгэлийн бодлого нь хамгийн чанга байгаа гэдгийг би нэдүгээрт хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, зохион байгуулалтын хүрээнд энэ төрлийн гэмт хэргийг шалгах, мөрдөх үйл ажиллагаанд хүүхдээс мэдүүлэг авдаг тусдаа 55 өрөө байгуулсан. Нийтдээ яг хүүхдийн эрхтэй холбоотой хүүхдийн үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах 120 эмэгтэй албан хаагчийг шинээр авч ажиллуулсан. Яагаад гэвэл хүүхдийн хэрэг дээр ер нь мөрдөгч нь бас эмэгтэй албан хаагч байвал илүү зүгээр юм гэж дагнаж мэргэшүүлэх ийм бодлогыг барьж байгаа.

Мөн Дотоод хэргийн их сургууль буюу хууль сахиулахыг сахиулагчдыг бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрт гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг бас бие даасан хэлбэрээр боловсруулж батлаад, үүний дагуу хичээл сургалт бас бие даасан хэлбэрээр ордог болсон гэдгийг хэлье.

2024 онд гэхэд Хууль зүйн туслалцааны төвөөс 8164 иргэнд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлснээс 516 буюу 6.3 хувь нь насанд хүрээгүй хүмүүс байна.

2025 онд 6508 иргэнд хууль зүйн төлбөргүй туслалцаа үзүүлснээс 565 нь буюу 8.6 хувь нь насанд хүрээгүй ийм хүмүүс байна.

Гэмт хэргийн яг гаралт ямар байдалтай байна вэ гэхээр “хүүхдийн эсрэг” болон “хүүхэд үйлдсэн гэмт хэрэг” манай улсын хувьд сүүлийн 2 жилийн статистик мэдээллийг Та бүхэнд үзүүлж байна.

- 2024 онд 2508,
- 2025 онд 3215.

Нийт гэмт хэргээс хүүхэд холбогдсон хэргийг Та бүхэнд харуулж байна.

Хүүхэд өөрөө холбогдсон гэмт хэрэг өмнөх онуудынхаас 17-гоос 18 хувийн бууралттай байна гэсэн ийм тоон мэдээлэл гарч ирж байгаа юм.

Сургуулийн орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн статистик мэдээллийг Та бүхэнд танилцуулъя.

2025 онд бүх шатны боловсролын байгууллагын орчимд 208 гэмт хэрэг, 134 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс –

- ▶ гэмт хэрэг 20 хувиар,
- ▶ зөрчил 11 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа.

Эндээс хамгийн их сургуулийн орчимд үйлдэгдэж байгаа хэргийг Та бүхэн анзаараарай. Нийт гэмт хэргийн дотроо хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг хамгийн ихээр сургуулийн орчинд үйлдэгдсэн байдалтай байна.

Сургуулийн өмчийн хэлбэрийн хувьд төрийн өмчийн хэлбэрийн сургуулиудад энэ төрлийн гэмт хэргүүд илүү их гардаг гэдгийг Та бүхэн тэр хүснэгтээс бас харж болж байна.

Хүчирхийллээс хамгаалах чиглэлд сүүлийн 10 жилд гэр бүлийн Хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш бас нэлээн анхаарч байгаа.

2016 онд би өөрөө дэд сайдаар ажиллаж байсан үе байдаг. Анх томилогдоод ажиллаж байхад манай улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байр улсын хэмжээнд 5 ширхэг байсан. Ердөө 5 ширхэг. Энэ байрнуудыг бусад гадаадын улс орнуудын хүрээнд бас нэлээн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлээд, одоо үр дүнд нь нийтдээ манай улс 39 байртай болсон байгаа.

О.Номинчимэг: Тийм. Б.Энхбаяр сайд ингэх үү? Таны танилцуулгын хугацаа бас нэлээн явсан байна. Хугацаандаа яасан байна.

Б.Энхбаяр: Хугацаатай юм уу?

О.Номинчимэг: Тийм.

Б.Энхбаяр: Ямар хугацаатай юм? Надад хэлээд байна шүү дээ.

О.Номинчимэг: 10 минут.

Б.Энхбаяр: Өө., за за. За уучлаарай.

О.Номинчимэг: Тэгээд дээр нь манай өнөөдрийн хэлэлцэх ёстой асуудал бол энэ үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой байгаа.

Б.Энхбаяр: Би тэгвэл танилцуулгаа товчлоод дуусгая даа.

Одоо нийтдээ 39 түр хамгаалах байр байгаа. Ер нь түр хамгаалах байрны асуудлыг улсын төсвийн хөрөнгөөр шийдэж байгаагүй шүү. Үүнийг бас Та бүхэн

маань анхаараарай. Дандаа гадаад улсын буцалтгүй зээл, тусламжийн хүрээнд энэ түр хамгаалах байруудыг барьж ажиллуулж ирсэн гэдгийг бас Та бүхэн маань бодоорой.

Төсөв хөрөнгийн хувьд сая Т.Аубакир сайд хэллээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад хүүхэд хамгаалал, урьдчилан сэргийлэх чиглэлтэй холбоотой төсөв 2024 оноос эхлээд байхгүй болсон. Үүнийг хүүхэд, гэр бүл нийгмийн хамгааллын харьяа байгууллага руу шилжүүлсэн байдаг гэдгийг Та бүхэнд бас хэлье.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ажлуудыг сая Нийгмийн хамгааллын яам, Боловсролын сайдын танилцуулга, мэдээлэлд танилцуулсан учраас ингээд товчилъё. Баярлалаа.

О.Номинчимэг: Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр сайдад баярлалаа.

Өнөөдрийн энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны хуралд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Д.Гантулга Боловсролын дэд сайд, Ж.Хунан Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Ц.Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга, Б.Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Л.Төгсбаяр Боловсролын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга, А.Халиунаа Боловсролын яамны Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга, Т.Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга, Б.Баярсайхан Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын дарга, Ж.Буянбат Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Л.Бадамцэцэг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Ц.Үүрцайх Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын дарга, Г.Ойнбаяр Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Батзориг Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Д.Будзаан Цагдаагийн ерөнхий газрын урьдчилан сэргийлэх албаны Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Ж.Азжаргал Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч, С.Пүрэвсайхан Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч нар оролцож байна.

Өнөөдөр оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцууллаа.

Тэгэхээр бүгдээрээ мэдэж байгаа. Өнөөдрийн энэ гол асуудал үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой, үүнийг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбоотой, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт ямар түвшинтэй байна,

цаашид бид юун дээр анхаарах ёстой байна гэдэг мэдээллийг сонсож хэлэлцэж байгаа.

Улсын Их Хурлын даргаас Улсын Их Хурлын үйл ажиллагааг Хүүхэд хамгааллын, хүүхдийн эрхийн жил болгож зарласан.

Тэгэхээр бид гол нь баахан хууль батлаад байдаг. Амьдрал дээрээ энэ чинь үр нөлөө үзүүлж байна уу гэдэг дээр, хуулийн хэрэгжилт дээр ч гэсэн манай Өргөдлийн байнгын хороо энэ хаврын чуулган дээр анхаарч ажиллахаар байгаа.

Тэгээд энэ хүрээнд энэ мэдээллийг сонсож байна.

Ингээд Хүүхэд хамгааллын тухай хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн талаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын дэд сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ бүртгүүлнэ үү.

Ж.Галбадрах гишүүнээр, нийт 9 гишүүнээр тасаллаа.

Одоо ирцийн дагуу Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Маш чухал асуудлуудыг өнөөдөр хэлэлцэж байна. Гурван яамнаас байна.

Бүгдээс нь нэгтгээд асуугаад л явъя даа. Тэгээд өөр өөрсдийнхөө харьяалсанд нь хариулаад явчхаарай. Товчховтор.

Энэ нэмэлт мэдээллээс харагдаж байгаа нэг хэд хэдэн зөрчилтэй юм шиг санагдаад байна л даа. Надад дуудлагын тоо гэдэг нь их л бодит хэмжээг илэрхийлсэн юм уу? Энэ чинь Монголд 1.28 сая сурагч байна. Тэрнээс 2300-хан кэйс гэнэ ээ. Статистикийн хувьд бодоод үзэхэд энэ маш бага байгаад байна.

- Яах вэ, ямар тайлбар байгаа юм?
- Энэ бодит хэмжээ нь байгаа юм уу?
- Ер нь дутуу бүртгэгдээд байгаа юм уу?
- Мэдээлэл систем чинь ажиллахгүй байгаа юм уу гэдэг дээр.

Тоо бодитой байх юм бол бид дээр зөв шийдвэр гаргаж, зөв арга хэмжээ хэрэгжүүлэх учраас энэ дээр нэг тодорхой хариулмаар байна.

Нийт 108 утсанд 2300 дуудлага бүртгэгдсэн гээд сая хэлэх шиг боллоо. Нийт тохиолдлын тэгвэл энэ нь хэдэн хувьдаа орж байгаа юм гэдгийг нэг хэлээд өгөөч.

Тэгээд сургууль дээр гарч байгаа дээрэлхэлтийн ер нь албан бүртгэл гэж юм байгаа юу? Тэр нь бас хэд вэ гэдгийг мэдвэл сайн байна.

Энэ бас нэг сэтгэл эмзэглэмээр. Энэ бас дата нь үнэн юм уу, худлаа юм уу?

77.8 хувь нь бие махбодын хүчирхийлэл гээд сая ярих шиг болох юм. Тэр нь бие махбодын хүчирхийлэл юм бол энэ чинь аягүй аймаар тоо байна шүү дээ. 78 хувь. Уг нь олон улсад нөгөө “буллинг” (Bullying)¹ буюу энэ чинь үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл зүйгээр доромжлох, нийгмээр тусгаарлах энэ тэр гээд ихэвчлэн тийм юм байдаг. Энэ чинь биеийн гэхээр чинь бүр гэмтэл согог, юу билээ, органик өөрчлөлтүүд өгч байна гэсэн үг шүү дээ.

- 77.8 хувь нь бие махбодын хүчирхийлэл гэж гарсан нь үнэн үү?
- Ямар дата дээр энэ эх сурвалжаа үндэслээд байгаа юм бэ?
- Хэрвээ үнэн бол эрүүгийн шинжтэй хэрэг болсон гэж тооцогдсон кэйс байгаа юу?
- Байгаа бол хэдэн хувь юм?
- Тийм бол сургууль дээр гарсан ийм хэрэгт хариуцлагад нь яг хэн тооцогдсон юм?

Сая ярьж байхад харахаар зэрэг 2023 оны нэг судалгаа гарч ирж байна. 23 хувь нь бие махбодын халдлага гэсэн байна. Яг аль нь үнэн зөв юм бол? Тэрийг нэг ялгаад салгаад датагаар нь нэг эцэслээд өгөөч.

Хэрвээ үнэхээр 78 хувь бол сая Гэр бүлийн сайдын сайдын ярьж байгаагаар хооронд нь координаца хийж уялдааг хангана гэж ярьж байна шүү дээ. Эрүүл мэндийнхээ яамыг оруулж ирэхгүй юм уу? Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн энд байх ёстой юм биш үү? Эмнэлэг тусламж, үйлчилгээний бараг аягүй том burden_[ачаалал, дарамт, хүндрэл] буюу нийгэм, эдийн засаг буюу нийгмийн эрүүл мэндийн, нийгэм, эдийн засгийн гол хүчин зүйл гэж яриад байдаг юманд чинь яг иймэрхүү асуудлууд орж бодлоготойгоор, уялдаатайгаар салбар тус бүрд нь ажиллаж байж ийм цахим дээрэлхэлт, эдгээр асуудлуудыг бүгдийг шийдэх боломжтой болдог.

Тэгэхээр энэ дээр бүрэн хариулт авмаар авмаар байна.

Ер нь цаг бага байна. Түүнээс биш ахиад хоёр, гурван асуулт байгаад байх юм. Энэ дээрээ хариулт авчих уу? Эхлээд.

О.Номинчимэг: Тэгье. Хэн хариулах вэ? Тоо баримтууд, гарсан танилцуулга дээр гарсан тоонуудаас асууж байна. Гараа өргөөрэй.

4 номер. Боловсролын дэд сайд Д.Гантулга сайдын микрофоныг өгье. 4 номер.

Д.Гантулга: Баярлалаа. Д.Ганмаа гишүүний асуултад хариулъя.

¹ Бусдыг санаатайгаар, давтамжтайгаар дээрэлхэх, дарамтлах, доромжлох зан үйл.

Яах вэ, дуудлага ирсэн гэдэг нь бодвол Б.Энхбаяр сайдын танилцуулга дээр гарсан болов уу гэж бодож байна.

Боловсролын яамнаас өгч байгаа танилцуулга дээр 2024-2025 оны хичээлийн жилийн сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний тайлан гарсан байгаа. Энэ тайланг хуулийн дагуу маягтаар сургууль бүрээс өөрсдөөр нь бөглүүлж авдаг ийм тайлан.

Энэ тайланд ерөнхий боловсролын 886 сургуульд хүүхэд хамгааллын бодлогыг мөрдөж, 7939 хүүхэд хамгааллын багийн гишүүд ажилласан.

Эрсдэлийн үнэлгээнд 748378 суралцагчийн 58055 буюу 7.8 хувь нь “дунд”, “өндөр” эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Үүний 16117 суралцагч нь үе тэнгийн дээрэлхэлтэд өртсөн гэсэн. Энэ нь өөрөөр хэлбэл нийт суралцагчдын 2.1 хувь нь. Ийм бодит тоон мэдээлэл бидэнд байгаа.

О.Номинчимэг: 7 номер. Гэр бүл хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан.

Б.Баярсайхан: Өдрийн мэнд хүргэе. Д.Ганмаа гишүүний асуултад нэмж хариульъя.

Манай 108 хүүхдийн дуудлагын утсанд жилдээ 110-аад мянган дуудлага ирж байгаа. Энэ нь ерөнхийдөө Цагдаагийн ерөнхий газар ирж байгаа нийт дуудлагадаа бараг дөхөж очдог.

Тэгэхээр хүүхдийн хүчирхийллийн дуудлага ямар өндөр байгааг бид эндээс харж болно.

2024-2026 оны хооронд яг үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалттай холбоотой 2300 дуудлага ирсэн. Үүний –

- 69.5 хувийг боловсролын орчинд,
- 21.1 хувийг олон нийтийн арга хэмжээн дээр,
- үйлчилгээ, гудамж талбайн орчин 8.9 хувийг,
- гэр бүлийн орчин 0.4 хувийг,
- хэвлэл мэдээлэл, цахим орчин, эрүүл мэнд, хүүхэд хамгааллын үйлчилгээний орчинд үлдсэн хувь нь эзэлж байгаа гэсэн статистик байгаа.

Үе тэнгийн дээрэлхэлтэд өртөж байгаа хүүхдүүдийн 1791.../минут дуусав/

О.Номинчимэг: 7 номер гүйцэж хариульъя.

Б.Баярсайхан: 77.8 хувь нь бие махбодод халдсан гэдэг статистик байна.

Тэгэхээр “бие махбод” гэдэг нь гадна талд нь бие махбодод органикаар гэж сая Д.Ганмаа гишүүн хэлж байгаа боловч яг үнэндээ одоогийн хүчирхийллийг

“гадна” болон “дотор тал” гэж хөнгөрүүлэх, хүндрүүлэх учир шалтгаан байхгүй болсон.

Ялангуяа цахим орчинд “буллинг”-дэж байгаа, гадуурхагдаж байгаа энэ асуудал бол яг тэр сэтгэц рүү нь, эрүүл мэнд рүү нь, яг тэр тархи руу нь, ходоод руу нь, дотоод эрхтэн рүү нь өөртөө итгэх, хүн байх тэр үнэ цэн рүү нь халдаж байгаа ийм халдлага байгаа юм.

Тэгээд хамгийн гол нь өгөгдөж байгаа энэ дуудлагууд, үе тэнгийн дээрэлхэлт, гадуурхалтын асуудлыг өнөөдөр Өргөдлийн байнгын хороогоор хэлэлцэхдээ яг уг углуургаар нь шийдэл нь юу байна вэ гэдгийг бас гишүүдийг асууж, энэ асуудлыг нэлээн... /минут дуусав/

О.Номинчимэг: Д.Ганмаа гишүүн тодруулах уу? Тодруулъя.

Д.Ганмаа: Саяын асуултад ингээд эргээд асуух юм бол өчнөөн асуудал байна л даа.

- 77.8 хувь нь яг “үнэн” гэж хариулж байна гэж ойлголоо.
- Түрүүний тэр тоо 2300 кэйс ч гэсэн “үнэн” гэж ойлголоо.
- 69.0 хувь нь боловсролынхтой холбоотой гэж ойлголоо.

Ингээд “бие махбод” гэдэг чинь уг нь сэтгэл зүй, үгээр доромжлох, нийгмээс тусгаарлах тусдаа учраас энэ чинь бүр органик өөрчлөлт байхаар бүр категори нь өөр асуудал шүү дээ.

Тэгэхдээ би одоо ийшээгээ орохгүйгээр нарийвчилснаар мэдээлэл авах нь зүйтэй байх. Зүгээр нөгөө үлдсэн хэдэн асуултдаа хариулт авмаар байна.

Одоо ингэж байна шүү дээ. 2016 он билүү, 2017 он. Хэдэн онд билээ. Хууль батлагдсан чинь. Хүүхдийн.

Энэ дээр тэгэнгүүт яахаараа энэ журам нь одоо хүртэл батлагдахгүй 10 жил болчихоод одоо л дөнгөж батлагдах тухай яриад байгаа юм. Тэгээд 69 хувь нь “боловсролын түвшинд” юм энэ асуудлыг сургууль хамгийн эрсдэлтэй орчин гээд гаргаад ирж байна шүү дээ. Тэгэнгүүт яагаад баахан бид сая гэр бүлийн яамнаас аян, сургалт, семинар юу юу гэххэв дээ. Баахан тийм постер, видео. Тийм юм... /минут дуусав/

О.Номинчимэг: Нэмэлт 1 минут.

Д.Ганмаа: Яг бодит системийн арга хэмжээг сонсмоор байх юм. Хэт их аян ярихгүйгээр.

- Сургуулийн дотоод хяналт нь ямар юм?
- Сахилгын систем нь байгаа юм уу?
- Эрт илрүүлэг явж байгаа юм уу?

- Мэдээллийн системтэй юм уу?
- Саяын ярьж байсан юмнууд нь хоорондоо нэгдсэн датабааз байгаа юм уу?

Түүн дээрээ харж байж бид дараа дараагийнхаа интервенцийг яривал уг нь зүгээр санагдаж байна. 10 жил өнгөрөөд журам нь батлагдаагүй санагдаад байна.

Дээрээс нь Л.Энх-Амгалан гишүүний ном дээр байсан шүү дээ. Нөгөө ажилладаг сэтгэл зүйчдийг авсан чинь бүр өөрсдөө сэтгэл зүйн юу авахгүй бол асуудал нь аягүй хүнд байна гээд.

Тэгэхээр манайхыг ингээд сая кэйсийг нь тоолоод үзсэн чинь нэг сэтгэл зүйчид бараг 700 хүүхэд хамрагдаад байна шүү дээ. Та хэдийн өгсөн тоогоор.

- Энэ тэгээд олон улсынх нь хэд байдаг юм?
- Хэд байвал сэтгэл зүйчид сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлтийг бууруулахаар ажиллах чадвартай юм? Боломжтой юм?
- Мэдээж мөнгө төгрөг, санхүүжилт дутагдалтай байх. Энэ нь ямар юм?
- Энэ 290 сургалт гэдэг нь бодит үр дүнгийн хэмжүүр үзүүлэлт эцсийн эцэст байгаа юм уу?

О.Номинчимэг: Яах вэ, үе тэнгийн дээрэлхэлт юунаас болж гараад, хэчнээн энд аян хийж байгаа боловч учир шалтгааныг нь бид тодорхойлж нэг салбарын гэхээсээ энэ чинь олон салбарын хамтын ажиллагааны уялдаа байх ёстой. Энэ дээр ч гэсэн бас анхаарах үүднээс л бид өнөөдөр энэ мэдээллийг сонсож байгаа.

- Хуулийн хэрэгжилт маань ямар түвшинд байна.
- Юу нь болохгүй байна.
- Яах ёстой юм гэдэг дээр.

Нэмэлт асуултад хэн хариулах вэ? 6 номер. Т.Ням-Очир дарга. 6 дугаар микрофон.

Т.Ням-Очир: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгэхээр 2022 оноос эхлээд боловсролын салбарт “боловсролын сэтгэл зүйч”, “хоол зүйч” гээд хүүхдийнхээ сайн сайхан байдлыг хангах багийг шинээр бүрдүүлж, боловсролын сургалтын орчинд хүүхэд хамгааллын баг ажиллахаар ийм зохицуулалт хийсэн.

2024 оноос эхлээд хүүхэд хамгааллын зардлыг сургуулийн хувьсах зардалд нь төлөвлөж нийт хувьсах зардлын 0.3 хувийг хүүхэд хамгааллын зардалд зарцуулаад явж байгаа.

Яг энэ үйл ажиллагаатай холбогдуулаад 2022-2023 оны хичээлийн жилээс эхлээд ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын үйлчилгээний тайланг албан ёсны маягтын дагуу авч, дэд сайдын гарч байгаа энэ тоо баримтуудыг албан ёсны маягтын дагуу бүртгэж, үүнийхээ дагуу хариу арга хэмжээнүүдийг авч ажиллаж байгаа юм.

Тэгээд энэ хүрээндээ хүчирхийлэл болон эрсдэлт нөхцөлд... /минут дуусав/

О.Номинчимэг: Нэмж хариулах уу? Гол хэлмээр байгаа юм байгаа юу? 6 номер уу? Нэмээд хариулъя.

Т.Ням-Очир: Хамгийн гол хэлэх гээд байгаа зүйл бол хүчирхийлэл болон эрсдэлт нөхцөлд орсон суралцагчдад шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг хүүхэд хамгааллын баг зохион байгуулж эхлээд, тухайн хичээлийн жилд 2024-2025 оны хичээлийн жилд 85684 сурагч эрсдэлт нөхцөлд байна гэдгийг тогтоогоод энэ нөхцөл байдлынхаа үнэлгээг хийгээд цаашаа “кэйс менежмент”, “нөхөн сэргээх” үйл ажиллагааг боловсролын сургалтын байгууллагын хүүхэд хамгааллын баг, сэтгэл зүйч нийгмийн ажилтан хийгээд явж байгаа гэдгийг албан ёсоор хэлье гэж бодож байна.

О.Номинчимэг: Баярлалаа. Лувсанбямбагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: Энэ өдрийн мэнд хүргэе. Бид нарт авч хэрэгжүүлсэн үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл гээд ойлгомжтой мэдээлэл бэлдэж өгсөн байна.

Хууль зүйн яамнаас танилцуулга байна. Ажил хийгээгүй биш хийгээд л байгаа юм байна. Нөлөөллийн ажлыг яг ингэж л хийнэ. Тэр аян зохиох ёстой, постер гаргах ёстой, сургалт семинар хийх ёстой. Ялангуяа энэ “Найз” хөтөлбөр маш их таалагдаж байна. Тэгсэн хэр нь энэ дээрэлхэлт чинь буурахгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр авч байгаа арга хэмжээг би буруу гэж бодохгүй байна. Өшөө нэмэх ёстой юм уу. Та нар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг чинь уншсан л даа. Тэр нэг утсанд ерөнхий боловсролын багш нар шууд дата юуг нь авдаг болохоор ямар өөрчлөлт гарах юм гэдгийг нэг их сайн ойлгосонгүй. Тэрэнд хариулж өгөөч.

Дээрээс нь надад зүгээр ийм санал байна. Хууль зүйн сайд аа. Энэ үе тэнгийн дээрэлхэлт чинь одоо харгис гэмт хэргийн шинж чанартай болоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол ирээдүйн харгис гэмт хэрэгтнүүд бэлтгэгдэж байна гэсэн үг.

Тэгэхээр бид одоо арга хэмжээ авахгүй бол оройтсон хойно нь дахиад гэмт хэрэгтэн энэ нийгэмд төрөн гарах магадлалтай байгаа.

Тэгэхээр одоогоор Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүүхдийн ялыг хойшлуулдаг шүү дээ. Түүн шиг үүнийг эрүүгийн хэрэг болгоод. Зөрчлийн хэрэг биш шүү. Үүнийг эрүүгийн хэрэг болгоод тэгээд насанд хүрсэн хойно нь ялыг нь эдлүүлдэг. Харж хандах ёстой үүргээ биелүүлээгүй, сурган хүмүүжүүлж чадаагүй эцэг, эхэд нь мөнгөн торгууль Зөрчлийн хуулиар оноодог. Тийм болохгүй бол зүгээр их дээд сургуульд орох эрхийг нь хасаад хэрэггүй шүү дээ. Одоо харж байгаа биз дээ. Дандаа эрх мэдэлтэй, мөнгөтэй албан тушаалтны хүүхдүүд ийм хэрэг голдуу үлдэж байна. Эд нар Монголын их дээд сургуульд сурахгүй байхгүй юу. Зүгээр инээгээд л явна. Тэгээд анзаараад байхад, хүүхдүүдээс мэдээлэл аваад байхад инфлюсер голдуу охидууд энэ хэргийг үйлдэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид энэ дээр дорвитой арга хэмжээ авмаар байна. Дээрээс нь сэтгэл зүйчид одоо яг бүх сургуульд байгаа юу? Сэтгэл зүйчид маань өөрсдөө бас сэтгэл зүйн асуудалтай байгаа юу?

Тэгэхээр сэтгэл зүйчид маш их хэрэгтэй санагддаг юм.

Тэгэхээр энэ үе тэнгийн дээрхлэлтийг хөнгөн, хүнд юугаас нь шалтгаалаад гэмт хэрэг болгоод Эрүүгийн хуулиар шийдвэрлэвэл ямар вэ гэж асууя. Хууль зүйн сайдаасаа.

Түрүүчийн асуултад манай хүүхэд хамгаалах газрынхан хариулаад өгөөрэй. Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Бид 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлаад, гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон шийдвэрлэж 10 жил явж байна.

Мэдээж ял шийтгэлийн бодлогыг чангатгах, шинжийг тодорхойлох энэ асуудал бол мэдээж нэлээн шинжлэх ухааны үндэстэй хандах учиртай. Ялангуяа Эрүүгийн хуульд.

Одоо энэ “**үе тэнгийн дээрэлхэлт**” гэдэг ерөнхий хэллэг дотор бие даасан тухайн үйлдэл, хохирлын хэр хэмжээ, үйлдлээрээ бол олон төрлийн гэмт хэргүүд байна.

Заналхийлэх, бусдын бие махбод сая хэлсэнчлэн дийлэнх нь хөнгөн гэмтэл санаатай учруулах гэдэг зүйл ангиар ял шийтгэгддэг. Энэ зүйл анги торгох, нийтийн алба хаших, зорчих эрхийг хязгаарлах гэсэн ийм ял шийтгэлтэй.

Манай Эрүүгийн хуулийн үндсэн зорилго цээрлүүлэх, хүмүүжүүлэх, урьдчилан сэргийлэх гэсэн гурван үндсэн зорилгыг агуулж байдаг. Мэдээж төр хатуудаа хатуу, зөөлөндөө зөөлөн бодлогыг барьдаг.

Хүүхдийн тухай ярьж байгаа гэдгийг бид их сайн ойлгох ёстой. Өөрөөр хэлбэл эрх зүйн бүрэн чадамжгүй, төлөвшөөгүй гэх юм уу. Одоо өөрийн үйлийн хор уршиг, үүнээс гарах үр дагаврыг бүрэн ухамсарлах тэр хэр хэмжээнд ухаан санаа, уураг тархи нь бэлтгэгдээгүй хүмүүсийн тухай ярьж байгаа.

Тийм учраас үүнийг нэлээн тооцоо судалгаатай ярих байх гэж би хэлж байна. Би яаран таны асуудлыг шууд эрүүлжүүлье, алаад өгье, хядаад өгье гэж би хэлж чадахгүй. Болгоомжтой хандах ёстой. Тооцоо судалгаатай хандах ёстой.

Үүний шалтгаан нөхцөл гэж ярих юм бол ганц тэр хүүхдийн буруу гэхээс гадна энэ үйлдэлд нөлөөлж байгаа нийгэм, эдийн засаг, хувь хүн, хүчин зүйлүүдийг бид цогцоор нь авч үзэх ёстой. Жишээлбэл, 2011 онд эдийн засаг 17 аравны хувьтайгаар өсөж байх үед танхай, хулгайн гэмт хэргүүд огцом буурсан. Эдийн засгийн өсөлт хэр хэмжээгээр хүмүүсийн тэр бие, сэтгэл зүй, энэ байдал бол их тийм тайван байдаг. Бас нөгөө талаар хүндрэх хэрээр хүмүүс их тийм бухимдалтай байдаг. Ялангуяа цахимжилтын үе дээр би нэг судалгаа хэлье. 2025 оны 12 сард манай улсын цахим орчин дахь байдлыг гадаад улсын төрийн бус байгууллага дүн шинжилгээ хийж, дүгнэлтээ гаргасан байгаа.

Энэ дүгнэлтээр Монгол Улс цахим хэрэглээгээрээ хамгийн өндөр эрсдэлтэй улсад тооцогдсон. Энд фэйсбүүкийг шууд интернэт гэж 90 хувь нь ойлгодог. Цахим орчинд явж байгаа мэдээлэлд гуравны хоёр нь ямар ч дархлаагүйгээр шууд итгэдэг. Шууд итгэдэг. Худал мэдээлэлд. Ямар ч дархлаагүй. Гуравны нэг нь ямар байж болох вэ гэдэг дээр арай жоохон бодож үздэг.

Тэгэхээр бид хүүхдийн цахим орчны хэрэглээн дээр ямар нэгэн хязгаарлалт, хориг саад байхгүй. Аллага, хүчирхийлэл, хар тамхи, гэмт хэрэг, янз бүрийн хараал зэлгийтэй хүүхэд шууд орж... /минут дуусав/

О.Номинчимэг: Л.Мөнхбаясгалан гишүүний цаашид хэрэгжүүлэх санал болгосон ажлын талаар. 5 номер. Нэрээ хэлээд хариулаарай.

Ц.Алтансор: Сайн байцгаана уу? Ц.Алтансор. Боловсролын сайдын зөвлөх. “Аюулгүй сүлжээ” үндэсний загварын зохицуулагч байна.

Ерөнхийдөө Боловсролын яамны зүгээс бидний ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байгаа нэг зүйл бол “Аюулгүй сүлжээ” үндэсний загвар юм.

Өмнө нь манай холбогдох яамдын гаргасан мэдээллүүд, мөн гишүүдийн гаргаж байгаа саналуудтай бүрэн санал нийлж байна. Яагаад гэхээр хэдий бид өнөөдөр хүүхэд хамгааллын бодлого, хууль тогтоомж, чиглэл гээд үе үеийн сайд нарын чиглэл байдаг боловч яг газар дээрээ энэ өөрөө хэрэгжихгүй байгаад байна.

Өнөөдөр нийт эцэг, эхчүүдийн 67 хувь нь бие махбодын хүчирхийлэл буюу бие махбодын шийтгэлийг зөв гэж үздэг. Багш нарын 15 хувь нь бие махбодын шийтгэлийг бас зөв гэж үздэг гэх мэтчилэн ийм асуудлууд байна.

Тэгэхээр энэ ерөөсөө хүүхдийн асуудал гэхээсээ илүү нөгөө томчууд, бид нарын үлгэрлэж байгаа, хүүхдэдээ авч байгаа арга хэмжээний... /минут дуусав/

О.Номинчимэг: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: Б.Энхбаяр сайд аа, би учиргүй хүн амьтан алаад, хядаад өг гээгүй л дээ. Та буруу шууд орчуулж ойлгоод байна.

Би энд санаатайгаар хүнийг харгисаар дарамталж байгаа ийм хүүхдүүдийн тухай ярьж байгаа шүү. Түүнээс биш зүгээр нэг хүүхдийн гэнэн цагаанаар хийсэн алдаан дээр нь дөрөөлөх гээгүй.

Зохион байгуулалттайгаар, санаатайгаар, бүлэглээд, харгислаад ийм хэрэг хийгээд байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр хэрвээ тэд нарт ял өгөөд ялыг нь хойшлуулж байгаад насанд хүрэхээр нь эдлүүлж болно шүү дээ. Үүнийг би зүгээр одоо хийгээд өг гэж байгаа юм биш. Энэ ямар байна гэж танаас асуусан болохоос хүн алж хүрээ талаад өг гэсэн асуулт би тавиагүй ээ.

Дээрээс нь энэ үе тэнгийн дээрэлхэлт чинь 16-аас дээш насныхных нь буюу 14-өөс доош насныхан гэж хоёр хуваагдаад байна. Энэ хүмүүс насанд насанд төрөхээрээ дахиад гэмт хэрэг үйлдэж байна шүү дээ.

Тэгээд мөнгөтэй баян дарга, цэрэг, албан тушаалтай хүний хүүхдүүд хүн зодоод гэмтээхээд тэгээд л хилийн хориг жоохон тавиулж байгаад л торгуулаад л салаад байдаг байж болохгүй шүү дээ. Тэд нар чинь... /минут дуусав/

О.Номинчимэг: Б.Энхбаяр сайд. Хууль зүй, дотоод хэргийн сайд.

Б.Энхбаяр: Би тооцоо судалгаатай сайн хандах учиртай л гэж байгаа юм.

Энэ үйлдэл ямар нэгэн ял шийтгэлгүй биш.

— “Заналхийлэх” гэж гэмт хэрэг байгаа.

— Бусдыг “амиа хорлоход хүргэх” гэж гэмт хэрэг байгаа.

— “Танхай” байгаа.

Бусдын бие махбод гэмтэл учруулбал гэмтлийн зэргээрээ бас ял шийтгэгддэг.

— Хөнгөн гэмтэл,

— хүндэвтэр гэмтэл,

— хүнд гэмтэл учруулах гэдэг нь бүх зүйл ангиудаараа байгаа.

Үүнийг бие даасан хэлбэрээр жишээлбэл яг “үе тэнгийн дээрэлхэлт” гэж тусдаа нэг гэмт хэрэг энэ гэмт хэргүүдтэйгээ ял шийтгэлийн бодлого нь яаж давхцаж явах вэ, бусад улс орны ийм туршлага байна уу гэдгийг би судалж үзэж ярих ёстой гэж байгаа юм.

Ер нь би хүүхдийг шоронжуулах бодлогын эсрэг байдаг. Энэ бодлогынхоо хүрээнд ч гэсэн өмнө нь бас Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд байхдаа эрүүгийн... /минут дуусав/

О.Номинчимэг: Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

Л.Мөнхбаясгалан: Та мушгиад байх юм. Ямар сонин юм. Хүүхэд шоронжуулах бодлого алга. Би таныг ямар хүүхэд шоронд хийгээд өг гэсэн юм уу.

Насанд хүрсэн хойно нь. Энэ чинь үе тэнгийн дээрэлхэлт гээд бүр гэмт хэрэг гарч ирээд байна шүү дээ. Больё доо.

Би тэр хүүхэд хамгааллын газраас асуух гээд байна. Тэр сэтгэл зүйчид байгаа юм уу? Сэтгэл зүйчид ер нь хэр хүрэлцээтэй байдаг юм? Сургууль дээр.

Миний бодлоор сэтгэл зүйчид маш их хэрэгтэй санагддаг. Тэгээд түрүүн тэр нөгөө утасны датаг шууд авах буюу шууд холбогдохоор ямар өөрчлөлт гарах ёстой юм бэ? Одоо тэгээд ер нь юу хийвэл энэ төрлийн хэргийн тоог нь ядаж бид багасгаж барьж чадах вэ?

О.Номинчимэг: Сэтгэл зүйчдийн асуудал. 6 номер. Т.Ням-Очир дарга

Т.Ням-Очир: Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя.

2021 оноос эхлээд боловсролын салбарт, тэр дундаа ерөнхий боловсролын сургуульд боловсролын сэтгэл зүйчийг ажиллуулж эхэлсэн.

2025-2026 оны хичээлийн жилийн 9 дүгээр сард албан ёсоор статистик мэдээгээр 496 сэтгэл зүйч ерөнхий боловсролын сургуулиудад ажиллаж байна гэсэн ийм албан ёсны статистик тоо гарсан.

Өнөөдрийн байдлаар ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа сэтгэл зүйчийн тоо 580 хүрсэн. Дээрээс нь цэцэрлэгт сэтгэл зүйч ажиллаж эхэлж байгаа. Энэ ойролцоогоор 50 орчим сэтгэл зүйч ажиллаж байгаа гэсэн ийм тоо баримт байгаа.

3 сургууль тутмын 2-т нь сэтгэл зүйч ажиллаж байгаа.

Нийслэлийн хувьд сэтгэл зүйч бол бүрэн хангагдсан.

О.Номинчимэг: 6 номер. Сэтгэл зүйчдийн хүрэлцээний асуудлаар бодлого.

Т.Ням-Очир: 2025 оноос эхлээд яг боловсролын сэтгэл зүйчийг Монгол Улсын Боловсролын их сургууль дээр албан ёсоор бэлтгэж эхэлсэн.

Тэгэхээр одоо яг боловсролын сэтгэл зүйчид хүрэлцээтэй бэлтгэгдэж эхэлж байгаа. Хамгийн гол нь хөдөө орон нутаг, алслагдсан байршлууд дээр очиж ажиллах, тэндээ тогтвор суурьшилтай ажиллах асуудал хүнд байгаа. Бусдаар сэтгэл зүйчид хүрэлцээтэй бэлтгэгдэж эхэлсэн.

О.Номинчимэг: 7 номер. Шинээр арга хэмжээ авах гэж байгаа. Энэ ямар нөлөө үзүүлэх вэ гэсэн асуулт байсан. Тийм ээ. Б.Баярсайхан дарга. 7 номер.

Б.Баярсайхан: Л.Мөнхбаясгалан гишүүн сая шийдэл асууж байна.

- ▶ Ерөөсөө гол шийдэл нь бид хүн рүүгээ л хандах ёстой.
- ▶ Хүүхдээ хөгжүүлэх ёстой.
- ▶ Монгол Улсад хүүхэд хөгжлийн бодлого байхгүй Боловсролын яам, Хүүхэд гэр бүл, хөгжил, хамгааллын ерөнхий газар, Соёлын яам, бусад яамдууд хамтран ажиллах ёстой.

Сая хамгийн сүүлд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хийсэн судалгаагаар хүүхдүүд өөрсдөө хариулахдаа гэр бүл дотор бид нарыг хайхрахгүй байна. Ээж, аав нар маань биднийг юу хийж байгааг мэдэхгүй байна. Ойлголцохгүй байна. Ойлгохгүй байна гэж байгаа.

11 сарын 20-нд зохион байгуулсан хүүхдийн чуулганаар хүүхдүүд бид нарт ерөөсөө бүх орчноос хайр хэрэгтэй байна. Бид нарыг хайхрах хэрэгтэй байна гэдгийг хэлж байгаа.

Тэгэхээр эндээс юу гэж хэлэх гэж байна гэхээр хүний хүмүүжлийн асуудал яригдаж байгаа. Хүүхдийн хүмүүжлийн асуудал, хүнээ хүн болгох асуудал.

Тэгээд боловсролын ерөнхий хуулийн гол зорилгод нь зан чанарын боловсрол ёс суртахуун дээр суурилсан хүн бэлтгэх... /минут дуусав/

О.Номинчимэг: 7 номер. Нэмэлт 1 минут.

Б.Баярсайхан: Хуулиа бид батлаад 3 жил болж байгаа боловч Боловсролын яамнаас өнөөдөр зөвхөн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр л гарч амжиж байна.

Уг нь юу хийх ёстой вэ гэхээр –

- ▷ **Нэгдүгээрт**, хүүхдүүддээ зан чанарын боловсрол олгох хөтөлбөр, агуулга аль хэдийн хэрэгжиж байх ёстой.
- ▷ **Хоёрдугаарт**, багш нарыг хүүхдэд зан чанарын хүмүүжил төлөвшил олгодог, түүний тэдний сэтгэл хөдлөл, тэдний үйл хөдлөлөөр хүүхдүүд төлөвшиж байгаа гэдгийг мэдэж боловсролын салбарт байгаа бүх багш нараа бид зан чанар, ёс суртахууны хичээлд суулгаж мэргэшүүлэх ёстой.
- ▷ **Гуравдугаарт**, эцэг, эхүүдийг хүүхдийнхээ хүмүүжилд анхаарах ажлыг бид бараг хувьсгалын хэмжээнд хийх ёстой байгаа.

Та нар саяхан харсан бол сошиалаар хүүхдүүдийнхээ хажууд “Би нууц амрагтай”, “Би хүүхэдгүй”, “Би гэр бүлгүй” гэж хүүхдүүдтэйгээ ярьж байгаа энэ видео маш олон хандалтыг авч байгаа.

Үүгээр юу харагдаж байна гэхээр ерөөсөө нийтдээ Монгол Улсад гэр бүлийн боловсрол, эцэг, эхийн хариуцлага байхгүй болсоныг харуулж байгаа.

Тэгээд энэ ажил дээр ерөөсөө салбар хоорондын уялдаа холбоо байхгүй байна гээд... /минут дуусав/

О.Номинчимэг: Бид Улсын Их Хурал бодлого гаргадаг. Бодлого гаргагч нараас хүсэж байгаа юм юу байна. Засгийн газар хоорондоо уялдаж ажиллаж үр дүн гаргах юу байна гэдгийг бас ялгаж зааглахгүй бол тэгэх хэрэгтэй байна гээд бид хоёр талаасаа ярих биш, аль нь хаанаа хийгдэх ёстой юм гэдгийг бас сайн ярих ёстой байх. Тийм ээ.

Тэр дата юу чинь юу юм уу, боловсролын газраас юм уу? Тийм ээ. Дата авах гэдэг юуны талаар Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад 5 номер.

Ц.Алтансор: Тийм. Хариу авах арга хэмжээний асуудлыг л би түрүүн үргэлжлүүлж ярих гээд байна л даа.

Яг одоо сая Б.Баярсайхан даргын хэлж байгаатай адилхан бид яг энэ аюулгүй сүлжээгээрээ ерөөсөө бид ийм загвар гаргая. Нэг ёсондоо –

- хууль, эрх зүйн хүрээнд,
- журмын хүрээнд,
- чиглэлийн хүрээнд гэж явахаас илүүтэйгээр –

- ▷ сургуулийн түвшинд бид юу хийж чадах юм бэ;
- ▷ хүүхдийн түвшинд яаж ажиллах юм бэ;
- ▷ эцэг, эхийн түвшин, хариуцлагын асуудлыг яаж ярих юм бэ;
- ▷ мөн үндэсний түвшинд юу хэрэгжүүлэх юм бэ –

-гэдэг ийм 4 үе шаттай, 5 тулгуурт “үндэсний загвар” гарч байгаа.

Энэ загварын хүрээнд нэг ёсондоо хүүхдүүдийн 33 хувь нь сургуульдаа итгэхгүй байгаад байна.

Тэгэхээр сургуульдаа итгэхгүй байхаар тэр хүүхдүүд чинь яаж мэдээлэх юм бэ. Энэ асуудал чинь илрэхгүй байгаад байна. Далд хэлбэрээр явагдаад байна. Яагаад өнөөдөр яригдаж байгаа тоонууд маань зөрүүтэй байгаад байгаа юм бэ гэхээр –

- > мэдээлэхгүй байна,
- > далд хэлбэрт шилжсэн байна,
- > цахим орчинд шилжсэн байна.

Тэгэхээр бид ерөөсөө энэ дээр гараас алдуураад байна гэсэн үг байхгүй юу.

Тэгэхээр цаашид бид үүнийг платформжуулаад, нэг ёсондоо үндсэн нэг сүлжээтэй.

- Цагдаагийн газар нь ч тэр,
- Боловсролын яам нь ч тэр,
- Гэр бүл... /минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер. 1 минут.

Ц.Алтансор: Бүгдээрээ нэг системээс энэ тоонуудаа хардаг, энэ дээрээ ажилладаг ийм системтэй байх ёстой.

Нөгөө талаасаа үе тэнгийн дээрэлхэлтийг өнөөдөр ийм хөнгөн хэлбэрийн дээрэлхэлтээр хүмүүс зарим нь хүлээж аваад байна. Гэтэл ноцтой буюу нэг ёсондоо гэмт хэргийн түвшинд очоод байна. Тэгвэл ноцтой хэмжээнд очвол Хууль зүйн яам нь яаж арга хэмжээ авах юм бэ гэдэг ийм хоорондын бодлоготой зүйл байх ёстой. Энэ нь өөрөө энэ аюулгүй сүлжээний загвар буюу үндэсний “Нэйшнэл фрэймворк” (National Framework) гэдэг энэ агуулгаараа болоод, эргээд үүнийг хэрэгжүүлэх тэр багш, нийгмийн ажилтан, бүх хүмүүс үүнийг ойлгомжтой нэг стандартаар хардаг зүг рүү чиглүүлэх энэ бодлого юм.

Түүнээс биш бүгдээрээ тус тусдаа нэг журам яриад, нэг чиглэл яриад, хэдэн зөрсөн тоонууд яриад суумааргүй байна гэдэг асуудал дээр бид ийм арга хэмжээ аваад ажиллаж байгаа юм.

Тэгэхээр үүнийг Та бүхэнд энэ сонин дээр нэлээн дэлгэрэнгүй байгаа. Цаашаа мэдээллийг хүргээд явна. Нэмэлт асуулт байвал хариулаад явж болно.

О.Номинчимэг: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн.

Нөгөө харгис хэргүүдийн тухай бас асууна. Энэ телевизээр ч гэсэн олон ийм сурвалжилга явж байгаа юм билээ. Үнэхээр сэтгэл эмзэглүүлэн. Гэхдээ бас бид энэ сошиал орчны асуудлыг ер нь хамтад нь авч явахгүй бол үнэхээр шийдэгдэхээргүй ийм гүн гүнзгий юм руу явж байгаа юм байна гэсэн. Гэхдээ эхлээд гишүүд маань асууя. Тийм ээ.

С.Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Өнөөдөр чухал асуудлыг тал талаас нь ярьж байна.

Нэгдүгээрт, би нийт хэргийн 70 хувь нь боловсролын орчинд үйлдэгдэж байна гэж байгаа. Энэ өөрөө нэг зүйлийг хэлээд байна л даа.

Тэгэхээр бид нийгмийн ажилтнуудаасаа авхуулаад л аваад үзэхэд тэр хүмүүс маань яг тэр хүүхдүүдтэй ажиллах орчинд бэлтгэгдсэн тийм хүмүүс байна уу?

Нийгмийн ажлыг сүүлийн үед хэн ч хамаагүй хийнэ гэдэг байдлаар хандаж ирснээс болоод эргээд өөрсдөө нийгмийн ажилтнуудын сэтгэл зүйчид маань өөрсдөө асуудалтай хүртэл ийм асуудал сөхөгдөж байгаа.

Тийм учраас энэ яг сургуулийн орчинд гэхээр яг хаах нь уу? Анги дотроо юм уу? Эсвэл өөр тэр. Сүүлд тэр хэвлэл мэдээллээр харж байхад тэр манай орчин үеийн тэр Шангрила билүү, тэрний нэг буланд бараг хүүхдүүдийг ээлжилж аваачиж хүчирхийлдэг хүртэл тийм орчныг нь бий болгоод тавьсан.

Тэгэхээр энэ бол зөвхөн сургууль гэдэг юм уу, төрийн ажил бишээс гадна хувийн хэвшлийн байгууллагуудад оролцоо, үүрэг нэлээн чухал байна гэдгийг би хэлмээр байгаа.

Гэмтэл согогийн төвд 50 хувь нь бүртгэгддэг гэж байна. Бүр Гэмтэл согогдлын төвд шүү дээ. Жирийн эмнэлэгт, дүүргийн эмнэлэг, өрхийн эмнэлгүүд дээр ийм хэргүүд байхгүйд нь би бүртгэгддэг үү, үгүй юу гэдгийг тодруулж асуумаар байна.

Тэгэхээр эмнэлгээр дамжиж аль хэдийн бэртэл авсаны дараа бүр гэмтэл согог дээр очно гэдэг чинь ноцтой түвшинд очсон ийм хойно л бид мэдээлэл авах нь байна шүү дээ. Гэмтлийн эмч нар мэдээж тэнд процедур нь тэнд байгаа учраас ингээд мэдээлэгдээд байгаа болов уу гэж бодож байна.

Яг үүн шиг магадгүй өөр орчнуудад ийм үйлдэл байхад нь шууд мэдээлдэг, дүгнэдэг ийм системүүдийг бий болгох хэрэгтэй юм болов уу гэдгийг хэлмээр байна.

Цахим орчинд гээд Боловсролын яамнаас асуумаар байна. Бид чинь хүүхдүүдтэйгээ нийлээд л нийгмийн хамаг болох болохгүй янз бүрийн зүйлийг л томчууд нь нийлээд л үзэлцээд л байгаа. Фэйсбүүк гэдэг орчинд л. Үүнийг

хязгаарлах гэдэг асуудлыг Та бүгд маань Боловсролын яамнаас санаачлаад хуулийг нь оруулж ирье гээд байсан. Энэ яг юу болсон бэ? Ямар хэмжээнд шийдэх вэ гэдгийг хэлмээр байна.

Дээрээс нь хүүхдүүд маань хоорондоо яг тодорхой групп, чат юмнууд дээр юу яриад байна вэ гэдэг тал дээр хянадаг, шалгадаг, дүгнэлт өгдөг газар байна уу гэдэг ийм зүйлийг асуумаар байна. Одоо манай цагдаа, хуулийнхан бас хэлэх болов уу.

Мөн дээрээс нь хүүхдийн зуслан, лагерь, секц дугуйлан ийм зүйлүүд дээр бол нэлээн хомсдолтой байгаа. Хүүхдүүд чөлөөт цагаа өнгөрөөх цаг зав бараг хомс байхгүй болчихоод байдаг. Энэ тал дээр манай Хүүхэд хамгаалал сан, улсын төсөв ч гэсэн ийшээ нэлээн анхаарал хандуулах ёстой юм болов уу.

Хууль зүйн сая түрүүн хэллээ. Хүүхдийн шүүхийн байр олдохгүй байна гээд.

Тэгэхээр би бол үүнийг заавал тэр шүүгч нь шүүхийн байр гэх гэхээсээ илүүтэйгээр өөр манай төрийн албанд ийм байр олдохгүй байна. Бүр тэр дарга нарын арын өрөөнүүдийг шахаад нэг ийм хүүхдийн шүүх байгуулах хэмжээний зай талбай гарах байлгүй дээ. Бид нарт.

О.Номинчимэг: 4 номер. Д.Гантулга дэд сайд эхлээд хариулъя. Хариулт 3, 1, 1-ээр явж байгаа. Та бүхэн маань болж өгвөл минутдаа багтаагаад хариулахыг хүсье. 4 номер.

Д.Гантулга: Би товчхон хариулъя.

Сургуулийн орчинд ихээхэн болж байна гэж. Ер нь энэ сургуулийн орчинд үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлыг тэр сургуулийнх нь нийгмийн ажилтан ч юм уу, сэтгэл зүйчид өгөөд тэд нарын ажил гэж орхидог гээд. Энэ ерөөсөө ажиллахгүй байгаа юм.

Тэгэхээр энэ “Аюулгүй сүлжээ” гэдэг маань үндсэн агуулга нь, тухайлбал хүүхдүүд нэг нэгнээ дээрэлхэж байхад бусад хүүхдүүд нь үүнийг та нар үүнийг дэмжиж болохгүй шүү, энэ чинь муухай зүйл шүү гэдэг энэ урьдчилсан нөлөөллийн энэ мэдээг нь хүргэдэг. Мөн бусад эцэг, эхчүүд. Одоо жишээлбэл өөрийнхөө хүүхэд өөр хүүхдийг дээрэлхсэн байвал хүүхдээ өмөөрөөд байдаг. Гэх мэтчилнээр ерөөсөө –

- хүүхдийн түвшинд,
- сургуулийн түвшинд,
- эцэг, эхийн түвшинд,
- үндэсний түвшинд –

-гээд сая С.Эрдэнэбат гишүүний дурдсан тэр социал тавьсан бичлэгээс үүдээд нийгэм маань бас нэг цочоо авч байна.

Тэгэхээр ийм байдлаар маш өргөн хамарсан тэр нэг яриад байгаа үндэсний загвар гээд байгаа үндсэн агуулга нь ийм байгаа юм.

Тэгэхээр бид одоо яг энэ түвшинд нь л ярих хэрэгтэй гэсэн ийм агуулгатай байгаа юм.

Хоёрдугаарт, цахим орчных яг бид бүгдийн, ялангуяа томчуудын өөрсдийнх нь сайн ойлгохгүй хэмжээнд хүүхдүүдэд нөлөөлөөд байна. Тухайлбал, өсвөр насныхан гээд нэг кино байна. “Adolescence”² гээд нэг кино байгаа. Түүн дээр ер нь яг энэ асуудлыг хөндөөд тавьсан. Яах вэ, кино л доо. Тэгэхдээ тэр үндсэн агуулга тэнд нэг бие бие рүүгээ ингэж нэг like дарж байгаа, үзэн ядалт дарж байгаа тэр мессежийг чинь бид шиг томчууд шиг авдаггүй юм байна. Орчин үеийн хүүхдүүд шал өөрөөр аваад. Тэрийг чинь маш гүнзгий хүлээж авдаг юм байна. Яагаад гэвэл тэр нийгмийн харилцаа нь ийм болсон гэсэн.

Тэгэхээр энэ үүдэлтэй үүдэлтэйтэйгээр бид энэ цахим нийгмийн сүлжээ нь дэх энэ хүүхдийн оролцоог хязгаарлах хуулийн төсөл одоо яамдаас санал авч байгаа. Саналууд нь ирэхээр ирэх долоо хоног юм уу, тэрний дараагийн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанд бариад Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барихаар ажиллаж байгаа. Хуулийн явц нь.

О.Номинчимэг: Өөр. Цагдаагаас мэдээлэл гарсан байна лээ шүү дээ. Сурвалжлагч нар хохирогч хүүхдүүдтэй.

Тэгээд драма, юу юу ч билээ. Тийм бүр бүлэг. Хэдэн мянган хүүхдүүдийн групп байдаг. Түүн дээрээ бие биеийгээ үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл санааны дарамтад учруулдаг, худал мэдээлэл бие биеийнхээ тухай тараадаг. Тэгж дээрэлхэлтийн сошиал орчинд явж байгаа, хохирогч нар нэлээн их байхаар. Даанч үе тэнгийнхэн хүүхдийн сэтгэл зүйтэй холбоотой. Тэр болгон наашаа гарч ирж чаддаггүй гээд.

Энэ дээр Та бүхэн маань ер нь хяналт хийж чадаж байна уу? Сая С.Эрдэнэбат гишүүний асуулт. Тийм ээ. Хэн хариулах вэ? Хяналт хийхэд юу хэцүү байна? Яах ёстой гэж бодож байна?

Засгийн газар хоорондын уялдаа холбоотой хийх ажлыг Засгийн газар хийх ёстой. Үнэхээр тийм байвал тэр level-дээ ярих ёстой. Улсын Их Хурлаас бодлогын түвшинд уялдуулах, төсөв мөнгө юу байдаг юм, түүнтэй холбоотой бодлогын шийдлүүд дээр анхаарах ёстой юм байвал Та бүхэн маань нээлттэй бидэнд хэлэх ёстой.

9 номер. Хяналт хийхэд бас бэрхшээлээ ярьж болно шүү дээ. Нэг ийм юм байх. Хуулийн гарц гаргалгаа ч байж болно. Ийм орчин хэрэгтэй байна гэдэг. 9 номер.

² 2025 оны Британи драм (Netflix)

Б.Батзориг: Гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Цагдаагийн байгууллагаас Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар болон бусад байгууллагуудтайгаа хамтран яг энэ Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд хамтран ажиллаж байгаа.

Мөн мэдээ, мэдээллийг байнгын солилцдог.

Түрүүн мэдээлэлд дурдагдсан 108 дээр ирдэг дуудлага мэдээллийг байнгын манай цагдаагийн байгууллагын 102, 107 тусгай дугаарын утасууд мэдээлэл солилцож ажилладаг юм.

Саяын асуултад дурдагдсан сургуулийн орчинд байгаа хувийн, хамт олны, найз нөхдийн цахим хаяг, дотоод группүүд дээр хяналт тавих ажил, арга хэмжээ тухайн групп дээр байгаа хүмүүс, хүүхдүүд өөрсдөө л зохион байгуулахаас биш энэ өөрөө хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон маш олон хууль тогтоомжоор хориглолт, хязгаарлалтууд байдгийг Та бүхэн мэдэж байгаа.

Тэгэхээр цагдаагийн байгууллагаас мэдээ, мэдээллийг... /минут дуусав/

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Яах вэ, хувийн нууц гэдэг талаас нь бид хараад байвал одоо сая О.Номинчимэг даргын хэлдэг янз бүрийн тийм группүүд хүүхдийг өөрийг нь мэдэхгүй татаж оруулж ирээд, тэр дотор нь янз бүрийн “бүлгиддэг”, янз бүрийн зураг, бичлэгийг нь тавьдаг, янз бүрийн байдлаар дээрэлхдэг тийм орчин руу нь тавиад байна л даа.

Тэгэхээр энэ тал дээр нь нөгөө талаасаа хүүхдийн сэтгэл санаа, оюун, амь насаа хорлох, эсвэл бусдыг зодох, гэмтээх ийм зүйл рүү түлхэж байгаа ийм талаас нь хянаж дүгнэлт хийх. Энэ зөвхөн цагдаагийн ажил бол биш шүү. Манай сургуулийн орчны нийгмийн ажилтнууд гэдэг юм уу, ийм хүмүүсийн орчинд хяналт тавьдаг ийм зүйл байна уу?

Бид тэр сошиал орчинд тэр чигт нь хүний эрх гээд хаявал магадгүй 16 нас хүртэлх хүүхдийг фэйсбүүк хаяггүй болгоно гэдэг нь хүний эрхийн зөрчил гэвэл энэ ажил явахгүй. Тодорхой асуудал байгаад байгаа учраас бид энэ тал дээр гэмт хэргийн шинж чанартай болон ийм зүйл рүү бэлтгэгдэх хөрс суурийг нь... /минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер.

Ц.Алтансор: Ерөнхийдөө сургуулийн орчны уламжлалт “бүллинг” гэж буюу дээрэлхэлт маань цахим технологи, сошиал орчин хөгжсөнөөрөө ерөөсөө “цахим бүллинг” гэдэг хэлбэр лүү гүн гүнзгий шилжсэн байгаа.

Тэгэхээр энэ дээр тэр 16 нас хүртэлх хүүхдүүдийг цахим орчин дахь хязгаарлалтын хууль гэдэг зүйл тодорхой хэмжээнд нөлөөлж өгнө.

Хоёрдугаарт, хэдий группүүдийг хаагаад. Тийм ээ. Одоо фэйсбүүк рүү, сошиал медиа руу мэйл бичээд хаалгасан ч гэсэн эргээд маш олон тийм сүлжээнүүд байна. Жишээлбэл, “телеграмм”.

Тэгэхээр хүүхдүүд буцаагаад телеграммд хүртэл групп нээгээд энэ асуудлууд хийгээд явж байгаа юм.

Тэгэхээр хувийн тэр зураг хөрөг, нүцгэн зураг хөрөг, янз бүрийн зургаар сүрдүүлэг хийж бэлгийн хүчирхийлэл, элдэв янзын дарамт шахалт үзүүлдэг. Энэ нь улмаар сэтгэл зүйн асуудал болоод амиа хорлох хэмжээнд хүргэж байна гэдэг энэ зүйлүүд яригдаж байгаа.

Тийм учраас бид яаралтай 16 насны хүүхдийн сошиал орчин дахь... /минут дуусав/

О.Номинчимэг: Б.Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бүхний тарааж өгсөн сонин дээр хүүхдүүдийн үйлдэл бидний өдийг хүртэл бүтээсэн нийгмийг буцаагаад бидэнд харуулж өгдөг гээд бичсэн байна. Их л зөв бичсэн байна. Энэ дээрээ л анхаарах ёстой л юм шиг харагдаад байгаа юм.

Яагаад хүүхэд гэдэг вэ гэдгээ бид ойлгох хэрэгтэй. Энд хүүхдүүдийн тухай л яриад байгаа юм. Гэхдээ эцэг, эх асран хамгаалагчдын тухай нөлөөллийн асуудлууд огт их яригдахгүй байна.

Өнөөдөр энэ хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой, хүүхдийн үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой асуудлууд сэтгэл зүй, боловсрол, нийгмийн хамгаалал, нэгдсэн бодлогыг л бид нараас шаардаж байгаа юм. Үүнийг л бид хийж чадахгүй байна л гэсэн үг.

Би өчигдөр Цахим харилцаа холбооны сайдтай уулзсан юм. Манай хүүхдүүд бүгдээрээ “Тик ток” үздэг. “Тик ток” дээр кириллээр нэг үсэг бичингүүт тэр чигтээ садар самуун гарч ирж байгаа. Үг, үсгээрээ. Тэгээд үүнийгээ хаагаач ээ. Болохгүй байна. Монгол Улс ямарваа нэг арга хэмжээ авахгүй юм уу гэсэн чинь хуулийг нь баталж байж л бид хаана. Өөр арга байхгүй гэж байгаа юм.

Тэгээд энд томчууд бид өөрсдөө үйлдэл хийхгүй байна гэсэн үг. Томчууд бид өөрсдөө аливаа асуудлыг нэг хэмжээс дээр л хараад байна. Олон хэмжээс дээр ерөөсөө харахгүй байна.

Дотуур байрны асуудал байна. Одоо манай Хөвсгөл аймгийн Дархадын хотгор, Улаануул сум гэр бүлийн хүчирхийллээс улбаатай дотуур байранд нь сумын төв дээр хүүхдүүд ороод ирсэн. Хөөж чаддаггүй. Эргээд ахлах ангийн

хүүхдүүд нэг өрөөнд хувцсаа сольж чадахгүй бие биеэсээ ичсэн байдалтай байж байгаа. Энэ ахиад л бид нарын хийх ёстой ажил мөн үү гэвэл ахиад л мөн байхгүй юу.

Тэгэхээр бидний хийх ёстой ажлууд эцэг, эх асран хамгаалагчийн хийх ёстой ажлыг бид хэзээ хийх вэ? Энэ дээр бодлогын яамд ямар арга хэмжээг авч явах вэ?

Нийгмийн сүлжээ. Сая Б.Баярсайхан дарга хэллээ. Үгүй, тэгээд эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ хажууд –

- “Би эхнэргүй, нөхөргүй”,
- “Би хүүхэдгүй”,
- “Орой уулзъя” гээд яриад яваад байх уу?
- Нийгмийн сүлжээн дээр байгаа энэ контентуудыг бид ер нь яах ёстой вэ?

Намайг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байхад хүн зарна гээд кино хийгдэж байсан. Тэгээд бид хатуу арга хэмжээ авч байсан. Эргээд сошиал булливид би өөрөө орж байсан.

Тэгээд эцэг, эхчүүд асран хамгаалагчдын асуудал дээр бид ер нь яамд зөвхөн хүүхэд, хүүхэд л гээд байдаг. Энэ дээр ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ гэдгийг би асуумаар байгаа юм. Энэ үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэлтэй холбоотой асуудлуудын гол буруутай явж явж байж энэ эцэг, эх асран хамгаалагч нар өөрсдөө шүү. Өөрсдөө.

Бид өнөөдөр яаман дээр нөлөөллийн ажлууд гээд л мөнгө зарцуулаад л байна. Хүүхэд рүүгээ л чиглээд байгаа юм. Энэ асран хамгаалагч эцэг, эхчүүд рүү хэзээ чиглэх вэ гэдгийг би асууя.

Тэгээд үргэлжлүүлээд дараагийн асуултуудаа асууя. Баярлалаа.

О.Номинчимэг: Эцэг, эхчүүдийн хариуцлага, оролцооны талаар ямар нэгэн бодлого, арга хэмжээ, төлөвлөлт байгаа юу? Хэн хариулах вэ? Гэр бүлийн газар. Б.Баярсайхан дарга. 7 номер.

Б.Баярсайхан: Би бодлого хариуцаж байгаа газар биш, хэрэгжилт хариуцаж байгаа агентлагийн дарга.

Гэхдээ энэ дээр надад харагдаж байгаа шийдэл нь бид Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам гэж яам байгаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам байхад Гэр бүлийн бодлогын газар гэж 9-хөн хүнтэй газар байсан.

Гэр бүл гэдэг бүхэл бүтэн нийгмийн том анхдагч нэгжийг хамааруулаад энэ яамыг байгуулсан гэж байгаа боловч нэг ч хүн нэмээгүй. Өөрөөр хэлбэл Гэр бүлийн бодлогын газарт яг тэр бодлого боловсруулах хэмжээний хүний нөөц, тийм бүтэц байхгүй гэдгийг Их Хурлын гишүүдэд дуулгая гэж бодож байна.

Хоёрдугаарт, 1992-1995 онд 47 мянган хүүхэд сургууль завсардсан. 5 мянга гаруй хүүхэд траншейны гэгддэг хүүхдүүд байсан. Тэр үед бүх хүмүүс хоолны төлөө ганзагын наймаанд гэр бүл, үр хүүхдээ орхиод явж байсан. Энэ үед өссөн, төрсөн хүүхдүүд өнөөдөр 35-аас 45 насны ээж, аав нар байгаа.

Бид эцэг, эхчүүдийг заавал соён гэгээрүүлэх шаардлагатай яг ийм цаг үед бид амьдарч байна. Энэ дээр энэ гар утасны хэрэглээ бас нэрмэсэн.

Тэгэхээр манай байгууллага гэхэд 1.3 сая хүүхэд, 997 мянган өрхийн сайн сайхны төлөө ажилладаг боловч энэ жилийн нөгөө ухамсарлах ёстой, соён гэгээрэх ёстой 997 мянган гэр бүлийг хөгжүүлж хамгаалах жилийн төсөв маань 107 сая төгрөг батлагдсан.

Тэгээд ер нь бүх түвшиндээ Засгийн газрынхаа бүтцийг чиг үүргийг нь нэг эргэж харахгүй бол хүүхдээ хэрэгжилт дээр тавьсан. Тэгээд бодлого хамгийн гол юм шүү дээ. Зам, тээврийн бодлогын яамтай байж хүүхэд маань хэрэгжилт дээр байгаа энэ бүтцээ бид сайжруулж хамгийн түрүүнд хүүхдийн хөгжил, гэр бүлийн хөгжил рүү Монгол Улс анхаарах шаардлагатай гэж бодож байна.

Би нэлээн суурьтай шийдэл ярьж байна л даа. Тэгэхээс ч өнөө маргаашийн шийтгэх, өнөө маргаашийн соён гэгээрүүлэх ажлыг бид бага багаар хийгээд төдийлөн амжилттай болохгүй байх.

Түрүүн хаалттай группүүдийг асуулаа. Яг 10 жилийн өмнө яаманд байхдаа Цагдаагийн ерөнхий газартай хамтраад илрүүлж байсан.

- “Дэлхийгээс зайл”,
- “Халтаруудаас салъя”,
- “Чи яах гэж төрсөн юм бэ” –

-гэсэн ийм хаягтай хаалттай группүүд фэйсбүүк дээр байдаг.

Энэ дотроо нэг нэгнийгээ гадуурхдаг, ээж, аавынх нь хийсэн нүглээр, хөгжлийн бэрхшээлээр нь, амьдралынх нь юу юу байдаг юм ингээд бүлгийгддэг, амийг нь хорлолтол нь дээрэлхэж гадуурхдаг асуудал байгаа.

Одоо 10 жилийн дараа энэ улам хэцүү болж байна.

Түрүүн Б.Энхбаяр сайдын яриан дээр гарч байна. Бид цахим хэрэглээ, фэйсбүүк хэрэглээгээрээ дэлхийд хүн амынхаа тооноос давсан хэрэглээтэй. Үүнийгээ хүүхдүүдийнхээ дунд ямар ч хязгаарлах, хянах боломжгүй. Айл болгон хүүхдийнхээ гар утасны донтолтыг шийдэж чадахгүй ийм хэмжээнд байж байгаа.

Тэгээд цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдээ хамгаалах хууль, бие даасан хууль байх ёстой гэж олон жил ярьсан. Өргөн барьсан боловч буцаагдсан. Тэгээд Боловсролын яамнаас нэр нь өөрчлөгдөөд ингээд орж ирэх

гэж байх шиг байна. Тэгээд хамгийн сэтгэл эмзэглүүлж байгаа асуудал бол одоо бид нарын үед өсвөр насандаа шоглож гадуурхагдахад маш их ичгүүр айдас амсдаг байсан бол өнөөдрийн хүүхдүүд бид нарын хүүхэд наснаас нэг сая дахин илүү ачаа үүрээд явж байгаа.

Дэлхийн улс гүрнүүд энэ цахим мөшгөлтийн талаар маш их анхаарч байна.

- Анги шилжээд болдоггүй,
- аймаг шилжээд болдоггүй,
- улс орон шилжээд шийдэгдэж өгдөггүй.

Одоо ямар ч асуудал байсан өнөөдөр дэлхийн асуудал болчихоод яваад байгаа юм.

Тийм учраас энэ асуудлыг... /минут дуусав/

О.Номинчимэг: Баярлалаа. Б.Бат-Эрдэнэ та хэнээс асуух вэ? Тийм. 5 номер. Ц.Алтансор зөвлөх.

Ц.Алтансор: Би нэмээд энэ дээр хариулъя.

Ер нь сургуулийн орчинд нийт дээрэлхэлтийн 70 орчим хувь нь гарч байна гэдэг. Энэ бол ерөөсөө л гэр бүл дотор байгаа тэр хүчирхийллийн ямар нэгэн хэлбэр, хүүхдийн сэтгэл зүйн асуудал өнөөдөр буцаж гарч ирэхдээ сургуулийн орчинд буюу үе тэнгийнхэндээ өөрөөс доор сул дорой хэн нэгэнд гарах байдлаар илэрдэг ээ.

Тийм учраас ерөөсөө л бид нарын “тусгал” гэж нэрлээд байгаа нь энэ юм.

Тэгэхээр гэр бүлийн орчинд сая Б.Баярсайхан даргын хэлж байгаа ч гэсэнтэй санал нийлж байна. Бид ерөөсөө гэр бүлийн боловсролыг, эцэг, эхчүүдийн боловсрол руу анхаарах шаардлагатай болсон.

Тэгэхээр асуудал ирэхээрээ нөгөө сургуулийн орчин, сургууль, багш нар хариуцах ёстой гэдэг энэ асуудлыг яриад байж бас болохгүй юм. Тийм ч учраас энэ “үндэсний загвар” гэдэг зүйл бид яг эхлэл шатдаа явж байна.

Тэгэхээр энэ дээр холбогдох яам, хамтран ажиллах бүх боломжтой газруудыг бид нэгдэж ажиллаасай гэж хүсэж байгаа.

Яагаад гэхээр өнөөдөр –

- яг сургуулийн түвшинд бид яаж ажиллах юм,
- гэр бүлийн түвшинд яаж ажиллах юм,
- эцэг, эхийн хариуцлага гэж юу байх юм.

Өнөөдөр үр хүүхэд... /минут дуусав/

О.Номинчимэг: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Би асуултдаа ерөөсөө хариулт авсангүй. Ойлгомжтой ч биш байна.

Та хэдийн өөрсдийн чинь бичсүүнийг л би асуусан шүү дээ. Одоо танаас би өөрөөс чинь асууя.

Дээрэлхэлтийг дээрэлхэлтээр шийдэж болохгүй гээд Та өөрөө энэ дээр ярилцлага өгсөн байна. Тэгээд өнөөдөр алга болсон юм уу, эсвэл хүчиндүүлсэн гэдэг юм уу, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн зургийг гаргаад байдаг. Гэмт хэрэгтнүүдийнх нь зургийг гаргадаггүй байсаар л байгаа шүү дээ. Зодуулж байгаа хүүхдийн зургийг гаргаад байгаа болохоос биш зодож байгаа хүүхдүүдийнх нь зураг ерөөсөө гарахгүй л байгаа шүү дээ.

Бид өөрсдөө томчууд ялгаварлал, дээрэлхэлт, бид өөрсдөө ийм хандлага гаргаад байна шүү дээ. Үүнийг яаж шийдэх юм.

Та хэдээс хийж байгаа ажлыг чинь тайлагна гэж би ерөөсөө асуугаагүй байхгүй юу. Та нар сониноор өгсөн байна, цаасаар өгсөн байна, РР файлаар өгсөн байна. Ойлголоо. Баярлалаа. Одоо яах вэ? Би одоо яах вэ л гэж асуугаад байгаа юм.

Энэ Байнгын хороо. Байнгын хороон дээр шийдвэр гараасай гэж би хүсэж байгаа.

О.Номинчимэг: 4 номер. Д.Гантулга Боловсролын дэд сайд

Д.Гантулга: Тэгэхээр ер нь асуудал нь хууль дээрээ ямар арга хэмжээ авах ёстой гэдэг нэлээн сайн орсон. Нэлээн тарах уу. Одоо сая Боловсролын ерөнхий хууль дээр ч гэсэн эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг гээд 40.2 дээр байгаа. Хүүхэд хамгааллын хууль дээр ч гэсэн орсон байж байгаа.

Тэгэхээр хоёр төрлийн хандлага байгаад байна л даа. Нэг нь таны, Б.Бат-Эрдэнэ гишүүний асуугаад байгаа гэмт хэрэг, тэр дээрэлхэлт нь гарсны дараа ямархуу шийтгэлтэй байх юм. Тодорхой, хатуу байх. Нөгөөдөх нь урьдчилан сэргийлэх, нөлөөллийн аян дээрээ илүү анхаардаг тэр Финланд маягийн, нөгөөдөх нь Солонгос эд нар бол нэлээн хатуу юм билээ.

Тэгэхээр бид яах юм гэхээр “үндэсний сүлжээ”, “аюулгүй сүлжээ” гэдэг үндэсний загварыг зөөлөн талаар нь явуулъя.

Мөн ингээд яг судлаад үзэхээр яг үе тэнгийн дээрэлхэлт дээр хуультай улсууд байна бас. Япон Улс байна. Тухайлбал.

Тэгэхээр ингээд хуультай болох юм бол энд тэнд байгаа тэр бүх арга хэмжээнүүд чинь... /минут дуусав/

О.Номинчимэг: 4 номер. Нэмэлт 1 минут.

Д.Гантулга: Энэ бол үе тэнгийн дээрэлхэлт дээр ярьж байна.

Мөн тэр цахим орчинд гэвэл нийгмийн сүлжээн дэх цахим хүүхдийн оролцоог зохицуулах энэ хуулийн төсөл. Түрүүн хэлсэн. Энэ явж байгаа. Энэ хууль батлагдсанаар цахим орчны асуудал нэлээн шийдэгдэнэ. Ялангуяа өсвөр насныхан цахимын орчны харилцаа ер нь бодит байдал дээр байдаг харилцаанаас илүү чухал болсон энэ үед нэлээн ач холбогдолтой ийм хууль болно.

Сургуулийн албан ёсны нэтбүүкүүд нь бүгдээрээ байгаа. Сургууль болгон дээр LMS (Learning Management System)³, SMS (School Management System)⁴ системүүд орсон байгаа.

Тэгэхээр тэр албан ёсныхоо сүлжээгээр харилцаад явахаар юу бичиж байна, хэн орж байна гэдэг нь бүгдээрээ тодорхой бол байх ийм ач холбогдолтой хууль болно.

О.Номинчимэг: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулга.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би уг нь нэг л асуулт асуусан юм шүү дээ.

Эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ өмнө болон өмнөөс нь хариуцлага хүлээхгүй юм уу? Энэ дээр ямар шийдэл байгаа вэ л гэж асуусан.

Сэтгэл зүйч нар дээр та хэд бас худлаа яриад байна. Финланд, Финланд л гээд байх юм. Сая Финланд явж ирчхээд л нэг юм яриад байх шиг байна.

Сэтгэл зүйч нар байхгүй шүү дээ. Хөдөө орон нутагт сэтгэл зүйч нар чинь сургууль дотор ч хүртэл алга. Хайгаад олохгүй байна. Үүнийгээ яаж тогтолцоон дээр нь бэлдэх юм бэ?

Сэтгэцэд нөлөөлөх мансууруулах бодистой холбоотой маш олон асуудлууд үүссэн байна. Үүнийгээ бид яаж урьдчилан сэргийлэх байдлаар байдлаар ажиллах вэ?

Бид өнөөдөр энд яриад л байна, яриад л байна. Ар талд гэмт хэрэг үйлдэгдээд үе тэнгийн дээрэлхэлт, хүчирхийлэл яваад л байгаа байхгүй юу даа.

³ Хичээл, сургалттай холбоотой.

⁴ Сургуулийн захиргаа, менежмент

Энэ дээр ямар арга хэмжээнүүдийг авах юм бэ? Яг бодит нэг, хоёр, гурав, дөрөв гээд хэлэхээр юм байна уу?

Түүнээс биш та бүхний тайланг яг хангалттай сонслоо. Гарц хэлээд өгөөч ээ. Ямар бодлого явж байгаа вэ л гэж асуугаад байгаа юм.

О.Номинчимэг: Хууль зүйн сайд ямар арга хэмжээ хийх вэ? Эцэг, эхэд нь үүрэг, хариуцлага ногдуулах эрх зүйн орчин байгаа юм уу? Болох юм уу гэдэг асуулт байна.

Хууль зүйн сайд. Б.Энхбаяр сайдын микрофон.

Б.Энхбаяр: Хүүхдийн гэм буруугийн хариуцлагыг эцэг, эхэд нь халдаан хэрэглэдэг тохиолдлууд байдаг.

Энэ асуудлыг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тодорхой бичсэн байгаа. Хариуцлагыг бас чангалж байгаа заалтууд бас орж ирсэн байгаа.

Тэгэхээр Гэр бүлийн тухай хууль, түүнийг дагалдаж байгаа Эрүү, Зөрчлийн хуулийг хэлэлцэх үед энэ тодорхой яригдах байх.

Сэтгэл зүйчтэй холбоотой асуудал хөдөө гэлтгүй хотод ч хүнд байгаа. Төрийн албаны 2 сая төгрөгийн цалингаар сэтгэл зүйч ажиллуулна гэдэг бол үндсэндээ бид бие биеэ хуураад яах вэ.

Ялангуяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад сэтгэл зүйчээр ажиллах хүнгүй байгаа. Мэргэжлийн хүн байхгүй. Тийм цалингаар, тийм нөхцөлд ажиллах хүнгүй байгаа.

Хар тамхины хуулийг өнгөрсөн Засгийн газрын хуралдаан... /минут дуусав/

О.Номинчимэг: Нэмэлт 1 минут.

Б.Энхбаяр: Хар тамхинаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийг өнгөрсөн долоо хоногийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн барихаар шийдвэрлэсэн. Энэ долоо хоногт Улсын Их Хуралд өргөн барина.

Тэгэхээр Улсын Их Хурал дээр энэ чиглэлийн тодорхой асуудал яригдана.

Ер нь нэг зарчмыг Хууль зүйн сайд барьж байгаа. Тэр нь саяын ярьж байгаа энэ “сэтгэл зүйч”, “хар тамхины эмчилгээ” гэдэг асуудлуудыг төрийн хүчээр хийхгүй. Энэ менежментийг нь ер нь мэргэжлийн төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

“Даахгүй нохой булуу хураана” гэгчээр үүнийг ч эмчлэх төв хэрэгтэй, үүнийг ч юу яах ёстой гэвэл нэг барилга байшин барьдаг, цемент цутгадаг. Тэгээд баахан тавилга болдог. Дахиад л төсөвт данхайдаг. Тэнд ажиллуулах гэж байна гээд орон тоо нэмдэг ийм юм руу явах юм билээ.

Төр бол бодлогын дэмжлэгээр үзүүлэх хэлбэрээр хар тамхины хуулийг өргөн барьж байгаа.

О.Номинчимэг: Сэтгэл зүйч, бусад юутай холбоотой боловсролоос хариу өгөх үү? 4 номер. Товчхон хариу өгчих. Тийм.

Д.Гантулга: Тэгье. Яг өнөөдрийн байдлаар нийт 580 сэтгэл зүйч ажиллаж байна.

Тэгэхээр бидний өнөөдөр хөндөж байгаа асуудал зөв өө. Томчууд гэдэг юм уу, монголын нийгэмд ер нь сэтгэл зүйн зөвлөгөө авдаг энэ соёл хэзээнээс нэвтэрч эхэлсэн билээ. Одоо ер нь байгаа юм уу.

Тэгэхээр бид яг сургууль болохоор байх ёстой гээд сэтгэл зүйч олдохгүй байна гэдэг зовлон байдаг. Зовлон байгаа нь ч үнэн. Сургуульд байтугай гадуур ч сэтгэл зүйн зөвлөгөөний яг тийм сайн сэтгэл зүйч ч байхгүй. Бид бүгдийн энэ асуудал эндээ байгаад байгаа юм.

Тэгэхээр эхний ээлжид яана вэ гэхээр тэр “аюулгүйн сүлжээ” гээд байгаа маань зөөлөн аргаараа.

Эцэг, эхчүүд гэхээр заавал тэр хуулийн хариуцлага гэхээсээ өмнө ядаж хүүхэд нь хүүхэд дээрэлхсэн юманд оролцсон байвал хүүхдээ өмөөрдөггүй байхгүй бол одоо ерөөсөө эцэг, эхчүүд чинь.

Сургуулийн багш нар маш их гомдол гаргадаг юм шүү дээ. Эцэг, эхчүүд ирээд загнаад байна. Юун тэр хүүхдийнхээ тэр нь үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг арга хэмжээ авч эхлэх. Энэ эхлээд хандлагын өөрчлөлт дээр нь ажиллаж эхлэх ёстой гэж. Тэгээд цаашдаа мэдээж... /минут дуусав/

О.Номинчимэг: Баярлалаа. Б.Пунсалмаа гишүүн асуулт асууя.

Б.Пунсалмаа: Баярлалаа. Сүүлийн үед үе тэнгийн дээрэлхэлт ихсээд байна гэдэг асуудлыг ярьж байна л даа.

Тэгэхээр үе тэнгийн дээрэлхэлт өсөөд байгаа нэг шалтгаан бол гэр бүлийн хүрээнд үл хайхрал, хүчирхийлэл ер нь хэр нөлөөлдөг юм бэ? Яг энэ талаар Гэр бүл хамгаалал, хөгжлийн ерөнхий газар дээр ер нь гаргасан судалгаа байна уу?

Хоёрдугаарт нь, сургуулийн орчин дээрэлхэлтийг зогсоох албан ёсны дүрэм журам гэж байгаа юу?

Өнөөдөр улсын хэмжээнд 791 сэтгэл зүйч, 978 нийгмийн ажилтан байна гэж байна л даа.

- Тэгэхээр энэ нь хэр хүртээмжтэй байгаа юм?
- Нэг сэтгэл зүйч, нэг нийгмийн ажилтанд хэдэн хүүхэд хамаараад байгаа юм?
- Ажил, үүргийн хуваарь нь хэр оновчтой байдаг юм?

Нийгмийн ажилтныхаа ажил үүрэг дээрээ баахан илүү олон ажил тавьсан, гол юман дээрээ фокусалж чадахгүй яваад байгаа юм биш биз.

Цахим орчин дээрээ ер нь бид хүүхдүүдээ хэрхэн хамгаалж байгаа юм? Хуулиа ер нь хэр хурдацтай оруулж ирэх юм бэ гээд сая бүх гишүүд асууж байна.

Тэгээд эцэст нь хэлэхэд хүүхэд хөгжлийн орчин ер нь хэр оновчтой байна? Жишээлбэл, хүүхдийг зөв зүйтэй хүн болж хүмүүжихэд хамгийн чухал зүйл бол хичээлийн дараах хөтөлбөр, дугуйлангууд байгаа шүү дээ. Энэ хөтөлбөр, дугуйлангуудад төрөөс дэмжих бодлого юу байна? Өрхийн орлогоос үл хамаараад хүүхдүүд маань дугуйланд бүгдээрээ хамрагддаг, завгүй. Тийм ээ. Өөрийнхөө авьяас билгийг хөгжүүлэхэд цагаа зарцуулдаг болбол илүү буруу дутуу юманд хамрагдах нь багасна.

Тэгэхээр энэ тал дээр төрийн бодлого дээр юу нэмэх хэрэгтэй байна аа? Та бүгдийн саналыг сонсьё.

О.Номинчимэг: 7 номер. Б.Баярсайхан дарга.

Б.Баярсайхан: Б.Пунсалмаа гишүүнд баярлалаа. Маш чухал асуулт асуулаа.

Хүүхдүүдийн эсрэг үйлдэгдэж байгаа нийт гэмт хэргийн 70.1 хувь нь өөрийнх нь гэрийн орчинд үйлдэгдээд байгаа юм. 70.1 хувь. Энд үл хайхрах хүчирхийлэл маш том үүрэг гүйцэтгэж байгаа.

Түрүүн би хэлсэн. Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын хийсэн хамгийн сүүлд хүүхдүүдээс авсан судалгаагаар –

- сүүлийн нэг сар намайг юу хийж байгааг миний ээж, аав мэдэхгүй байгаа;
- миний тэдэн удаа согтсоныг миний ээж, аав нар мэдэхгүй байгаа;
- би тийм тамхи татаж байхад намайг анзаарахгүй байгаа;
- миний юунд сэтгэл зовж байгааг эцэг, эхчүүд ерөөсөө огт сонирхохгүй байгаа гэдэг асуудлыг хэлж байгаа.

Эндээс бид юу гэж харж байна гэхээр ерөөсөө гэр бүлүүд хүүхдээ үл хайхрах, хүчирхийлэл дав давамгайлж байгаа. Жилдээ Монгол Улсад гэртээ үл хайхрагдаж байгаа, гэмтэж бэртэж байгаа, мөн хүчирхийлэгдэж байгаа, нас барж байгаа хүүхдийн тоо 35 мянгад хүрсэн.

Үл хайхрагдаж байгаа байдал маш том хувийг эзэлж байгаа гэсэн үг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хөгжлийн асуудлыг асууж байна. Хоёр ээлжийн сургуультай байгаа Монгол Улсын хувьд дугуйлан секцийг төдийлөн сайн ажиллуулж чадахгүй байгаа байх гэж бодож байна. Бид дөнгөж л гурван ээлжийн сургуулиасаа гараад явж байгаа. Ялангуяа нийслэлийн сургуулиудын хувьд.

Тэгэхээр манай газраас энэ жил хүүхдийн зуслан үүсгэн байгуулагдсан 100 жил юм билээ. 1980-аад онд байгууллага болгон дэргэдээ зуслантай байсан. 215 зусланг янз бүрийн аргаар хувьчилж аваад одоо 30 гаруй зуслан улсын хэмжээнд ажиллаж байна. Тэгээд хүүхдийн хөгжлийн асуудлыг бид Гэр бүл, хүүхдийн хөгжил, амралтын төв маягаар 4 ээлжээр ажиллуулахаар энэ жил сая Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл хуралдаж зусланд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хагас хувьсах зардлыг даах, яг зуслангийн үйл ажиллагаа итгэмжтэй явуулж байгаа, тогтвортой явуулж байгаа зуслангийн газрын төлбөрийг чөлөөлөх гээд энэ арга хэмжээнүүдийг бас авахаар ярилцаж байгаа.

Түрүүн Б.Бат-Эрдэнэ гишүүний хэлээд байгаа, Б.Пунсалмаа гишүүнтэй хамтруулаад хэлэхэд Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдээ хайхрахгүй байгаа эцэг, эхчүүдэд хүлээлгэх хариуцлага байгаа юм.

Гэхдээ энэ хуульд зохицуулалт нь байхгүй байгаа юм. Нөгөөтээгүүр бид яг Америкт байдаг шиг эцэг, эх байх эрхийг нь хасаад, хүүхдээ аваад очъё гэхэд хүүхдийг гэр бүлээс нь тусад нь тухтай байлгах тэр хүүхэд хамгааллын байр нь, дэд бүтэц нь манайд огт байхгүй байгаа юм.

Тэгээд энэ хүүхдээ үл хайхраад байгаа гэр бүлийн асуудлыг Боловсролынхоо яамтай хамтраад боловсролын салбарт байгаа хүүхдүүдийн аав, ээж нарыг Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газар нь хамтдаа гэр бүл эцэг, эхийг соён гэгээрүүлэх, хүүхдээ хайхрах энэ ажил руу хамтдаа хиймээр байгаа юм. Үүнийгээ хийж чадахгүй байгаадаа үнэхээр бухимдаад байна. Салбар хоорондын уялдаа холбоо байхгүй байна гэж үзээд байна.

Улсын Их Хурлын гишүүдээс бүр нэг зүйлийг хүсэхэд би дахиад хэлэхэд гэр бүл гэдэг бол нийгмийн анхдагч нэгж.

- ▶ Гэр бүл амар амгалан байх юм бол нийгэм амар амгалан байна.
- ▶ Гэр бүл зөв байх юм бол Монгол Улс зөв байна.

- ▶ Гэтэл Гэр бүлийн хөгжлийн тухай хууль байхгүй.
- ▶ Гэр бүлийн хөгжлийн бодлого байхгүй.

Би түрүүн хэллээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг зүгээр “гэр бүл” гэдэг хоёр үг нэмсэн. Бүтэц, бүрэлдэхүүнд нь огт өөрчлөлт оруулаагүй байж байгаа. Энэ асуудлыг Та нар маань хараад өгөөч ээ.

Яг гэр бүлийн асуудлыг тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, нийгмийн даатгал, хөгжлийн бэрхшээл, ахмад настны асуудал хариуцсан ийм том яаман дээр “гэр бүл” гэдэг үг наачхаад, ингээд гэр бүлийн хөгжлийн бодлого ярих юм бол өнөөдөр ерөөсөө энэ чинь бүтэхгүй байгаа юм гэдгийг л хэлээд байгаа юм л даа. Хамгийн гол суурь шийдэл нь энд байна гэдгийг хэлэх гэж би оролдоод байна.

Тэгээд хөгжлийн асуудал дээр боловсролын салбар нэмээд ярих байлгүй дээ. Хамгийн гол нь эцсийн... /минут дуусав/

О.Номинчимэг: 6 номер. Т.Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Б.Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Тэгээд сая дэд сайд хэлсэн. 580 орчим сэтгэл зүйч ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байна гээд. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын 3 сургууль тутмын 2 нь сэтгэл зүйчтэй болж байгаа.

2021 онд анх сургуульд боловсролын сэтгэл зүйч ажиллуулж эхлэхэд их дээд сургуулиудыг жилдээ 100 орчим л сэтгэл зүйч мэргэжлээр хүмүүс төгсдөг байсан.

Боловсрол сэтгэл зүйч ажиллаж эхлээд сургууль болгоныг сэтгэл зүйчтэй болох бодлого барьснаас эхлээд Монгол Улсын Боловсролын их сургуулийн хамгийн эрэлтэй мэргэжил боловсролын сэтгэл зүйчийн мэргэжил болсон Монгол Улсын Их Сургуулийн хамгийн их элсэлттэй дээрээсээ хоёр дахь мэргэжилтэн нь сэтгэл зүйчийн мэргэжил болсон гээд уг нь сэтгэл зүйч бэлтгэгдэж гарах нь сайжирсан.

Хамгийн гол нь алслагдсан бүс нутгуудад, хөдөө орон нутагт. Яагаад гэхээр сэтгэл зүйч өөрөө шинэ тутам хөгжиж байгаа ийм мэргэжил учраас залуучууд алслагдсан сумын сургуулиудад очиж сэтгэл зүйчээр ажиллах энэ зүйл их дутмаг байгаа. Төвлөрсөн төв суурин газар, аймгийн төв, хотын сургуулиудын сэтгэл зүйчүүд ерөнхийдөө бол... /минут дуусав/

О.Номинчимэг: Тодруулах юм уу? Болсон юм уу?

Б.Пунсалмаа гишүүний хэлж байгаа, ер нь хүүхдүүд маань бүр бага насаа, 3, 4 наснаасаа дэлгэцийн донтолтод ороод, жоохон том болохоороо янз бүрийн тамхи, одоо юу гэдэг юм донтолтын хэлбэр лүү ороод. Тэгээд бүр хэцүү хамгийн сэтгэл эмзэглэж байгаа юм хар тамхи гээд. Ингээд донтолтын хэлбэр лүү ороод байгаа байхгүй юу.

Тэгээд яг энэ дээр угаасаа л олон улсын хамгийн сайн туршлага бол хүүхдүүдээ чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх тэр орчныг л бүрдүүлэх. Тэгээд аргаа ядаад тамхины хууль бид чинь энд сууж байгаа бараг ихэнх гишүүд нэгдэж өргөн барьсан.

Тэгээд тамхины татварыг чинь. Их орж ирж байгаа. Манай Монгол Улсад. Тийм ээ. Татварынх нь 50 хувийг нь ерөөсөө спортын дугуйлан, барилга байгууламжид, эсвэл хүүхдийн тэр шим тэжээлтэй хоолонд нь зарцуулчхаач ээ гээд хууль оруулаад ирэхээр Сангийн яам нь өнөөдөр бас ажлын дэд хэсэг дээр эсэргүүцээд сууж байгаа юм. Үгүй гээд.

Тэгээд яах гэж байгаа юм. Сангийн яам. Энэ онцгой албан татварын тамхийг хэрэглээг нь бууруулах, хүүхдүүддээ зориулах юмыг нь аваад татварынх нь мөнгийг өөр юунд тавих гээд байгаа юм. Нэг яам, Тамгын газрын дотоод зохион байгуулалт юу гэдэг юм засвар, тоног төхөөрөмж тавих гээд байгаа юм уу.

Тэгээд ийм бодлого гаргаад хүүхэд рүүгээ чиглэсэн аль аль талдаа төсөв мөнгөнийх нь талаас ч хийе гэхээр энд тэндээс яамд нь өөрсдийнхөө амбицыг барьж дийлэхгүй байдаг бол бас зохимжгүй байгаа.

Ерөөсөө энэ чөлөөт цагт нь бид өнгөрүүлэх тэр зуслангийн газар нь байдаг юм уу, чөлөөтэй тоглодог тэр урлаг, спортын арга хэмжээнд нь байдаг юм уу. Ерөөсөө ийшээгээ л бид орохгүй бол хэчнээн гарсан хойно нь бид халаглаад яах вэ дээ. Тийм ээ. Тийм юм байгаа.

Б.Пунсалмаа гишүүн тодруулах юм уу? Дахиад. Б.Пунсалмаа гишүүний микрофон. 1 минут.

Б.Пунсалмаа: Тэгэхээр Та бүгдээсээ шийдэл сонсоод байгаа юм л даа.

Энэ “хичээлийн дараах хөтөлбөр” гэж байна. Сэтгэл зүйч нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх. Тийм ээ. Энэ болгонд чинь төсөв, хөрөнгө оруулалт, бодлого хэрэгтэй.

Тэгэхээр Та бүгд үүнийгээ яг энэ ажлыг хариуцаж байгаа хүмүүсийн хувьд ямар саналууд бид нарт дамжуулж хэлэх юм? Үүнийг бид төсөв дээр суулгах дээр хэрхэн ажиллах ёстой юм? Тийм ээ. Тэр саналыг сонсох гээд байгаа юм.

О.Номинчимэг: 7 номер. Б.Баярсайхан дарга.

Б.Баярсайхан: Манай Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын ерөнхий газарт 2025 онд 833 нийгмийн ажилтан анх удаа томилогдсон байгаа. Сумд 1 нийгмийн ажилтантай болсон.

5 мянга гарам шахам хүн амтай суманд 1 нийгмийн ажилтан, Хүүхэд, гэр бүлийн сайн сайхны төлөө 1.3 сая төгрөгийн цалинтай ажиллаж байгаа. Суманд ажил олддоггүй учраас нийгмийн ажилтнууд маань тогтоод байгаа. Нийслэлд энэ ажил дээр хүн тогтохгүй байгаа юм.

Тэгэхээр нийгмийн ажилтан ажилласан энэ нэг жилийн хооронд хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа хүчирхийллийн илрүүлэлт ихэссэн. Кэйс шийдэл нэмэгдсэн. Хамтарсан багийн ажил сайжирсан.

Дөнгөж сая бид 2 сарын 18-нд авсан 2025 оныхоо статистикийг 2024 оны статистиктай харьцуулахад нийгмийн ажилтнууд сум, хороонд ажилласнаараа тодорхой сайн үр дүн гарсан байж байгаа. Өнөөдөр бас “Нийгмийн ажилтны өдөр” байгаа.

Тэгэхээр цаашдаа нийгмийн ажилтнуудын орон тоог нь нэмж өгөх юм бол... /минут дуусав/

О.Номинчимэг: Болсон уу? Ганзоригийн Лувсанжамц гишүүн асууя.

Г.Лувсанжамц: Гишүүддээ, яамны ажилтан, албан хаагчдадаа өдрийн мэнд хүргэе.

Мөн нийгмийн ажилтнуудын өдрийн мэндийг бүх нийгмийн сайн сайхны төлөө ажиллаж байгаа бүх ажилчин албан хаагчдадаа мэндийг хүргэж байна.

Хоёр асуулт байна. Эхнийх нь 3 яам маань өнөөдөр гурвуулаа болсны дараа биш болохоос өмнөх арга хэмжээ авъя буюу урьдчилан сэргийлэх тал дээр анхаарч чадна л их баяртай байна. Тэгж байж л бид энэ асуудлыг үе тэнгийн дээрэлхэлтийг шийдэж чадна.

Тийм урьдчилан сэргийлэх аян гээд маш олон аяныг 3 яам гурвуулаа хэрэгжүүлж байя.

- “Дээрэлхэлт дэлгэрлэх ёсгүй”,
- “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аян”,
- “Хүүхдээ сонсьё” гэх мэт. Тийм ээ.

Жишээ нь, Гэр бүлийн яам, Боловсролын яам тус бүрдээ жилд их үедээ 300-аас 400 мянга орчим хүүхэд хамруулж чадаж байна. 100-аас 200 мянган эцэг, эх нарыг бас хамруулж чадаж байна. Албан хаагчдыгаа бас хамруулаад явж байна.

Энэ дээр хэдүүлээ үр дүнгээ л ярих ёстой болов уу гэж бодож байна.

- Энэ аянуудыг зохион байгуулахад ямар хэмжээний төсөв зарцуулсан бэ гэдэг нэгдсэн тоо байдаг болов уу? Яам тус бүрээрээ.
- Энэ аяныг зохион байгуулснаараа үе тэнгийн дээрэлхэлт хэдэн хувь буурч байна гэсэн үр дүнгийн судалгаа бас байгаа юу?

Та бүхний ирүүлсэн тайлан дээрээс харахаар одоогийн нөхцөл байдлын зүйл харагдаж байгаа болохоос биш яг энэ аяныг хэрэгжүүлснээрээ –

- тэдэн хувь үе тэнгийн дээрэлхэлт буурчээ,
- эцэг, эхчүүд хүүхдүүдээ сонсдог болжээ,
- гэр бүлийн доторх энэ асуудлууд шийдэгджээ гэсэн ийм үр дүнг нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт нь, 108 дугаар луу жилд дунджаар 1000 орчим дуудлага ирдэг.

Тайлангаас харахад 10 хувьд нь танайхаас зөвлөгөө өгч хаагаад, 90 хувийг нь шилжүүлдэг гэсэн байна? Тийм ээ.

Шилжүүлэг дээрээ 21 аймаг, 9 дүүргийн Хүүхэд, гэр бүл, хөгжил, хамгааллын газар хэлтсүүдэд шилжүүлсэн байна гэж ойлголоо. Тайлангаас.

Энэ шилжүүлсний дараа ямар арга хэмжээ авсан бэ гэдгийг нь танай зүгээс мөрддөг үү? Яг энэ 31 дүгээр сургууль дээр ийм асуудал гарсан байна.

Манай дээр ийм зөвлөгөө өгөх боломжтой юм байна. Өглөө. Цааш нь 31 дүгээр сургуулийн Сүхбаатар дүүрэг гэх юм уу. Тийм ээ. Сүхбаатар дүүргийн энэ гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэс рүү шилжүүлсэн учраас ийм арга хэмжээ аваад ингэж хэрэг хаагдсан байна ч байдаг юм уу. Тийм ээ. Энэ асуудал шийдэгдсэн байна гэсэн тийм тайлангийн араас явдаг уу? Ийм хоёр асуулт байна.

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүний асуултад хэн хариулах вэ? Гурван яам. Тэгээд 108 хариулах юм байна.

Гэр бүлийн яам Т.Аубакир сайд гараад явсан. Өмнөөс нь төлөөлж газрын дарга хаана байна? Яам хариулаарай. 1 юм уу, 2, 3 дугаар микрофон. Тэр тоотой микрофон дээр очоод хариулъя.

Тэр хооронд нь Боловсролын яам, Хууль зүйн яам хариулъя. 4 номер. Боловсролын дэд сайд хариулж байх уу? 3 номер. Нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Э.Адъяасүрэн: Гишүүний асуултад хариулъя. Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн.

2025 оны хүүхэд хамгаалах зардлын төсвийн хэрэгжилтийн талаар танилцуулъя.

Нийтдээ салбарын хэмжээнд 2025 онд “Сургуулийн өмнөх боловсрол”, “Ерөнхий боловсрол” гэсэн хөтөлбөрийн хүрээнд 4.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

Төсвийн хэрэгжилт 85 хувьтай. 4.1 тэрбум төгрөгийг 2025 онд зарцуулсан байна.

Тэгээд үүссэн нөхцөл байдал, гүйцэтгэлтэй яагаад бага байгаа вэ гэхээр оны эцэст санхүүжилт, төсвийн орлого бүрдүүлэлттэй уялдаад дутуу орж ирсэнтэй холбоотойгоор хэрэгжилт 85 хувьтай хэрэгжсэн.

- Сургуулийн өмнөх боловсролын хувьд 91 хувьтай.
- Ерөнхий боловсролын сургуулийн хувьд 82 хувьтай хэрэгжсэн байна.

О.Номинчимэг: Тэр микрофон руу очоорой. Хариулах хүмүүс. Зөндөө олон аян хийсэн байна. Хаа сайгүй л хийдэг. Би ч гэсэн орон нутаг, нийслэл дээр ажиллаж байхад бид бас аян хийдэг. Үүний үр дүн яаж гарч байна гэдэг тоон үр дүнгийн хэмжилтийг хэлээч гэж байна.

3 номерын микрофон. Нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Б.Бадамжав: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Гишүүний асуултад хариулъя.

Боловсролын салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгээс би нэг тоо хэлмээр байна.

- ▶ 2024-2025 оны хичээлийн жилд үе тэнгийн дээрэлхэлтэд 16 мянга 117 суралцагч өртөөд байна гэсэн мэдээлэл манай дэд сайдын мэдээлэлд гарсан байгаа.

Энэ нь өмнөх хичээлийн жилээс 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа. Өөрөөр хэлбэл тухайн тохиолдол бүрт хүүхэд хамгааллын болон хамтарсан баг–

- шуурхай тусламжийн үйлчилгээ,
- хүүхэд хамгааллын үйлчилгээ,
- нөхөн сэргээх үйлчилгээг –

-төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байгаагийн үр дүнд манай энэ тоо 1.2 хувиар өмнөх хичээлийн жилээс буурсан гэсэн үр дүн гарсан байгаа юм.

О.Номинчимэг: Гэр бүлийн яам. 2 номерын микрофон.

Ц.Мөнхзул: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын газрын дарга Ц.Мөнхзул гэж хүн байна.

2025 онд хүүхэд хамгааллын зардал, хүүхэд хөгжил, хамгааллын зардал манай салбарт 20.3 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс 2025 оны 12 сарын 31-ний байдлаар 15.2 сая төгрөг буюу 74.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан.

Гүйцэтгэлээс ерөнхийдөө хорин хэдэн хувийн гүйцэтгэл батлагдсан төсвөөсөө бага байгаа шалтгаан нь тухайн үед төсвийн хүндрэлээс шалтгаалаад яг зарцуулалт дээр сар сарын зарцуулалт хойшлогдох нөхцөл байдлаас шалтгаалаад ийм гүйцэтгэл гарсан.

Хүүхэд хөгжил, хамгааллын зардал 2025 оноос эхлээд гэр бүл, хөдөлмөр, нийгэм хамгааллын салбарт “хүүхэд хөгжил” ба “хамгаалал” гэдэг хоёр зардлын ангилалтай болсон. /минут дуусав/

О.Номинчимэг: 2 номер гүйцээгээд хариулъя. Минутдаа багтаагаад.

Ц.Мөнхзул: Үүнээс өмнө хүүхэд хамгааллын зардал байсан.

Ингээд хүүхэд хөгжил, хамгааллын зардал дотроо –

- хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ,
- урьдчилан сэргийлэх үйлчилгээ,
- хөгжил, оролцооны зардал,
- эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээний зардал –

-гэсэн ангиллаар зарцуулагддаг.

Энэ “урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал” гэдэг нь ерөнхийдөө нөлөөллийн үйл ажиллагаанууд, зорилтот болон зорилтот бус урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлуудад зарцуулагдаж ажилладаг.

Манай агентлагийн зүгээс явуулсан үйл ажиллагааныхаа үр дүнгийн талаар мэдээллээ нэмээд хариулна.

О.Номинчимэг: Хууль зүйн яам гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх байгаа. Тийм ээ. тэндээс үр дүн байна уу? 8 номер.

Ж.Буянбат: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Ж.Буянбат байна.

Та бүхний энэ өдрийн мэндийг мэдье.

Яг тухайлсан хүүхэд хамгаалалтад зориулсан зардал байхгүй. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэд гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх зардалд –

- 2021 онд 333 сая 200 мянган төгрөг,
- 2022 онд 254 мянга 700 мянган төгрөг,
- 2023 онд зөвхөн орон нутагт 173 сая 100 мянган төгрөгийн санхүүжилттэй байсан байна.

2024 оноос Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаад хүүхэд хамгааллын үйл ажиллагааны удирдлага зохион

байгуулалтыг хангах чиг үүргийг хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шилжүүлсэн учраас төсөв тавигдаагүй байна.

Үр дүн сүүлийн 2 жил... /минут дуусав/

О.Номинчимэг: Хууль зүйн сайд гүйцээж хариулах юм байна. Б.Энхбаяр сайдын микрофон.

Б.Энхбаяр: Яах вэ, тодорхой үр дүнгүүд мэдээж байгаа. Ялангуяа замын хөдөлгөөний эсрэг урьдчилан сэргийлэх аянууд бол замын хөдөлгөөний эсрэг гэмт хэргийг огцом бууруулсан. Энэ бас үр дүнгээ өгдөг юм билээ.

Яах вэ, нэг талд нь үүнийг ганцхан аяны тоо, гэмт хэргийн гаралтын тоог шууд ингэж тулгаж бас болохгүй. Энэ их олон хүчин зүйлүүд нөлөөлж байгаа.

Цахим гэмт хэргүүд бол ер нь одоо бол маш хяналтгүй болж байгаа. Ялангуяа “гүтгэх” гэдэг эрүүгийн гэмт хэрэг байхгүй болсон. Ерөөсөө худал мэдээлэл тарааж байгаа цахим төрлийн хэргийг хуулийн байгууллага шалгах эрх зүйн үндэслэл байхгүй болсон. Хяналтгүй болсон.

Тэр байтугай сая 16 настай хүүхдийн хэргийн сэвэлтийг гадаад улсуудаас хийгээд байсан.

Тэгэхээр энэ бас зохион байгуулалттай, өөр зорилготой үйлдлүүд ч энд хавсрагдаад байна. Өөрөөр хэлбэл цахим... /минут дуусав/

О.Номинчимэг: 7 номер. Б.Баярсайхан дарга. Хийж байгаа ажлын үр дүн яаж гарч байна. Тэгээд 108-ын дуудлагаар дараа нь яаж хяналтаа хийж байна гэдэг асуултад хариулъя.

Б.Баярсайхан: Аян зохиогоод яг үр дүнд хүрсэн гэж хэлэхгүй.

Би 833 нийгмийн ажилтантай болсноор энэ жил нийгмийн ажилтны кэйс шийдвэрлэлт 86.7 хувиар нэмэгдэж, гэмт хэрэг 18 хувиар буурсан ийм амжилттай. Тухайлбал,

- Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 62.8 хувиар буурч байна.
- Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд 2.4 хувиар өсөж байна.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 24.9 хувиар буурсан.
- Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн хүүхдийн тоо 21 хувиар нэмэгдсэн.

- Хараа хяналтгүй хүүхэд 62.8 хувиар буурсан.
- Хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 70 хувиар буурсан.
- Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөрчил шалгасан хүүхэд 10.7 хувиар нэмэгдсэн.
- Асрамж, халамжийн төвд байгаа хүүхэд 6.8 хувиар буурсан.
- Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо 7.9 хувиар нэмэгдсэн.

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн нэмэлт асуулт, тодруулга.

Г.Лувсанжамц: Тийм. Хэдүүлээ үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлыг ярьж байгаа учраас үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аянууд маань дээрэлхэлт гарч байгаад хэдэн хувиар бууруулсан юм бэ гэсэн үр дүнг асуусан.

Тэгээд Гэр бүлийн яамны сая 833 нийгмийн ажилтан гэдгийг дэмжиж байна. Сайн ажиллаж байна. Хууль зүйн яам ч гэсэн янз бүрийн аянуудыг зохион байгуулж байгааг би үргэлж дэмждэг. Үр дүнгээ өгч байгаа гэж харж байна.

Гэхдээ өнөөдөр үе тэнгийн дээрэлхэлтийн сэдвийн талаар ярьж байгаа учраас яг энэ хүрээндээ ийм аян зохион байгуулсан чинь үе тэнгийн дээрэлхэлт буусан байна.

Тэгээд хоёр дахь нь. Сая түрүүн хоёр дахь асуулт байсан. 108 дээр 1000 орчим дуудлага ирээд 10 хувийг нь шийдээд, 90 хувийг нь шилжүүлдэг гэсэн. 90 хувь шилжүүлсэн тэр зүйлүүдийнхээ араас явдаг уу гэсэн асуултдаа хариулт авъя.

О.Номинчимэг: 108. Харьялж байгаа байгууллага. 7 номер. Б.Баярсайхан дарга.

Б.Баярсайхан: Г.Лувсанжамц гишүүн ээ, манайд жилд 108 мянга гаруй дуудлага ирдэг юм.

108 мянга гаруй. 10 мянга биш.

Эндээс 2024 онд 35 мянга гаруй нь кэйс шийдвэрлэлт болоод энэ бодитой байсан гэсэн үг.

108-ын утсанд ирж байгаа дуудлагын зарим нь бодитой, зарим нь хүүхдүүд тоглож байгаа, зарим нь дуудлага хийгээд кэйс болдоггүй. Өөрөөр хэлбэл асуудлыг тэр доор нь шийдээд явж байгаа ийм асуудлууд байж байгаа.

Шилжүүлээд байгаа гээд байгаа нь харьяаллын дагуу тухайн аймаг, орон нутагт. Хамтарсан баг тухайн аймаг орон нутгийн дарга нар чинь бүгдээрээ

хүүхдийн орон нутгийнхаа зөвлөлийн дарга нар. Хүүхдийн зөвлөлтэй байгаа шүү дээ.

Тэгэхээр хамтарсан баг тэр тухайн орон нутаг руугаа бас явдаг гэсэн үг.

Та үр дүн асууж байна. Би яг энэ ажлыг аваад нэг жил болохдоо энэ асуудлыг нэг кэйс шийдвэрлэлээ гээд энэ үр дүн нь гарч байна гэж би ерөөсөө харахгүй байгаад байгаа. /минут дуусав/

О.Номинчимэг: Г.Лувсанжамц гишүүн тодруулга.

Г.Лувсанжамц: Б.Баярсайхан дарга аа, би Та бүхний тарааж өгсөн материалыг харж байгаад л асууж байгаа юм шүү.

Үе тэнгийн дээрэлхэлтийн дуудлага мэдээлэл нь 2024 онд 1051, -

- шийдсэн нь 107,
- шилжүүлсэн нь 944 гээд.

2025 он. Тэгээд 2026 оны 3 сарын 13-ны байдлаар гэсэн.

Үүнийг асуугаад шилжүүлсэн 944-ийнхөө араас явдаг уу, үгүй юу гэсэн зүйлийг асууж байгаа.

Таныг сайн ажиллаж байна гэж би бодож байна. Бүх асуудал танаас болж байна гэж бодохгүй байна. 108-аас болж байна ч гэж бодохгүй байна.

Зүгээр л хэдүүлээ үр дүн ямар байгаа, төсвөө хэдий зарцуулсан юм гэдэг зүйлээ л логиктойгоор хоорондоо ярилцах зорилготой хариулт авах гээд л би асуугаад байгаа юм шүү.

О.Номинчимэг: Энэ тоо Б.Баярсайхан дарга мэдэхгүй байвал яамнаас өгсөн тоо байна шүү дээ. Яамныхан хариулах юм уу, яах юм. Гишүүдэд өгсөн танилцуулга дээр чинь тов тодорхой бичсэн байна. 7 номер. Б.Баярсайхан дарга.

Б.Баярсайхан: 2024-2026 онд энэ нийт ирсэн дуудлагын 2300 нь үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой дуудлага ирж байгаа.

Үүнийг үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой асуудлыг ерөнхийдөө хуулиараа Боловсролын яам бүрэн хариуцаж байгаа. Бүрэн хариуцах ёстой.

Гэхдээ бид хариуцахгүй байна гээд оролцохгүй байна гэсэн үг биш.

Бид тэр салбар хоорондын уялдаа холбоогоо миний яриад байгаа нь үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой ийм их дуудлага ирж байхад үүний дөнгөж 1 хувь нь боловсролын салбарын нийгмийн ажилтнуудаас ирээд байна.

Түрүүн өмнөх гишүүн асуусан. Тэр 70 гаруй хувь нь гэмтлийн эмнэлгээс ирээд байна гэдэг нь яг бодитой байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр боловсролын яам хариулах байх. Зүгээр миний хэлж байгаа нэг зүйл бол бид ямар нэгэн байдлаар кэйс шийдвэрлэлээ гээд тэр хүүхдийн асуудлыг ерөөсөө шийдвэрлэдэггүй юм билээ. Дөнгөж сэтгэл санааны тэр гутрал, бүх зүйлс нь яг л эхэлж байдаг юм билээ. Тэгээд үүнийг цааш нь мөшгөж 18 хүртэл нь... /минут дуусав/

О.Номинчимэг: 108-д ирсэн үе тэнгийн дээрэлхэлтийн кэйсүүдийг Боловсролын яам бүрэн хариуцах ёстой гэдэг чинь юу билээ? Яагаад 108-д гэмтлээр ч гэсэн хамаагүй дамжиж ирж байгаа юмыг Боловсролын яам 100 хувь хариуцах ёстой гэдэг юм байгаа юм.

Тийм яг ямар хууль дээр тийм юм байгаа юм? Боловсролын яам чинь үе тэнгийн дээрэлхэлтийг. 4 номер, 5 номер. Боловсролын яамнаас энэ хариугаа хэлье.

Тэгээд энэ асуудал дээр та хэд шилжүүлсэн асуудлаа яаж хэлэлцээд, ямар үр дүн гараад.

Тэгээд ийм л байна шүү дээ. Ер нь манай аягүй олон салбарт байгаа. Зөвхөн энэ асуудал дээр биш. Манай дараагийн хэлэлцэх орон сууцын захиалга, залилангийн асуудал дээр ч гэсэн дандаа яам яамны амбиц. Бид тэгнэ. Бид тэгэхгүй. Манайх биш. Танайх биш. Ерөөсөө энэ гээд. Тэгээд тийм болохоор чинь уялдаа ерөөсөө байдаггүй байхгүй юу.

Одоо тэгээд үе тэнгэрийн дээрэлхэлтийн асуудал 100 хувь. Тэгээд хуульдаа тийм бол бид тэрийг нь өөрчилье л дөө. Боловсролын яамны бүрэн асуудал гээд.

Тэгээд яаж энэ чинь уялдаж ажиллах юм? Ийм байхаар чинь. Яам яам өөрсдөө бид ийм, бид ийм гэдэг. Тийм. Ингээд хоорондоо уялдаатай ажиллахгүй бол яаж энэ дээр үр дүн гаргах... /минут дуусав/

5 номер. Ц.Алтансор зөвлөх.

Ц.Алтансор: Г.Лувсанжамц гишүүний асуусан асуулт дээр бас нэмээд тодруулаад хэлэхэд.

Мэдээж хоол үйлдвэрлэлийн юугаар бол 150 метр. Тийм ээ. 150 метрт “боловсрол, сургуулын орчин” гэж заасан байгаад байгаа.

Тэгэхээр бид яг сургуулийн орчинд үүсэж байгаа энэ асуудлуудыг бас ангилж, яг хаана үе тэнгийн дээрэлхэл, тэр асуудал гараад байна гэдгээ нэгдүгээрт ялгаж салгах хэрэгтэй учраас үүнд зохицуулах тэр хууль, зохицуулах акт хэрэгтэй байгаа юм. Яалт ч үгүй. Үе тэнгийн дээрэлхэлтийг.

Яагаад гэхээр өнөөдөр яг ярьж байна л даа. Гэр бүлийн яам, Хууль зүйн яам, Боловсролын яам. Аль нь хариуцах ёстой юм бэ гээд л асуудал яригдаад л байна.

Тийм учраас өнөөдөр бид энэ үндэсний загвар, үүнтэй холбогдох хуулийн асуудлыг яримаар байгаа юм. Яагаад гэхээр бид –

- сургуулийн орчинд,
- хүүхдийн хүүхдийн орчинд,
- дээрээс нь гэр бүлийн орчинд,
- үндэсний түвшинд –

- яг ямар ажлууд хийх юм бэ гэдгээ тодорхой гаргаад үүн дээрээ хамтарч ажилламаар байгаад байгаа юм. /минут дуусав/

О.Номинчимэг: 5 номер нэмэлт 1 минут.

Ц.Алтансор: Бид жишээлэх юм бол сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн чадвар олгох сургалтыг ч гэсэн сургалтын хөтөлбөрт оруулж өгөөд үүнийгээ бас зааж хүүхдүүд өөрсдөө энэ сэтгэл зүйн асуудалдаа урьдчилан сэргийлэх асуудал.

Бид түрүүн Финландын жишээг бас ярьсан гэдэг нь өнөөдөр 22 оронд хэрэгжиж байгаа нэг ёсондоо бүлгийн норм буюу сургуулийн соёлыг өөрчлөх ийм урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг ийм хөтөлбөр байгаа. Цогц. Тэгэхгүй болохоор бид яг “кэйс менежмент” буюу –

- гарсан тохиолдлыг нь дардаг,
- хохирогчтой ажилладаг,
- дээрэлхэгчийг нь шийтгэдэг –

- энэ системээр явснаараа үр дүн бас гарахгүй байгаад байна гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр эдгээр нэг ийм богино хугацааны аян, “кэйс менежмент” үр дүнгээ өгөхгүй байна.

Тийм учраас цаашаа бид хамтарч ажиллаад, урьдчилсан сэргийлэх талаасаа Боловсролын яам яаж ажиллах юм, Гэр бүлийн яам эцэг, эх рүүгээ хандсан тэр хууль тогтоомж энэ талаасаа яаж ажиллах юм, Хууль зүйн яам ноцтой хэмжээнд очвол яаж ажиллах юм гэдгүүдээ нийлүүлсэн ийм загварыг бид гаргана гэдэг энэ “Аюулгүй сүлжээ” загварын... /минут дуусав/

О.Номинчимэг: Баярлалаа. Тэгээд энэ асуултад хариулт нь бүрэн агуулга нь гарахгүй байгаа учраас би бас нэмэлт 1 минут өгөөд байгаа.

Гэхдээ дахиад одоо дахиад гурван ч гишүүн байна. Цөмөөрөө яг цагтаа хариултуудаа, асуултуудаа аваад явахыг бодъё тэгэх үү.

Ж.Галбадрах гишүүний микрофоныг өгье.

Ж.Галбадрах: Өнөөдөр маш чухал асуудал ярьж байна.

Тэгээд томчуудын л тусгал маань ийм байдалд үүнийг гаргаж байгаа. Би хэд хэдэн тодорхой асуултууд асууя гэж бодож байна.

Дээрэлхэлтийн тоог хэрхэн бүртгэж байна вэ? Одоо энэ зөвхөн дуудлагын тоо яриад байна шүү дээ.

Дуудлагын тоо, тэгээд гомдол гаргаж байгаа тоог л яриад байна. Тэгвэл далд хэлбэрт байгаа нь ер нь хэдэн хувь байгаа вэ?

Түрүү 33 хувь нь сургуульдаа итгэдэггүй гэж байна. Тэгээд итгэдэггүй бол сургуульдаа итгэхгүй байна гэдэг чинь багшдаа хэлэхгүй, тэгээд багшдаа хэлэхгүй бол тэр чинь эхний анхан шатны үе тэнгийн дээрэлхэлт бол тэнд явагдлаа. Тэгээд дараагийн шатандаа шилжлээ. Тэгээд одоо бүр ноцтой шатандаа ирэхээр л энэ чинь гараад байна шүү дээ. Тэр гэмтлийн эмнэлгээр дамжиж мэдэгдэнэ гэдэг бол яалт ч үгүй гэмтлийн эмнэлэгт очсоноос гарч байна.

Тэгэхээр ер нь дээрэлхэлтийг хэдэн хувь гэвэл хэдэн хувь нь мэдэгдээд байгаа юм гэдгийг нэгдүгээрт асуумаар байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн тийм ноцтой кэйс энэ тэр хэд байна вэ? Тэрийг ер нь тэгээд мөшгөж мөрдөөд энэ олон нийтэд шийдүүлээд явсан уу гэдэг тоог асууя. Тэр кэйсийг асууя.

Түүнээс гадна энэ маань маш олон жилийн өмнөөс явсан ийм ужгирсан асуулт байгаа. Ужгирсан энэ асуудлыг энэ жил. Одоо бид одоо ярьж байгаа нь сайн. Сайн гэж байгаа боловч энэ маань нэлээн бүр яваад бүр ийм түрүүн хэлээд байна шүү дээ. Бүр ийм бүлэг, бүр сүлжээ, ийм том ноцтой болсон үед нь бид ингээд ярьж байна.

Тэгвэл үүнийг өмнө нь яагаад энэ асуудлууд дээр ямар ямар, одоо үр дүн нь ямар гарав гэж асуугаад байгаа шиг энэ асуудлуудын талаар бас яагаад өмнө нь ийм арга хэмжээнүүдийг авахгүй энэ их олон жил ингээд яваад байна вэ? Өмнө нь ер нь ямар арга хэмжээ гарсных нь дараа гэсэн үг л дээ. Тэгээд гарахаас нь сэргийлнэ гэдэг нь бол хамгийн чухал байгаа.

Тэгээд сая Та бүхэн бас хэлж байна. Ямар орчинд гараад байгааг нь л их сайн судалсан уу? Одоо бид энэ сургуулийн анги дүүргэлт, бүлэг дүүргэлт хэтэрснээс болоод сурагчийн хувийн орон зай гэж байхгүй болсон. Хувийн орон зай байхгүй болохоор ингээд шахаад суусан хүүхдүүдээс чамаас тийм үнэр гарч

байна, тэгж байна ингэж байна гэдгээсээ эхлээд л, тохой шүргэлцэхээс эхлээд л ингээд л энэ бол бүр эхлэл нь тавьж байгаа.

Тэгэхээр бид сургуулийнхаа тэр орон зайг, энэ нөхцөлийг, сургалтын орчныг сайжруулах тал дээр та нар маань ямар арга хэмжээ авч байна вэ? Үүний тэр ноцтой гэдэг талаар бас хэлж өгөөч.

Тэгээд сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч бол олноор бэлтгэж байна гээд байна.

Тэгээд энэ бэлтгэж байгаа хүмүүсийгээ яг мэргэжлийн түвшинд хэр чиглүүлж мэргэшүүлж байгаа вэ? Энэ хүмүүс чинь ерөнхий сэтгэл зүйгээ судлаад гараад ирсэн байна. Тэгээд яг энэ үе тэнгийн дээрэлхэлт гэдэг дээр тийм мэргэжлийн хүмүүс ажиллуулж байна уу?

Мөн сургууль, гэр бүл, нийгэм, түншлэлийн холбоо, энэ “Аюулгүй сүлжээ” үндэсний зөвлөл гэж яриад байна. Үүнийг бас сайн бүр их нарийн... /минут дуусав/

О.Номинчимэг: Асуултад хэн эхэлж хариулах вэ? Шүүхээр шийдэгдсэн тоо байна уу? Бусад сургуулийн орчин.

6 номер. Т.Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Би эхний хэсэгт нь хариулаад, үргэлжлүүлээд манай сайдын зөвлөх бас хариулна.

2022-2023 оны хичээлийн жилээс эхлээд сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний тайланг анхан шатны маягтын дагуу авдаг болсон.

Өөрөөр хэлбэл эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоо. Энэ дотроосоо дээрэлхэлд өртсөн хүүхдүүдийн тоо гээд албан ёсны анхан шатны маягтаар авдаг болсон.

Тэгэхээр өөрөөр хэлбэл сургууль дээр байгаа хүүхдийн тоо, дээрэлхэлд өртсөн хүүхдүүдийн тоо албан ёсны анхан шатын маягтаар ингэж гарч байгаа. Тэгээд саяын дэд сайдын танилцуулга дотор 16117 хүүхэд дээрэлхэлд өртсөн байна гээд.

Энэ дээр кэйсүүд үүсгээд кэйсийн шийдвэрлэлтээ бас давхар тайлагнаад явж байгаа. Тухайлбал нэг тоо дурдъя.

Ер нь кэйсээр шийдвэрлэж сургуулийн хүүхэд хамгааллын баг –

— хаасан кэйсийн тоо 2701,

— хаагдаагүй үргэлжлүүлээд ажиллаж байгаа кэйсийн тоо 1067,

— бусад мэргэжлийн байгууллагууд холбон зуучилсан 1167 –

- гээд ингээд анхан шатын маягтын дагуу сургуулиудаар гараад явж байгаа.

“Сургуулийн сэтгэл зүйч” (School Psychologist)-ийг “Боловсролын сэтгэл зүйч” (Educational Psychologist)-ээр мэргэшүүлэх албан ёсны богино хугацааны сургалтуудыг бид 2022 оноос эхлээд зохион байгуулаад явж байгаа.

Тэгэхээр одоо сургуульд ажиллаж байгаа 500 гаруй сэтгэл зүйч боловсролын сэтгэл зүйчийн мэргэшүүлэх сургалтад суугаад албан ёсны сертификатаа аваад сургуульд ажиллах эрхтэй болоод ажиллаж байгаа ийм сэтгэл зүйчид байгаа.

Одоо харин бид багш ажилтныг мэргэшүүлэх, эндээ мэргэжил дээшлүүлэх модулиудыг бас боловсруулаад ажиллаж байгаа.

Тэгэхээр цаашдаа боловсролын сэтгэл зүйчийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдээд явахаар байгаа гэдгийг хэлье.

О.Номинчимэг: 5 номер 1 минут.

Ц.Алтансор: “Аюулгүй сүлжээ” гэдэг маань ерөөсөө л –

- аюулгүй орчин,
- аюулгүй сургууль,
- аюулгүй эцэг, эх,
- аюулгүй найз,
- аюулгүй социал сүлжээ

- гэж юу юм бэ гэдгийг л тодорхойлж өгч, үүнийхээ хүрээнд бид хүүхдээ хамгаалах бодлогыг л энэ үндэсний загвараар гаргаж өгөхийг л эрмэлзээд байгаа юм.

Тэгэхээр энэ маань өөрөө сургуулийн орчинд нэгдүгээрт “хүүхэд дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх бодлого” гэдэг зүйлтэй болох юм.

- ▶ Сургуулийн хариу арга хэмжээ,
- ▶ ноцтой байдалд авах арга хэмжээ,
- ▶ багш, ажилчдад зориулсан сургалт,
- ▶ дээрэлхэлтийг бүртгэдэг –

- ийм систем ажиллах юм.

Тэгээд хүүхдийн түвшинд бол сургалтын хөтөлбөр буюу сурах бичигт нь энэ талаарх мэдлэгийг өгөх агуулга бас орж ирнэ.

Эцэг, эхийн түвшинд бол эцэг, эхийн хариуцлагын асуудал юу байх юм бэ, эцэг, эх хэрхэн хариуцлага тооцох юм бэ гэдэг хууль, эрх зүйн орчинд энэ нь орж ирж өгнө.

Үндэсний түвшинд бид цаашдаа хийх хяналт, үнэлгээ гэдэг платформыг ч гэсэн хийхгүй... /минут дуусав/

О.Номинчимэг: Шүүхээр шийдэгдсэн тоо Та бүхэнд байна уу? Хууль зүйн яам. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх дээр бэлэн тоо байна уу? Байхгүй бол Ж.Галбадрах гишүүнд хэрвээ хүсвэл Та энэ тоог нь авчих. Тийм ээ.

Ж.Галбадрах гишүүн нэмэлт тодруулга.

Ж.Галбадрах: Түрүүн бас ийм хуультай орон байдаг гээд Японы жишээг хэлж байна л даа.

1990 оны үед их ноцтой байж байгаад одоо Япон бол бас энэ асуудлаа бас дарсан.

Түүнээс Та бүхэн маань нэг ийм хуулийн төсөл боловсруулж байгаа юу гэдгийг асууя.

Дараа нь сая хэлж байна л даа. Сэтгэл зүйчдийг зүгээр боловсролын талаар бэлдэх үү? Мэргэжлийн хүмүүсээр “көүчинг” хийнэ гэдэг шүү дээ. Тийм ээ. Одоо бэлтгэгдсэн хүмүүс дээрээ ажиллах нь маш чухал байна гэдгийг хэлмээр байна.

Түрүүн Б.Пунсалмаа гишүүн бас хэлж байсан. Энэ сэтгэл зүйчдийг нэмэх гээд л яриад байна шүү дээ.

Тэгэхээр 2018 оны 3 сайдын тогтоол байгаад байгаа шүү дээ. Норм, норматив баталсан. Энэ дээр чинь сэтгэл зүйч ажиллуулах юм нь байгаа юу?

Одоо сургуулиуд дээр очихоор сэтгэл зүйчээ авч ажиллуулна гэхээр бид нарт норм, норматив нь байхгүй байна гээд байна. Энэ тал дээр Та бүхэн маань юу анхаарч байна вэ? Тэгээд тодруулья.

О.Номинчимэг: 5 номер.

Ц.Алтансор: Хуулийн зүгээс нийтдээ олон улсын туршлагаар харахад нийтдээ яг энэ төрлийн хуультай 5-аас 10 орон байдаг юм билээ. Япон, Солонгос, Филиппин гэх мэтчилэн. Яг бодлогоор зохицуулж байгаа 20 орчим орон байгаа.

Тэгэхээр бид бас энэ талын хуулийг судалж байгаа.

Тэгэхээр яг бид нарын яриад байгаа энэ хууль эрх зүйн орчныг бүрдүүлээд, олон талт оролцогч талуудынхаа асуудлуудыг бүгдийг нь хуулиар зохицуул юм бол их ойлгомжтой болохоор байгаа.

Тэгэхээр бид одоогийн байгаа журам, чиглэлүүд дээр яг нарийн тодорхой ажиллаад, ажлын хэсэг дээрээ бас энэ асуудлыг яриад, ажлын хэсгийн үр дүнгээс бид хууль цаашаа байх уу эсэх дээр бас тодорхой саналыг хүргүүлнэ.

О.Номинчимэг: 4 номер нэмэлт хариулт.

Т.Ням-Очир: Тэр хоёр дахь асуулт. Сэтгэл зүйчийн тоо, норм, норматив дээр яаж орсон бэ гээд.

Тэр 2018 оны норм, нормативыг шинэчлэх ажлын хэсэг гарч ажиллаад, төслөө гаргаад, Сангийн яаманд хүргүүлсэн байж байгаа.

Ер нь олон улсын жишгээр 500-аас 1000 хүүхдэд 1 сэтгэл зүйч байдаг ийм нэг юу байна лээ. Benchmark байдаг юм байна. Тэгээд бид энэ норм норматив дээр аль болох энэ рүүгээ л чиглүүлэх байдлаар төсөлд орсон байж байгаа.

Дахиад л бид яг энэ норм, нормативыгаа шинэчлээд л гаргахаар үүний чинь цаад тал дээр шаардагдах боловсон хүчнээс авхуулаад санхүүгийн асуудал гардаг болохоор энэ бол зөвхөн ингээд хэдийгээр Боловсролын яам ингээд олон улсын жишгийг оруулаад тэгээд нэг их сайн хэрэгжиж чаддаггүй журамтай болох нь гол биш. Энэ яг хэрэгжээд явах гэхээр санхүү мөнгөнийх нь асуудал зэрэг шийдэж болохоор ийм цогц асуудал болчихоод байгаа.

Тэгэхээр Сангийн яаманд бид хүргүүлсэн байгаа. Хувьсах зардлын итгэлцүүр гээд бүх тэр холбоотой журмынхаа төслийг Сангийн яам... /минут дуусав/

О.Номинчимэг: Сангийн яаманд төслөө хийсэн. Дараагийн жилийн төсөвт суугаад явах нь уу. Бид бас харах ёстой юм байна.

О.Номинчимэг: Ж.Галбадрах гишүүн дахин тодруулга.

Ж.Галбадрах: Тэгээд бид маш олон хууль гаргаад. Тийм ээ. Одоо бүр шүүх дээр ч гэсэн энэ асуудлыг шийддэг. Хууль зүйн яам сайд түрүүн хэллээ шүү дээ.

Түүн шиг ингээд гэхээсээ илүү бид телевизээр, ялангуяа Боловсрол телевиз гэж бид нарт нэг сайн суваг байна. Тэгээд энэ сувгаар энэ хүүхдүүдэд зориулсан энэ арга хэмжээг телевизтэй гэрээ хийгээд хүүхдийн сэтгэл зүйд л. Ялангуяа ээж, аав энэ асуудалд эцэг, эхчүүд энэ асуудал дээр суралцах маш их хэрэгцээ байгаа.

Тэгэхээр эцэг, эхчүүдийг сургах, ахлах ангийн хүүхдүүдийг сургах энэ төсөл нь энэ кэйс, бүр болдог бол цуврал кино, драм хийгээд явбал болно.

Тэгээд би түрүүн хамгийн гол асуугаад байгаа нь ямар орчинд гар гараад байна вэ гээд.

- Энэ сургалтын орчин,
- энэ даац хэтрэлт,
- энэ норм хэтрэлт,
- бүлэг дүүргэлтийн асуудал дээр Та бүхэн маань сайн анхаарч явж үндсээр нь шийдэхгүй бол энэ хэзээ ч шийдэгдэхгүй асуудал шүү гэдгийг л бас хэлмээр байна.

Тэгэхээр Та бүхэн маань энэ хөрөнгө оруулалт, ялангуяа энэ даац хэтэрсэн сургуулиуд дээр их анхаарах хэрэгтэй. Үүнийг анхаарч чадвал бид нар... /минут дуусав/

О.Номинчимэг: Санал хэллээ. О.Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Би хоёр асуулт тодруулъя.

Яг одоогийн байдлаар дээрэлхэлтийн эсрэг бодлого, дүрэм журамтай хэчнээн сургууль байгаа вэ гэдэг тодруулга авмаар байна.

Хоёрдугаарт нь, “Аюулгүй сүлжээ” гэдэг шинэ санаачилга гаргаж байгаа юм байна. Энд маш их баяртай байна.

Гэхдээ энэ аюулгүй сүлжээг ажиллуулж эхлэхийн тулд одоогийн байгаа ямар тоон мэдээллүүд “base” болж ашиглагдах боломжтой вэ гэдэг ийм мэдээллийг авъя. Яагаад гэвэл энэ дээр маш их тоон мэдээллийг ашиглах шаардлагатай процедурууд бас харагдаад байна л даа.

Тэгэхээр энэ дээр мэдээлэл аваад, тэгээд тодруулж асууя.

О.Номинчимэг: Дээрэлхэлтийн журамтай сургуулийн тоо. 6 номер. Т.Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Яг ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг дагаж мөрдөж, өөрийнхөө сургуулийн хүүхэд хамгааллын бодлогыг гаргасан 886 сургууль.

Яг энэ сургуулийн хүүхэд хамгааллын багийн 7939 гишүүн яг энэ бодлогоо мөрдөж ажиллаж байгаа гэсэн ийм 2024-2025 оны хичээлийн жилийн албан ёсны анхан шатын тайланд тусгагдсан байгаа.

О.Номинчимэг: “Аюулгүй сүлжээ”-тэй холбоотой тоо дата. 5 номер. Ц.Алтансор зөвлөх.

Ц.Алтансор: Энэ нэг ёсондоо загварыг бас хийх болсон шалтгаанууд нь ерөөсөө л бид нийтдээ сургуулийн орчинд нийт хүүхдүүдийн 79 хувь нь дээрэлхэлд өртөж байна гэдэг ийм судалгаа байгаа.

Мөн 33 хувь нь ерөөсөө сургууль хамгаалж чаддаггүй буюу бид сургуульдаа итгэдэггүй гэдэг ийм асуудлыг ярьж байгаа.

Тэгэхээр нэгэнт хүүхдүүд маань сургуульдаа итгэхгүй байгаа, хэнд хэлэхээ мэдэхгүй байгаа ийм нөхцөл байдал бүрдээд байгаа бол бид аюулгүй орчин, аюулгүй сургууль гэдгийг бий болгож байж багш, ажилчид бүх тэр эргэн тойрны томчууд маань аюулгүй байдлыг бий болгож байж л энэ асуудал шийдэгдэж тодорхой хэмжээнд байгаа тэр далд байгаа зүйлийг бид ил болгох юм байна гэж харж байгаа.

Энэ утгаараа яг энэ асуудлыг гаргаж ирсэн.

Мөн түүнчлэн ихэвчлэн энэ үе тэнгийн дээрэлхэлт яадаг вэ гэхээр 80-аас 85 хувь нь гэрчтэй болдог. Эргэн тойронд нь дандаа хараад зогсож байгаа чимээгүй ажиглагч нар байдаг. /минут дуусав/

О.Номинчимэг: О.Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Би хүүхэд хамгааллын бодлоготой сургууль гэж асуугаагүй.

Дээрэлхэлтийн эсрэг бодлоготой сургууль гэсэн үг. “Anti-bullying program” гэдэг ойлголтыг асууж байна. Урьдчилан сэргийлэх бодлоготой. Тэр нь сургууль дээрээ тамга тэмдэгтэй, дүрэм журамтай. Хэрвээ тэрийг зөрчих юм бол яах вэ гэдэг асуудлыг асууж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл багш, сурагч, ээж, аав нарт зориулсан ийм бодлоготой сургуулийн тоог асууж байна.

Хоёрдугаарт, аюулгүй сүлжээний датаг хэрэгжүүлж эхлэхийн тулд төрийн байгууллагад байгаа, төрийн үйлчилгээнд байгаа ямар тоон мэдээлэл дээр түшиглэх вэ?

“Хур-Дан” системийн ямар үзүүлэлтийг ашиглах юм бэ гэдэг ийм тоо баримтын зүйл асуугаад байна. Тодруулъя.

О.Номинчимэг: Маш тодорхой асууж байна. Тодорхой асуултад нь тодорхой хариулъя. Тэгэх үү? 6 номер уу? 6 номер Т.Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Хуучнаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/214 гэдэг тушаалаар “Үе тэнгийн дарамтаас сэргийлэх, баримтлах чиглэл” гэдгийг баталсан.

Энэ чиглэлийн дагуу албан ёсны анхан шатны баримтаар яг үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх энэ бодлого, чиглэлтэй сургуулийн тоог авч

байгаа. Тэгээд энэ нь бол яах вэ, сая миний хэлсэн яг энэ хүүхэд хамгааллын бодлоготойгоо уялдуулаад 886 гэж хэлсэн нь ийм учиртай юм.

О.Номинчимэг: Дата дээр тодорхой хариулт. 5 номер.

Ц.Алтансор: Үүн дээр бид яг нөгөө платформ гэдэг зүйл дээрээ E-Parents_[цахим эцэг, эхийн систем], E-School_[цахим сургуулийн систем] гээд системүүд байгаа.

Эдгээрээс бид илүү дата авч яг эцэг, эхчүүд, оролцогч талуудын мэдээллүүдийг бол энэ системүүдээс авч хамтран ажиллахаар төлөвлөж байгаа.

О.Номинчимэг: Болсон уу? О.Саранчулуун гишүүн 2 дахь тодруулга.

О.Саранчулуун: Бид шинэ аян бол Монгол Улсад цөөдөөгүй, шинэ арга хэмжээ, сургалт бол цөөдөөгүй байна.

Энэ тайланг харахаар маш их сургалт аянууд хийгдсэн байна. Тэгэхдээ үүний ард төсвийг нь зоох юм бол бид бүр их зүйлийг харах боломжтой.

Тэгэхээр сургалт, аян бол зөв өө. Нөлөөллийн ажил байх ёстой. Гэхдээ энэ аян, сургалт болгоноос сургуульд ямар дүрэм журам өнөөдөр бичиг баримт болж үлдээд, тэрийг дагаж мөрддөг болсон тухай асуудлыг би тодруулмаар байгаа байхгүй юу.

Тэгэхээр “Аюулгүй сүлжээ” гэдгийг эхэлж байгаа бол үүний дагуу ямар өөр бодлогын баримт бичиг байх юм? Шинэ зүйлийг хийхийн тулд одоо байгаа датагаа ашиглахгүй бол бид ахиад шинэ систем гаргаад л, нэг сайт хийгээд л, нэг аппликэйшн хийдэг. Тэр нь ажилладаггүй байхгүй юу.

Тэгэхээр тийм юм байх вий дээ гэдэг болгоомжлол байгаа учраас би асуугаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр E-School гэдэг нь төрийнх юм уу? Тийм ээ. Төрд байгаа ямар мэдээлэлтэй уялдуулж энэ системээ ажиллуулах юм бэ гэдгийг л би тодруулах гээд байна л даа.

О.Номинчимэг: 5 номер. Ц.Алтансор зөвлөх хариулъя.

Ц.Алтансор: энэ загвар гэдэг маань зөвхөн платформын асуудлыг бид яриагүй. Энэ бол одоо яг 5 тулгуурт үндэсний загвар юм.

Нэг хэсэг нь бид бүртгэдэг систем буюу платформ гэж байгаа юм.

Тэгэхээр бид ерөөсөө өнгөрсөн тэр дата, хийсэн арга хэмжээнүүдийн асуудлыг бүгдийг нь авч хэлэлцэж байгаа. Өнгөрсөн хугацаанд Боловсролын Ерөнхий газар дээр хэрэгжсэн хөтөлбөрүүд, файлууд хэлбэрээр хэрэгжсэн хөтөлбөрүүдийг, мөн хамтран ажилласан төрийн бус байгууллагуудын

мэдээллүүдийг, хийсэн судалгаануудыг, жил жил хийгддэг тэр компанит ажлууд, аянуудыг ч гэсэн, юу нь бид нарыг авах ёстой юм бэ, ямар алдаа байсан юм бэ гэдгийг бүгдийг нь судалж үзэж байгаа. Энэ үндсэн дээр бид энэ 5 тулгуурт загвар гэдэг зүйл бол байх ёстой юм байна гэдгийг гаргаад ирсэн.

Одоо тэгэхээр яг ажлын хэсэг маань энэ дээр хамтраад ажиллаж байна.

Бидний гол зорилго цаашлаад... /минут дуусав/

О.Номинчимэг: Ингээд асуулт асуух гишүүд асуултаа асууж дууслаа. /алх цохив/

Өнөөдөр чухал асуудал дээр манай гишүүд ч идэвхтэй оролцож, ажлын хэсгээс ч гэсэн өөрсдийнхөө хийж байгаа бодлого, хөтөлбөрийг тайлбарлаж, цаашид Улсын Их Хурлын түвшний хэмжээнд юу хэрэгтэй байна вэ, уялдаа холбоо, төсөв санхүү, Гэр бүлийн яам гэдэг юм уу, бодлогын хүрээнд бид яаж харж бодит байдалд нийцүүлэх вэ гээд олон саналуудаа хэлж байна.

Байнгын хорооны даргын хувьд их талархаж байна.

Энэ асуудал дээр бас Боловсролын яам манлайлаад “айдсаар бус, ойлголцлоор шийдэх” энэ аян, сүлжээ үүсгэж байгаа юм байна.

Гол нь энэ маань манай төрийн байгууллагуудын уялдаа холбоо гэж үе үе, салбар салбарт яригддаг асуудал байгаа. Тэрийг маш сайн холбоотой ажиллах тал дээр Та бүхний зүгээс ч гэсэн манай Улсын Их Хуралд, Байнгын хороод, Өргөдлийн байнгын хороо, Хүний хөгжлийн байнгын хороо. Манай гишүүд тэгвэл юун дээр бас анхаарах ёстой байна гэдгээ саналаа бас хэлж байгаад талархаж байна. Өшөө нарийвчилсан саналыг ч гэсэн Та бүхэн бас ирүүлж болно шүү гэдгийг хэлмээр байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо гишүүд энэ сэдэвтэй холбоотой бас үг хэлэх боломжтой. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. /алх цохив/

О.Саранчулуун, С.Замира гишүүн гишүүнээр тасаллаа. 5 гишүүнээр тасаллаа.

Л.Мөнхбаясгалан гишүүн үг хэлье.

Л.Мөнхбаясгалан: Сургуулийн дээрэлхэлт гэдэг бол энэ бол аймшигтай үзэгдлээ.

Бид зүгээр энгийнээр хараад их хөнгөнд бодоод байгаа байхгүй юу. Хоёр хүүхэд хоорондоо хэрэлдэх ч юм уу. Тэгж бодоод байгаа. Үгүй ээ. Энэ зохион байгуулалттай, санаатай, бүр нэлээн харгислах шинжтэй үйлдлүүд байгаа шүү.

Тэгээд үүнийг ярихаар хүүхэд юм даа яах вэ, энэ хүүхдийн ирээдүй эд нар гэж яриад байгаа юм. Нөгөө дээрэлхэлтэд өртөж байгаа хүүхдийн оюун санаа, цаашдын амьдрал юу болж хувирах вэ гэдгийг бид тооцож ярихгүй л байна л даа.

Тэр хүүхэд насан туршдаа шархтай үлддэг. Хоёулаа тийм шархтай үлдэнэ. Зарим нь бүр гэмт хэрэгтэн болно. Зарим нь өшөөгөө авна. Энэ нийгмээс.

Тэгээд үүнийг харж хандахгүй байгаа алдаа эцэг, эхийнх гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Тэгэхдээ бид энэ дээр заавал нэг зүйлийг хийх хэрэгтэй. Одоо постероо нэмээд, аянаа нэмээд амжилтад хүрэхгүй. Сэтгэл зүйчид байгаа. Бид сайхан бэлтгэж байгаа гэж яриад байгаа боловчиг манай аймгуудад байдаггүй. Үүнийг би өөрөө мэдэж байна.

Тэгээд бас дээрээс нь нэгэнт хүүхдийн сэдэв хөндсөн бол гадаадын хөрөнгө оруулалттай асрамжийн газрууд. Надад 3 хүн өргөдөл өгсөн. Тэр асрамжийн газар шашны сект хийдэг. Тэр хүүхдүүдийг 14 хоног хоол өгөхгүй хорьдог. Цасан дээр хөл нүцгэн алхуулдаг. Гадаад руу авч явсан. Гуйлга гуйлгуулсан ийм ноцтой асуудлаар өргөдөл хандсан байгаа. Би үүнийг холбогдох байгууллагад нь өгнө.

Тэгэхээр бид энэ дээрэлхэлтийг хөнгөн юманд бодож болмооргүй байна. Сайд нь сая зүгээр шоу хийчхээд гараад явчхаж байгаа байхгүй юу. Энэ маш аюултай. Би анзаараад байхад хүүхэд дээрэлхэж байсан хүүхдүүд одоо төгсчхөөд сошиал орчинд хүнийг заналхийлдэг, хүнийг доромжилдог, нөгөө л хүчирхийллээ хийсээр яваа байхгүй юу. Эд нар цаашдаа гэмт хэрэгтнүүд болно.

Тэгэхээр наана нь бид ямар нэгэн арга хэмжээ авхуулах хэрэгтэй. Бусад нөлөөллийн ажлууд байж таарна. Сэтгэл зүйчид маш их хэрэгтэй. Зарим сэтгэл зүйчдийг хөдөө орон нутагт ажилласан жилийг нь төрийн албанд тэдэн жилээр тооцно гэсэн тийм асуудлыг бид гаргаж ирж болно шүү дээ.

Тэгээд эцэг, эхэд нь мөнгөн торгууль заавал оногдуулдаг байх хэрэгтэй байна.

Тэгэхээр их олон хуулиудад бид яаралтай өөрчлөлт хийх хэрэгтэй юм байна гэж бодож байна. Хөнгөн их битгий бодоорой. Заавал энэ хүмүүс ардаа ямар нэгэн сэтгэл зүйн асуудалтай үлддэг. Тэрийгээ дараа нь хүүхдүүддээ гаргадаг юм уу, эсвэл нийгмээс өшөө авах хэмжээний болдог шүү. Үүнийг та нар анхаарч үзээрэй л гэж хэлье.

Яаралтайгаар энэ хуулиудад бид өөрчлөлт хийх ёстой.

О.Номинчимэг: Баярлалаа. Би ч гэсэн яг өнөөдөр энэ мэдээллийг сонсоод юун дээрээ бодлогын хийдэл гараад байна гэдэг дээр дүгнэлт хийж, үүний дагуу ажил өрнүүлж болох үүднээс өнөөдөр энэ хуулийн хэрэгжилтийг сонсож байгаа.

Ингээд яриад байх юм бол бодлогын хийдэл бол зөндөө л газраа байгаа. Хүүхэд гэж тавиад салбар дундын асуудал болоод хаяад тавьдаг болохоор л хаана хаанаа бид энд анхаарах ёстой болоод байгаа гэдэгтэй санал нэг байна.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлье.

С.Эрдэнэбат: Тэгэхээр манай байгууллагууд маань чадлынхаа хэрээр л ажиллаж байна гэж бол харж байна.

Гэхдээ бидний хувьд нэгдүгээрт бодлогын нэгдсэн уялдаа холбоо чухал юм уу даа гэж бол харж байна.

Хууль эрх зүйн хүрээнд яг ямар хуулийн ямар заалтуудыг хийж өгвөл бид ийм юм хийх бололцоотой байна вэ гэдэг энэ асуудал өнөөдрийн хурлаас гараасай гэж би бодож байна. Тухайлбал, тэр сошиал орчинд хүүхдүүдийг хязгаарлах, тодорхой хэмжээгээр тэр групп, элдэв янзын сошиал орчинд авчирч ирж байгаад тэгээд хүчирхийлдэг, ялгаварлан гадуурхдаг, янз бүрийн зүйлд өртөж байгаа энэ асуудлууд дээр нь судалгаа тооцоотой, хяналт дүгнэлттэй бол хандах хэрэгтэй болов уу гэж ийм зүйлийг хэлмээр байна.

Хууль эрх зүйн орчин, хүний нөөц, хөрөнгө мөнгө, тэгээд процесс гэдэг ийм дөрвөн чиглэлээр хүүхэд хамгааллын асуудал дээр онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.

Энэ жилийг хүүхэд хамгааллын асуудал дээр нэлээн ач холбогдол өгье гэдэг дээр Улсын Их Хурлын даргаас авхуулаад гишүүд ч гэсэн энэ зүйлийг маш их яригдаж байгаа.

Тийм учраас энэ жилийг боловсролын жил, тэр тусмаа боловсролын орчинд 70 хувь нь хүүхдүүд нь хүчирхийлэлд өртдөг ийм орчин байж болохгүй. Яах аргагүй хүүхдийн орчин боловсролын салбар мөн.

Тийм учраас үүнийг өнөөдрийн байгаа хүмүүс гэхээсээ илүү бидний л туулж авчирсан энэ цаг хугацаанд л анхаарахгүй өнгөрүүлсэн ийм л бодлогын алдаанууд байна. Үүнийгээ шатдаа засаад явъя гэдэг зүйлийг хэлмээр байна.

Хүүхэд хамгааллын сан гээд энэ хөрөнгө мөнгөний асуудал бас яригдаад байдаг. Тэрийг ч гэсэн зүй ёсных нь зохицуулах ёстой энэ зүйл дээр нь зарцуулмаар байна.

Татварын хууль ч гэсэн явж байгаа. Хүүхдээс авхуулаад бид хүүхэд хамгааллын орчин бий болсон. Тэр 1 хувийн татварыг ч гэсэн ийшээ нэлээн чиглүүлэх хэрэгтэй юм байна. Тэгэхгүй бол тэр 1 хувийн татварын ихэнхийг нь

баахан спорт заал барьж байгаа нэрийн доор шоу цэнгээний баахан газар болгоод хувиргах вий. Бас буруу тийшээ явах гээд байгаа ийм тал байгаа.

Хүүхдийг шүүх шүүхийн байргүй байна гэдэг бол энэ өөрөө аягүй том асуудал шүү дээ. Манай улсад төрийн олон л байр байгаа.

Тийм учраас энэ тал дээр бид хандлагаасаа авхуулаад ажиллая. Хууль эрх зүйн орчны хүрээнд манай Байнгын хорооны гишүүд маань дэмжээд явна. Тэгээд Та бүгдэд амжилт хүсье.

Тэгээд маш олон хэргүүд цаана нь нуугдмал байгаад байгаа юм болов уу. Зүгээр мөсөн уулын орой тэр гэмтлийн эмнэлгээр гэхэд гэмтэж бэртсэн хүмүүсийн гэмтлийн эмнэлгээр л илэрдэг гэж байна шүү дээ. Гэмтэлд очоогүй, гэртээ байж байгаа, уулын мухарт байж байгаа маш олон хүүхдүүд хүчирхийлэл, дарамт шахалтад өртөж байгаа. Сошиал орчинд хэлэх гээд хэлж чаддаггүй. Хэлэх юм бол бүр их гадуурхалтад автана гэдэг бодолтой байж байгаа.

Тийм учраас тэр үеийнх нь хүүхдүүдийг өөрөө өөрсдийгөө хамгаалах гэдэг хамгийн зөв арга болов уу гэж би бодож байна.

О.Номинчимэг: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Агуулгаа л их сайн хармаар л юм шиг надад зүгээр санагдсан.

Би одоо Боловсролын яамыг шүүмжилдэг хүмүүсийнх нь нэг. Боловсролыг Боловсролын яамнаас нь аварья гэж би хүртэл ярьж байсан.

Өнөөдрийн байгаа процесс дээр энэ ганцхан боловсролын асуудал биш л дээ. Би түрүүн хэлсэн. Энэ бол нийгмийн цогц хүрээний асуудал болчихоод байгаа.

Тэгээд энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бид нарт тарааж өгсөн. Хамгийн харамсалтай юм л яг л энд л байгаад байгаа юм л даа. Тэгээд энэ дээр хурдан морины уралдаантай холбоотой, хүүхэдтэй холбоотой 10 заалт байгаа. Хориглосон заалтууд. Нэг талдаа. Гэтэл гамшгийн нөхцөл байдалтай онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалалттай холбоотой 6-хан заалт байгаа. Асуудал энд байна.

Та нарын оруулж ирж байгаа энэ дотор асуудал байна гэсэн үг. Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын сургууль зааг гараад хүүхдүүд нь сурахад маш хүнд нөхцөл бүрдсэн. Тэгэхэд танай Боловсролын сайд ямар хариулт хэлсэн бэ гэхээр “Энэ бол аймаг, орон нутгийнх нь өөрийнх нь үүрэг юм.” гэж хэлж байсан. Энэ өөрөө харамсалтай.

Энд хүүхэд хамгааллын асуудал орхигдож байгаа юм. Хүүхэд эрүүл, аюулгүй орчинд, хүн эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох ёстой. Үндсэн хуулиараа.

Энэ гамшгийн нөхцөл байсан уу, онцгой нөхцөл байсан уу гэвэл байсан. Засгийн газрын хуралдаанаар оруулаад гамшгийнхаа төсвөөс, Засгийн газрын нөөцөөс мөнгийг нь гаргаад тэнд хүүхдүүдийн төлөө арга хэмжээ авах ёстой байсан.

Би үүгээр юу хэлэх гээд байна гэхээр та нар зөвхөн цаасан дээр ажиллаж байна. Цаасан дээрээ ч бүрэн ажиллахгүй байна. Өнөөдөр Байнгын хорооны хуралдаанд орж ирэхдээ Та бүхэн концепцтой. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Соёлын яам цогцоороо асуудлаа тодорхойлоод орж ирэх ёстой байхгүй юу.

Энд яах гэж та нарыг бид тодорхой асуултууд асууж байгаа вэ гэхээр ямар концепцоор бид цаашдаа ямар хамгаалал, зарчим, ямар гарц шийдлийг эрэлхийлж явж байгаа вэ гэдэг дээр л хамтарч шийдэл гаргахыг л бид хүсэж байгаа юм.

Харамсалтай нь Та бүхэн зөвхөн өнгөрсөн хугацаанд хийсэн ажлаа өөрсдийнхөө арьсыг хамгаалах хэмжээнд тайлбарлаад өнгөрч байгаа нь маш харамсалтай. Би бол харамсалтай гэж хэлнэ. Би бол үүнийг эмгэнэл гэж хэлнэ. Ний нуугүй хэлэхэд.

Яг хүүхэд хамгааллын энэ асуудал дээр ямар бодит үйл ажиллагааг Та бүхэн хийж байгаа вэ гэдэг өнөөдрийн энэ дүр төрх чинь өнөөдрийн нийгмийн толь болсон энэ үе тэнгийн хүчирхийлэл, энэ дээрэлхэлт, энэ амь насаа алдаж байгаа асуудлууд, энэ хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч чадахгүй сургуулийнх нь танхимд гадагшаа нар гарсан, салхи сийгсэн өрөөнд хичээл хийгээд бид нарыг авраач ээ гэж байхад энэ онцгой гамшгийн нөхцөл байдал биш юм гэж хэлээд буцаж байгаа сайдтай холбоотой асуудал байхгүй юу.

Нийгмийн энэ асуудлыг бид цогцоор нь авч үзэх ёстой.

Засгийн газар Улсын Их Хурал тусдаа. Улсын Их Хурал Та бүхэнд аль болох шийдэл дээр нь дэм болохыг хүсэж байгаа. Гэтэл та нар шийдлээ оруулж ирэхгүй хий хоосон тайлагнасан хэлбэрийг явуулж байгаа нь маш харамсалтай байгаа. Маш харамсалтай байгаа.

Та бүхэн ярьсаар л байна. Хүүхэд хамгаалал нэрээр улсын төсөв дээр төсөв тавихыг л хүсэж байна. Бодит ажил чинь ерөөсөө хийгдэхгүй байна. Би үүнийг Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нар, салхи нь сийгсэн сургуулиар, тэнд идэр есийн хүйтэнд хүүхдүүд яаж даарч хөрч байсан бэ гэдгээр Та бүхэнд хэлж байгаа юм.

О.Номинчимэг: С.Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Уг нь асуулт асуух байсан. Тэгэхдээ амжсангүй.

Асуулт тэгээд үг хоёуланг нь зэрэг явуулъя. Энэ хүүхдийн эрх зөрчигдөж байна гээд Б.Бат-Эрдэнэ гишүүний ярьж байгаа үг нь зөв. Эрүүл саруул, тэгээд аюулгүй орчинд хүүхэд маань Үндсэн хуульд заасан юугаар сурах ёстой. Хүүхдүүд маань. Тэгсэн чинь одоо юу болж байна.

Яах вэ, хууль батална гээд хууль санаачлаад оруулж ирсэн байна. Тэгээд хууль баталснаараа, хууль санаачилснаар энэ асуудал үгүй болно гэж би бодохгүй байна.

Яагаад гэвэл энэ нийгэмдээ байна, энэ орчиндоо байна, энэ сэтгүүлзүйдээ байна. Бүх юм. Үүнээс гарах гарц гаргалгаа Та нар хэлэлцэж энд оруулж ирэх ёстой байсан.

Ямар хүмүүс энэ Их Хурал, Байнгын хороо дээр орж ирнэ гэхээр нь дандаа нэг зовлон ярьсан, дандаа мөнгө төгрөг ярьсан, ер нь болж бүтэхгүй талаас нь ярьсан хүмүүс л орж ирэх юм.

Ер нь зүгээр нэг энгийнээр нэг санаачлах юмаа яагаад санаачилж болохгүй байна. Юу нь болохгүй байна. Хөдөлмөр, халамжийн нийгэмд нөгөө ямар юм гэнэ. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар гээд том газар байгаа юм байна шүү дээ. Юу нь болохгүй байна. Яамд нэгдсэнээр яагаад ажил нь явахгүй байна. Үүнийг нэг тайлбар надад бичгээр ирүүлж өгөөрэй.

Газар байж байж бүхэл бүтэн яамнаас болоод бидний ажил саатаж байна гэж хэлж байх. Би үүнийг гайхаад байна л даа. Тэгээд сургуульд эцэг, эхийн зөвлөл гэж байдаг юм. Боловсролын яамнаас хүн байгаа биз. Энд. Тэр эцэг, эхийн зөвлөл гэж ер нь юу хийдэг хүмүүс юм. Багш байна. Ангийн багш нь гээд. Тэгээд сэтгэл зүйч яриад байна. Сэтгэл зүйч чинь хүрэлцээ муутай гэж байна. Тэр сэтгэл зүйч нь ангийн багштай, тэгээд сургуулийн эцэг, эхийн зөвлөлд ер нь анги бүрд хэдэн хүүхэд сахилгагүй, тал нь сул гээд бодъё л доо. Түүнтэй тулж ажиллаж яагаад болохгүй байна. Энд ямар мөнгө хэрэгтэй юм бэ. Ер нь. Сэтгэл дутаад байгаа биз дээ.

Одоо ямар ч амьд харилцаа байхгүй. Дандаа цаасаар нэг судалгаа авсан, ингэсэн, тэгсэн, тэгээд гэмт хэрэг гарахаар жоохон шүгэлдэж байгаад тэгээд нам дарагдана. Тэр нь эцсийн үр дүнд юу болсон. Үнэхээр арга хэмжээ авагдсан уу, үгүй юу. Тэр тал дээр ерөөсөө дахиад юу ч байхгүй. Тэгээд байсхийгээд нэг баахан бужигнаж байгаад, хүн болгон ярьж байгаад тэгээд нам дарагдана.

Хамгийн гол нь гэмт хэрэг хийсний дараа тэр хүүхдүүдийг яллах, эцэг, эхийн арга хэмжээнд оруулах биш, бид урьдчилан сэргийлэх тал дээр яг тулж ажиллах ёстой.

- Ангийн багш нь байна.
- Сургуулийн захиргаа нь байна.
- Тэгээд эцэг, эхийн зөвлөл нь байна.

Тэр байтугай ангийн дарга гээд бас байдаг шүү дээ. Тэр хүмүүс хүртэл болохгүй байгаа хэдэн хүүхэдтэй яагаад ажиллаж болохгүй байна. Тэрнийг та нар нэг эргэж хараарай.

Тэгээд боловсролын салбарт ер нь шинэчлэгдэж байгаа юм байна уу. Одоо ингээд гэмт хэрэг гарч байна. Энэ бүлэглэл гэдэг чинь аюултай шүү. Ганц хоёр хүүхдийн зодоон нүдээн байвал өөр хэрэг. Бүлэглэлүүд ингээд хүүхдийг гэмтээгээд янз бүрийн гэмт хэрэг гарч байна гэдэг чинь аюултай. Энэ дээр урьдчилан сэргийлэх тал дээр ер нь хуулийн талаар, сэтгүүл зүйн талаар сургууль дээр нь хичээл ном орж байгаа юу. Ерөөсөө байхгүй байгаа юм уу. Энэ тал дээр Боловсролын яам, Хууль зүйн яам эндээ хамтран сургалт явуулах хэрэгтэй. Албан ёсоор... /минут дуусав/

О.Номинчимэг: С.Замира гишүүн үг хэллээ. О.Саранчулуун гишүүн үгээ хэлье.

О.Саранчулуун: Нэгдүгээрт, бид ирүүлсэн материалуудтай танилцаж байгаа юм.

Тэгэхээр бид нарт нэг асуудал байгаа нь хуульдаа ч гэсэн. Бид “дээрэлхэлт” буюу “bully”, “дарамт” буюу “harassment”. Тийм ээ.

Хүчирхийлэл, гэмт хэрэг гэдгүүдээ ялгамжтай тодорхойлоод тухай бүрд нь тохирсон урьдчилсан сэргийлэлт, -

- эрсдэлтэй байвал ямар ажил хийх юм,
- хариу арга хэмжээ нь ямар байх юм,
- эргээд сэргээн засахын тулд юу хийх юм –

-гэдэг ийм matrix-тай, тооцоололтой төлөвлөгөөг би ерөөсөө олж харахгүй байгаад байна л даа.

Бүгдийг нь “дээрэлхэлт” гэдэг нэг тогоон дотор хийчхээд энэ дотор чинь хүчирхийлэл нь ч яваад, дарамт нь ч яваад янз бүр болоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр бид бодлогын цэгцтэй шийдлийг гаргамаар байгаа.

Яагаад тэр аюулгүй сүлжээ дээр үндэсний датаг ашиглах тухай ярьсан бэ гэхээр тухайн нэг хэрэг гарахаар нэг шинэ систем бий болгоод, нэг шинэ ажил эхэлдэг. Тэгээд түүнийх нь үр нөлөө, үлдэц нь маш дутагдалтай харагдаад байдаг юмыг бид олон жил харсан учраас –

➔ одоо байгаа төрийн мэдээллийн системүүд,

- ➔ одоо байгаа халамж, хорооны нийгмийн ажилтнууд,
- ➔ одоо ажиллаж байгаа сэтгэл зүйч нар –

- ➔ ямар мэдээлэл хоорондоо солилцож байгаа,
- ➔ ямар тогтолцоог ашиглаж байна –

-гэдгийг харж байгаад, тэгээд түүнийгээ уялдуулах талаар ярихгүй бол цоо шинэ зүйлийг хөрсөн дээр буулгахаас илүү байгаа зүйлээ сайжруулах дээр бид ажиллахгүй бол үр нөлөө нь бас одоо ингээд хий хоосон болох вий дээ гэдэг санаа зовж байгаа учраас би түрүүний асуултыг асууж тодруулаад байгаа юм.

Нөгөө талдаа сая би хэлсэн. Тийм ээ.

- ▶ Аль нь “дээрэлхэлт” юм,
- ▶ аль нь “дарамт” юм,
- ▶ аль нь “хүчирхийлэл” юм,
- ▶ аль нь “гэмт хэрэг” юм –

- гэдгээ бид энэ дээр ялгахгүй бол хүүхэд хамгаалж байна гэдэг нэг тогоон дотор бүгдийг нь хийчхээд, сургалтыг нь ч гэсэн бүгдийг нь нэг тогоонд, аян хийсэн ч бүгдийг нь нэг тогоонд хийхээр хүмүүс ялгахгүй байна.

Ялгахгүй байна. Хололдоод байна. Тийм ээ.

Тэгээд үүнийгээ цэгцлээч гээд байгаа юм.

Сургууль дотор “дээрэлхэлтийн эсрэг бодлого” гэдэг бол тусдаа байх ёстой. Хүүхэд хамгаалах бол хамгаална гэдэг чинь хамгаалж байгаа байхгүй юу. Тухайн хэрэг явдал болоход хамгаалж байгаа.

Урьдчилан сэргийлэх бодлого бол сургууль анхнаасаа л жижигхэн эрсдэл гарч ирэхэд л арга хэмжээ авах ёстой байхгүй юу. Хүүе. Яагаад чи ингээд байна. Тийм ээ. Ийм байж болохгүй гэдэг арга хэмжээ авах ёстой. Бага дээр нь.

Тэгэхгүй бүр ийм хүнд байхад нь. Тэр хүүхдүүд жишээлбэл өнөөдрийн нийгэмд гарсан хэрэг бол ийм хүнд нөхцөлд ирж байна гэдэг илэрсэн нь л энэ болохоос биш илрээгүй өчнөөн дарамт хийсэн байж таараа. Илрүүлээгүй өчнөөн дээрэлхэлт бид өнөөдөр дахиад гарч ирнэ. Энэ чинь зөвхөн бид нарт харагдаж байгаа мөсөн уулынх нь орой.

Тэгэхээр бид энэ дээр хүүхэд хамгааллын бодлого чинь өөрөө үе шаттай баймаар байна. Эрсдэлийн түвшин дээр.

Түрүүн тайлан дээр харагдаж байна шүү дээ. Эрсдэлтэй гэж үнэлсэн байна.

Дээрээс нь янз бүрийн төрлийн ийм дарамт, дээрэлхэлт, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд насан туршдаа эдгэшгүйгээр бие, сэтгэл санаа, нийгмийн харилцааны гэмтэлтэй болдог. Түүн дээр бид эргэн сэргээн засах арга хэмжээг огт авдаггүй.

Ер нь бид гурав дахь, хоёр дахь урьдчилан сэргийлэлтийг огт ярихгүй орхигдуулаад байгаа нь бас нэг асуудал.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг эргэн сэргээх тухай асуудал ярьж байна. Тийм ээ. Оронд нь хиймэл хөл хийгээд өгье гэдэг шиг. Тэгвэл сэтгэл зүйн хувьд бэрхшээлтэй болсон хүүхдүүд насан туршдаа ажилтай болохгүй, хамт олонтой болохгүй, гэр бүл болоход ч асуудалтай, өөрийгөө үргэлж буруутгадаг, өөртөө итгэх итгэлгүй ийм болж төлөвшиж байгаа байхгүй юу. Ийм том хүн болж байгаа байхгүй юу. Эргээд эд нар дахиад өөр хүүхдүүдийн ээж, аав болно.

Тэгэхээр би Та бүхнээс юу хүсэж байна вэ гэхээр, хэрвээ шаардлагатай бол хамтарч ажиллая. Үе шаттай матрикстай төлөвлөгөө гаргая. Хууль зүйн нэр томъёонуудаа ялгая.

- Аль нь “гэмт хэрэг” гэж тодорхойлоод тэр хуулийнх нь хүрээ рүү аваачих юм.
- Аль нь “дарамт” гэж тодорхойлох юм.
- Аль нь “хүчирхийлэл” гэж тодорхойлох юм.
- Аль нь “сэтгэл зүйн дарамт” юм.
- Аль нь “cyberbullying” гэдгээ тодорхойлчихоод бүх тодорхойлсон шат бүр дээр –
- Аль нь “урьдчилан сэргийлэлт” байх ёстой юм.
- Аль нь “дараах сэргээн засалт” байх ёстой юм.

Дээрэлхэлт өртсөн жижигхэн ч гэсэн анги дээрээ дарамтлуулсан хүүхдэд сэтгэл зүйн сэргээлт огт байхгүй шүү дээ, манайд одоо. Тэгээд л өөрийгөө тайвшруулаад л, ээж нь аргадаад л дуусдаг ийм л нөхцөл... /минут дуусав/

О.Номинчимэг: Баярлалаа. Яг энэ О.Саранчулуун гишүүний хэлсэнтэй холбогдуулаад энэ яг бид нарт дээрэлхэлт гэж юу юм, дарамт нь юу юм, яахаараа гэмт хэрэг рүү орох юм гэдгээ маш сайн тодорхой болгож өгөхгүй бол одоо бидэн дээр ирж байгаа, бид чинь энэ Өргөдлийн байнгын хороон дээр өрөгдөл, гомдлууд ирж байгаа шүү дээ.

D-Petition дээр ч гэсэн бас үүнтэй холбоотой асуудал нийтийн өргөдөлд үүссэн байгаа.

Тэгээд ингээд явахаар хүүхдүүд маш тийм далд хохирогч нар ихтэй. Тэгээд хэллээ гээд яах вэ улам л би бүлгидүүлнэ. Тэгээд хариуцлага тооцдоггүй шүү

дээ. Заавал юу гэдэг юм бие махбодын хохирол байж байж л энэ чинь цаашаагаа яваад байна.

Сэтгэл зүйн хувьд би дарамтад ороод сэтгэлээр депресст ороод. Тийм ээ. Ингээд байж байхад хариуцлага тооцож чадахгүй бол би хэлээд дахиад илүү л депресст орж хохирохын нэмэр. Яршиг гээд гарч ирж үүнийгээ хохирогч болсноо хэлж чадахгүй байгаа олон 10 хүүхэд байгаа тухай энэ асуудлууд бас яваад байгаа өргөдөл байна.

Тэгэхээр Хууль зүйн сайд энэ дээр байгаа дээр Та энэ дээрэлхэлттэй холбоотой хууль эрх зүйн орчныг нэг дахиж хараач ээ.

Энэ асуудлыг бид харсаар байтал. Мэдээж урьдчилан сэргийлэх ажил хийнэ. Энэ бол хамгийн чухал асуудал. Нийгэм рүүгээ чиглэсэн. Энэ бол ийм цогц арга хэмжээ гэдэгтэй бид санал нэг байгаа.

- Эдийн засгийн хувьд ч гэсэн,
- гэр бүлийн хувьд ч гэсэн,
- хөгжлийн хувьд ч гэсэн,
- хүүхдүүдээ бид яаж чөлөөт цагаа зөв өнгөрүүлдэг болгох гээд олон юмыг бид хийж байж байгаа юм.

Гэхдээ хамгийн тодорхой болсон. Одоо тэгвэл хийдэл гараад байгаа юм байна гэдэг асуудлаар Хууль зүйн сайд байгаа дээр Байнгын хорооны хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой энэ асуудлыг хууль зүйн хүрээнд хараад ялгаж, ялгамжтай байдлаар үүсгээд хариуцлага тооцдог механизм дээр юун дээр алдаа хийдэл гараад байна гэдгийг хараач ээ гэдгийг хэлмээр байна.

Х.Баасанжаргал гишүүн үг үү? Х.Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Надад хэд хэдэн асуулт байсан боловч би цагаа юу яаж чадсангүй. Хууль өргөн барих гээд.

Санал дээрээ хэдэн зүйл хэлэх гэсэн юм.

Түрүүн О.Саранчулуун гишүүний хэлдгээр яг аль нь гэмт хэрэг юм, аль нь зөрчил юм, аль нь сургууль дээрх жижиг хэмжээний зөрчил юм бэ. Яг сургуулийн түвшиндээ шийдэх нь аль нь юм, эцэг, эхийн түвшиндээ шийдэх нь аль нь юм гэдэг энэ хил хязгаар, үүний зааг ялгааг гаргаж өгөх зайлшгүй хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм.

Тэгээд тэр дундаа хүүхэд нь ямарваа нэг асуудалд орлоо гэхэд эцэг, эх хамгийн түрүүнд хэнд хандах юм. Ангийн багшид хандах юм уу. Нөгөө эцэг, эхийн чат дээр бичээд хоорондоо хэрэлдэх юм уу, яах юм гэдэг заавар зөвлөмжүүд сургуулиудад нэгдсэн журмаар өгөөч ээ гэдэг зүйлийг өнгөрсөн 10 сараас хойш л

бичиг боловсролын яаманд явуулаад л ерөөсөө энэ нэг л болж өгөхгүй байгаад байна.

Тэгэхээр сая Боловсролын яамны цаашид авах арга хэмжээ гэдэг дээр гарч ирж байх шиг байна. Нэг.

Хоёрдугаарт, хүүхэд хамгааллын шинэчилсэн найруулга батлагдаад, түүнээс хойш яг энэ хүүхэд хамгааллын үндэсний хэмжээний яг тогтолцооны зураглал байна уу гэж асуугаад хариулж байгаа юм ерөөсөө байхгүй байна. Би өөрөө бас Хүүхэд, гэр бүлийн шүүхийн хуулийг ахалж байгаагийнхаа хувьд бас л яг энэ зураглалыг салбаруудаас нь асуугаад энэ ерөөсөө гарч ирэхгүй байна. Үүнийгээ ядаж нэгдүгээрт гаргаадхаач ээ.

Хоёрдугаарт, давтан гэмт хэрэг зөрчилд холбогдоод байгаа хүүхдүүдийн мэдээлэл байна уу? Хүүхдүүд тухайн гэмт хэрэг, нэг гэмт хэрэг, нэг зөрчилд холбогдлоо гэхэд эргэж давтаад байна уу. Тэр нь ямар нөхцөлд нөлөөлөөд байна вэ гэдэг судалгаа гаргаж өгөөч ээ гэхэд бас байхгүй.

Тэгэхээр ерөөсөө бид нарт хэрэгцээтэй дата, судалгаа, тоон мэдээлэл нь ер нь маш хангалтгүй, хаана хаанаа маш хангалтгүй байгаад байна.

Тэгэхээр үүнийг ер нь манай салбарууд ч гэсэн аягүй сайн анхаарах хэрэгтэй байх. Тэгээд Улсын ерөнхий прокуророос бас гаргаж өгнө гээд ингээд хүлээгээд байж байгаа гэсэн үг.

Гуравдугаарт, өнөөдрийн энэ хэлэлцүүлэг, энэ мэдээлэл олон нийтэд нээлттэй очсоноороо би нэг үр дүнг хүлээгээд байгаа юм. Юу гэвэл ямар ч байсан энэ асуудал томчууд, насанд хүрэгчид, төрийн анхаарлын төвд байгаа юм байна. Хамгаалах, хамгаалагдах энэ механизм тодорхой хэмжээгээр алдаж онож байгаа ч гэсэн ажиллаж байгаа гэдэг энэ итгэл найдвараа битгий хүүхдүүдийг алдаасай гэж бодож байгаа.

Сая төрийн байгууллага, яамдаас ирж байгаа хүмүүсийн зөндөө олон мэдээлэл үг Та бүхэн олон нийт сонслоо. Бас мэдээж эрвийх дэрвийхээрээ бүгд л ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ итгэл найдварыг ерөөсөө бид алдаж болохгүй.

Дээрээс нь нэмээд цагдаагийн байгууллага яг энэ гэрч, хохирогчийг хамгаалж байгаа тал дээрээ мэдээллийг цаг алдахгүй өгдөг байгаач ээ. Тэгэхгүй бол шүгэл үлээсэн гэрч, хохирогчид эргээд давхар хохироод байгаа мэдээлэл маш олон ирээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ дээр би олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цагдаагийн өгч байгаа мэдээллийг харсан чинь тэр болохоор жишээ нь худлаа мэдээлэл байсан ч гэдэг юм уу гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр аль нь үнэн юм, аль нь худлаа юм гэдэг талаар мэдээллийг цагдаагийн байгууллага яг энэ холбогдох байгууллагууд нь, төрийн

байгууллагууд нь цаг алдалгүй яг энэ цахим орчин дээр яг мэдээллийг тавьдаг баймаар байна. Хэлдэг баймаар байна. Энэ мэдээлэл үнэн, худлаа гээд.

Тэгэхгүй болохоор нийгэм хоорондоо талцаад, сүүлдээ цахимаар хүн шүүх хэмжээний юм болоод байна л даа. Төрийн механизм ажиллахгүй байгаа юм шиг ийм сэтгэгдэл иргэдэд очоод байгаа байхгүй.

Тэгэхээр төрийн байгууллага, үүрэг хүлээгчид, хариуцаж байгаа хүмүүс маань яг энэ талаарх мэдээллийг шуурхай цаг алдалгүй өгдөг байх тал дээрээ бас нэг анхаараад өгөөч гэж хүсэж байгаа.

Тэгээд хамгийн сүүлд нь манай Байнгын хорооныхоо гишүүдэд би бас уриалах гэж байгаа. Хүний эрх, эрх чөлөөний ерөнхий хяналтын сонсголыг яг энэ хүүхэд хамгааллын хуулиар ерөнхий хяналтын сонсгол санаачлаад гаргая гэдэг ийм санаачилгыг миний хувьд гаргаад манай Байнгын хорооны гишүүд дэмжээд гарын үсэг зураад, манай Байнгын хороо энэ дээр санаачилгатай ажиллаад цаашид энэ мэдээллүүдийг авсан юм чинь бид бүр нарийн, гүнзгий, бүр деталь руу орж ингэж ажиллах хэрэгцээ шаардлага байгаа учраас энэ санаачилгыг бас дэмжээд тэгээд хаана хаанаа бүгдээрээ энэ дээр хамтарч ажиллая гэдэг ийм уриалгыг хэлэх гэж байна.

Тэгээд 108 гэдэг бас утасны дуудлагын мэдээллийн асуудал маш олон бас асуудлууд дагуулаад байгаа ийм мэдээллүүд бас ирээд байгаа. Энэ дээр яам болохгүй болбол, би болбол бараг Хууль зүй, дотоод хэргийн яам руу энэ 108 гэдэг энэ утасны дуудлага мэдээлэл өөрөө шилжээд, одо болбол 102 шилжсэн байгаа. 103 шилжсэн байгаа... /минут дуусав/

О.Номинчимэг: Баярлалаа. Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Саяын эхний асуудал буюу үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсож дууслаа. /алх цохив/

Одоо хэлэлцэх асуудлынхаа дараагийн хоёр дахь асуудал оръё.

Хоёр.Орон сууц захиалах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагын мэдээллийг сонсох

Орон сууц захиалах, худалдах, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн сайдын мэдээллийг сонсоно.

Өмнөх асуудал дээр оролцсон албан хаагчдадаа, ажлын хэсэгтээ баярлалаа.

Гэр бүл, хөдөлмөрийн яам, Хууль зүйн яам, манай Боловсролын яамныхан. Тийм ээ. Баярлалаа.

Дараагийн ажлын хэсгийг оруулахад бэлдээрэй.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглабарт тусгасан Орон сууц, захиалга, худалдан авах харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн биелэлтийн талаар мэдээлэл сонсох хүрээнд орон сууцын барилга барихтай холбоотой олгож байгаа зөвшөөрөл, захиалгын гэрээ, барилгын чанар, ашиглалтад оруулах үйл явц, аюулгүй байдалд тавих хяналтын талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайдын мэдээлэл сонсоно.

Дэд сайд байна уу? Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд Самбуугийн Энхболд сайд орж ирсэн байгаа юу?

Хууль зүйн сайд Б.Энхбаяр сайд бас мэдээллээ хийнэ.

Барилгын яамныхан орж ирсэн үү? Тийм ээ. Орон сууц, барилгатай холбоотой олгож байгаа зөвшөөрөл, захиалгын хяналт, гэрээ, чанар, ашиглалтад оруулах үйл явц, аюулгүй байдалтай холбоотой Та бүхэн маань ямар хяналт хийж байна.

Орон сууцын захиалгаас үүдээд хохирсон иргэдийн асуудал маш их ирсэн. Манай Байнгын хороон дээр.

Манай Байнгын хороон дээр 32 өргөдөл ирсэн боловч үүний ард 200-аад хүн байгаа. Багц ийм асуудал.

Мэдээлэл авахаар үүгээр хязгаарлагдахгүй. 2000 гаруй иргэдийн асуудал бас яригдаж байгаа. Хууль, шүүхийн байгууллага дээр очоод гацсан, цөхөрсөн, олон жил яахаа мэдэхгүй болсон нийгмийн үзэгдэл болоод байна.

Тэгээд энэ асуудлыг харахаар урьд нь ерөөсөө Эдийн засгийн байнгын хороо ч барилгын асуудал гэдэг утгаараа авч хэлэлцэж байгаагүй, Хууль зүйн байнгын хороо ч энэ чинь хууль эрх зүйн орчин нь яаж байна гэдгээрээ авч хэлэлцэж байгаагүй.

Өргөдлийн байнгын хороо байгуулагдсаны үр дүнд бид иргэдээсээ авсан өргөдөл, гомдол дээр бид цаашдаа иргэдээ хохироосон асуудлыг таслан зогсоохын тулд ямар хууль эрх зүйн орчин, бодлогын алхмыг хийх ёстой байна гэдэг асуудлуудыг хэлэлцэж байгаа.

Хоёр, гурван хэлэлцүүлэг хийсэн. Санал бодлыг нь сонссон. Тэгээд энэ асуудалтай холбоотой өнөөдөр бас мэдээллийг сонсоод өнгөрсөн оны 12 сард Өргөдлийн байнгын хорооноос энэ асуудал дээр анхаарч хяналт шалгалт хийнэ гэдэг асуудал гарснаас хойш олны анхааралд орж, манай бодлого боловсруулагчид, яамдууд ч гэсэн энэ дээр анхаарч байгаагаа хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээлээд байгаа. Тийм ээ. Гэхдээ яг ямар арга хэмжээ, шийдэл хийх гэж байна гэдгийг олон нийт төдийлөн мэдэхгүй байгаа.

Тэгээд иргэд маань ер нь амьдралдаа сайндаа нэг, хоёр удаа л орон сууц худалдаж авч байгаа. Гайгүй тохитой орон сууцад амьдрах юмсан гэсэн энэ иргэдийн хүсэл, мөрөөдөл дээр тулгуурласан санаатай залилангийн асуудлууд ч маш их байна. Санаандгүй барилгын салбарын онцлогтой холбоотой, гэрээ эрх зүйн харилцаа нь тэгш бус, мэдээлэл ихтэй барилгын компани мэдээлэл багатай хэрэглэгч, орон сууц захиалагчийн хооронд эрх тэгш байдлыг нь хангаж чадахгүй гэрээний асуудлаас үүдээд хохироод үлдэж байгаа олон иргэд байна.

Цаашид ийм асуудал гаргахгүйн тулд бид аль аль яам нь өөр өөрсдийнхөө амбицыг дараад, хоорондоо уялдаа холбоотой, иргэдийнхээ эрх ашгийг хамгаалсан шийдэл рүү явах ёстой байна гэдэг энэ үүднээс Өргөдлийн байнгын хороо ажиллаж байгаа гэдгийг Та бүхэнд дуулгая.

Ингээд эхлээд Хот байгуулалт, барилга, орон сууцжилтын дэд сайд Самбуугийн Энхболд сайд мэдээллээ хийнэ үү. 10 минутад багтаагаад Та бүхэн мэдээллээ хийнэ үү гэж хүсэж байна. 4 номерын микрофон нээе.

С.Энхболд: Сайн байцгаана уу?

Эрхэм Байнгын хорооны гишүүд, хүндэт зочид оо,

Сүүлийн жилүүдэд орон сууцын барилгын ажил эхэлсэн ч олон жил ашиглалтад орохгүй гацах, зураг төсөл анхны батлагдсан байдлаасаа өөрчлөгдөх, санхүүжилт тасалдах, улмаар захиалагч, хөрөнгө оруулагч, иргэд бодит мэдээлэлгүйгээр эрсдэл хүлээх нөхцөл байдал нэлээд түгээмэл ажиглагдах болсон байна.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар 997 мянган өрхийн 295 мянга нь орон сууцад амьдарч байна.

Тус яамнаас хийсэн судалгаанаас харахад –

- 2021 онд 17 мянга 478 айлын орон сууц ашиглалтад орж байсан бол
- 2025 онд 25 мянга 817 болж,
- орон сууцны ашиглалтад орсон байгаа байдал 47.7 хувиар өссөн байна.

Дээрх судалгаанаас харахад Хан-Уул дүүрэг, Баянзүрх, Сүхбаатар, Баянгол дүүргүүдэд түлхүү баригдсан байна.

Мөн 28 аймгийн статистикийг харахад Орхон аймаг, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймгуудын бүтээн байгуулалт нэлээн түлхүү явагдсан байна.

Тус яамнаас зөвшөөрлийн хуульд заасны дагуу барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилга угсралт, өргөх байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх бага, дунд, өндөр, онцгой төлөвлөлттэй барилгын зөвшөөрлийг олгож байна.

Барилгын тухай хуульд заасан төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагуудаар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх эрхлэх тусгай зөвшөөрлийг 2008 оноос “Монголын барилгын материалын үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллагаар, сургалт, үйл ажиллагааг 2014 оноос “Барилгын инженерүүдийн холбоо” төрийн бус байгууллагуудаар, барилгын угсралт, зураг төсөл өргөх байгууламжийн зөвшөөрлүүдийг Барилгын үндэсний ассоциац, төрийн бус байгууллагууд түншлэлийн хэлбэр дээр тус тус олгож байна.

Өнөөдрийн байдлаар тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг License.mn болон MCIC.gov.mn цахим сайтуудаар олгож байна. Тухайлбал, өмнөх системээр зөвшөөрөл авахад дунджаар 21 хоногийг зарцуулдаг байсан бол бид одоо 2-оос 3 хоногт багтаан олгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Барилгын төсвийг аль ч шатад зөвшөөрөл, бүртгэл, хяналтын уялдаа алдагдвал барилга ашиглалтад орох хугацаа гацах эрсдэл үүсдэг. Эдгээрийг шат шатдаа уялдаа алдагдвал дуусаагүй барилгын эрсдэл хамгийн өндөр байдаг.

Барилга байгууламжийг ашиглалтад орох хүртэлх процессыг зураглан үзэхэд техникийн нөхцөл барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл, барилгын зураг төслийн өөрчлөлт, зургийн маргаан, зургийн асуудал анхаарал татаж байна.

Мөн дуусаагүй барилгуудын шалтгаануудыг судалж үзэхэд төсөл эхлэх үед–

- ▶ санхүүжилтийн эх үүсвэр баталгаажуулахгүй,
- ▶ батлагдсан зураг, төсөл нь барилгын явцад өөрчлөгдсөн нь бүртгэлд бүртгэгдээгүй,
- ▶ гэрээний хэрэгжилт сул,
- ▶ хариуцлага шилжих,
- ▶ маргаан удаашрах,
- ▶ хяналтын тогтолцоо сул,
- ▶ газрын эрх зүйн маргаан,
- ▶ зах зээлийн огцом өөрчлөлт,
- ▶ техникийн нөхцөл,
- ▶ дэд бүтцийн асуудал зэргээс шалтгаалж байна.

Барилгын салбарын хяналт шалгалтаар нийт 339 зөрчил илэрснээс 128 зөрчил нь нийслэлд, 211 зөрчил нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Илэрч буй зөрчлүүдийн дийлэнх нь –

- хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө зөрчсөн,
- барилга хоорондын зай хэмжээ,
- нарны тусгал,
- ногоон байгууламж, гадна тохижилтын шаардлага хангахгүй байх,
- зураг, төсөл болон зөвшөөрөлгүй барилгын үйл ажиллагааг гүйцэтгэх зэрэг асуудлууд байна.

Мөн барилгын ажлын чанар, ашиглалтын үеийн аюулгүй байдал, барилгын материалын чанартай холбоотой зөрчлүүд тодорхой хэмжээгээр гарч байна.

Иймд барилгын салбарт зөрчил гаргахгүй байх, чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор төлөвлөлтийн шатаас эхлэн сургууль, цэцэрлэгийн хүртээмж, барилгын материалын чанар, краны аюулгүй байдал, орон сууцын ашиглалтыг сайжруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга аргамжаа авч хэрэгжүүлж байна.

Одоогийн нөхцөлд иргэд –

- ▶ “зураг, төсөл батлагдсан эсэх”,
- ▶ “барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөлтэй эсэх”,
- ▶ “магадлал” зэргийг хүлээн авч чадаж байгаа боловч –

- ▶ төслийн санхүүжилтийн бодит байдал,
- ▶ техникийн нөхцөлийн хангалт,
- ▶ газрын маргаан –

-зэрэг эрсдэлтэй холбоотой чухал мэдээллийг ихэнхдээ мэдэх боломжгүй байгаа байдал юм.

Иймд захиалагчийн эрхийг хамгаалах зорилгоор барилгын төслийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, зөвшөөрөл, зураг төсөл, техникийн нөхцөл болон төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй чиглэлд анхааран ажиллах шаардлагатай байна.

Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд барилгын үйл ажиллагааны эрхлэх зөвшөөрөлгүй, зураг, төсөл нь батлагдаагүй, газар ашиглах эрхгүй, техникийн нөхцөл нь бүрдээгүй зэрэг шаардлагыг хангаагүй тохиолдолд барилгын төсөлд хөрөнгө татан төвлөрүүлэхийг хориглох заалтыг тусгаж, ингэснээр захиалагч, хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах, барилгын чанар, аюулгүй байдлыг хангах, зөвшөөрөлгүй барилга болон эрсдэлтэй төслүүдээс үүдэх хохирлыг бууруулах зорилготой.

Мөн Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох байгууллагатай хамтран барилгын тухай, Орон сууцын тухай зэрэг хууль тогтоомжид зарим зохицуулалтыг тусган ажиллаж байна.

Энэхүү харьцуулалтаас харахад Бүгд Найрамдах Солонгос Улс, Сингапур Улс, Япон, Солонгос, Герман, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг улсуудад барилгыг эхлэхээс нь өмнө –

- санхүүгийн баталгаа,
- хатуу магадлал,
- шаталсан хяналтын тогтолцоог –

-нэвтрүүлснээр захиалагчийн эрхийг хамгаалж, дуусаагүй барилгын эрсдэлийг бууруулж байгаа бол Монгол Улсад ийм зохицуулалт сул байгаа. Дуусаагүй барилгын асуудал давтагдах нөхцөлийг бий болгосоор байна.

Цаашид дуусаагүй барилгын асуудлыг бууруулахын тулд урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх, салбарын оролцогчдын хариуцлагыг тодорхой болгох, зогссон барилгын нэгдсэн бүртгэлийг бий болгох, эрсдэлийн ангилалд суурилсан шийдвэр гаргах замаар иргэд болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. С.Энхболд дэд сайдад баярлалаа.

Одоо энэ асуудлаар Б.Энхбаяр сайдыг дуудаарай. Сая энд сууж байсан.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “...барьж дуусаагүй барилгын эрх, эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд уг барилгад хөрөнгө оруулсан иргэн, хуулийн этгээд буюу захиалагч нь урьдчилсан тэмдэглэл хийлгэж болно.” гэсэн заалтын хэрэгжилтийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын, Б.Энхбаяр сайдын мэдээлэл байна.

Дуудаарай. Б.Энхбаяр сайдыг. Тэр хооронд ирж оролцож байгаа албан тушаалтнуудаа танилцуулж байя.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр одоо ороод ирэх байх.

Хууль зүй, дотоод хэргийнхэн байгаа юм уу? Энэ дээр орж ирсэн юм уу? Манай ажлын албанаас. Дандаа барилга, нийслэлийнхэн л байх шиг байх юм. Хууль зүйн яамныхныг оруулаадхаач. Улсын бүртгэлээс байна уу?

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням ирсэн байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын албан үүргийг түр орлогч Д.Болормаа ирсэн байна.

Сайдыг дуудаарай. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын дэд сайд С.Энхболд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудиторын газрын дарга Б.Найрамдал, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батзориг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Барилга, барилгын материалын бодлого зохицуулалтын газрын Материал үйлдвэрлэлийн хэлтсийн шинжээч Б.Хосбаяр ирж оролцож байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын дарга Г.Баярсайхан, нийслэлийн Хяналт шалгалтын газрын дарга Б.Энхбаяр, нийслэлийн Орон сууцны бодлогын газрын Орон сууцын дэд бүтцийн хэлтсийн дарга Г.Ганхүү, нийслэлийн Хяналт шалгалтын газрын барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч З.Ганбат, нийслэлийн Хууль, эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Сарангэрэл нар оролцож байна.

Ингээд Эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой 31.2 дахь хэсгийн хуулийн хэрэгжилтийн талаар Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр таныг мэдээллээ хийнэ үү гэж урьж байна. 10 минут.

Танилцуулгатай байгаа билүү? Танилцуулгыг нь гаргаарай.

Б.Энхбаяр: Баярлалаа. Энэ орон сууцтай холбоотой ер нь залилангийн гэмт хэрэг ихсэж байгаатай холбоотой хууль, эрх зүйн шалтгаан, нөхцөлийн асуудал 10 жилийн өмнө бас яригдаж байсан.

10 жилийн өмнө 2016 оны 11 сард Улсын бүртгэлийн багц хууль Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн баригдаж байх үед энэ дуусаагүй барилгыг давхар барьцаалж захиалагч иргэдийг хохироож байгаа асуудлыг хаахын тулд Бүртгэлийн багц хуульд бас өөрчлөлт орж ирж байсан.

Тэгээд би тэгээд шууд л хэлье. Тэр заалтыг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад хассан байгаа. Яагаад гэхээр Улсын Их Хурал дээр маш олон барилгын компанийн төлөөллүүд байсан.

Тэгэхээр энэ барилга, орон сууц барилгын компаниудын бас гол санхүүжилт босдог асуудал бол энэ дуусаагүй барилгаа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлээд тэгээд тэрийгээ гэрчилгээгээ банк, санхүүгийн байгууллагад барьцаалж санхүүжилт олгодог.

Тийм учраас барилгын салбар энэ эрсдэлд орох нь гэдэг үндэслэл ярьж хасаж байсан юм.

Одоо ингээд 10 жилийн дараа эргээд авахад залилуулж хохирсон иргэдийн тоо бол үлэмж нэмэгдсэн ийм дүн байдалтай байж байна.

Тухайн үед би бас Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ажиллаж байхдаа нэгэнт Их Хурлын гишүүдийн санал гаргах эрх, хууль тогтоох эрх байсан. Би зориуд протоколд бас тэмдэглүүлж байсан.

Үүний үр дагавар их олон болно шүү. Их олон иргэд хохирно шүү гэдгийг би зориуд протоколд тэмдэглүүлж байсан. Оршил болгоод би энэ үгийг хэлж байгаа юм.

Тийм учраас энэ бол нэг их төр, засаг мэдээгүй, хайхрахгүйгээс болж ийм асуудал үүсээгүй шүү гэдгийг би урьдчилж хэлэх гэж байгаа юм.

Одоо ер нь эрх зүйн орчны хувьд ямар байгаа вэ гэхээр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-д барьж дуусаагүй үл хөдлөх хөрөнгийг хоёр болон түүнээс олон этгээд хөрөнгө оруулан барьж байгаа тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээр, 31.2-т барьж дуусаагүй барилга улсын бүртгэлд бүртгэгдсэн тохиолдолд уг барилгад оруулсан иргэн, хуулийн этгээд урьдчилсан тэмдэглэл хийлгэх боломжтой байгаа юм.

Одоо энэ дуусаагүй барилгын бүртгэл нийт улсын бүртгэлд 2340 дуусаагүй нийтийн зориулалттай орон сууцын барилга бүртгэлтэй байна. Үүнээс 274 нь бүрэн ашиглалтад орсон байна.

Энэ дуусаагүй барилга барьцаалагдаж байгаа тоон дүнг Та бүхэнд харуулж байна. Жил ирэх тутам нэмэгдэж байгаа. Энэ барьцаалбар.

Хамгийн сүүлд 2023, 2024, 20025 гээд барьцаалбар жил тутам нэмэгдээд яваад байна.

Барьцааны гэрээний нийт үнийн дүн жил бүр ойролцоогоор 47-гоос 50 тэрбум төгрөгийн хооронд байна.

Тэмдэглэлийг Та бүхэн харж байна. Урьдчилсан тэмдэглэлийн тоо өсөж байгаа. Нийт захиалгын гэрээтэй харьцуулахад иргэд гэрээгээ улсын бүртгэлд бүртгүүлэх түвшин харьцангуй бага байна. Өөрөөр хэлбэл шинэ орон сууцын захиалга өгөөд орон сууц захиалж байгаа иргэд маань тэр гэрээгээ улсын бүртгэлд бүртгүүлж өөрийнхтэйгөө эрх зүйн давхар барьцаалж тэр эрсдэлээс хамгаалах эрх зүйн мэдлэг энэ юм дутагдалтай байна гэдгийн тоо энэ шалтгаан, нөхцөлийг эндээс харж болохоор байгаа юм.

Сүүлийн 5 жилд орон сууцын захиалгатай холбоотой залилангийн гэмт хэрэг 2365 бүртгэгдсэн байна. Нийтдээ шүүхээр шийдэгдэж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуудас гарсан 570 хэрэг байна.

Энэ тоон дүн нь 16.7 тэрбум төгрөг байна.

Нөхцөл байдлын хувьд орон сууцын төлбөрийг бүрэн төлсөн боловч улсын бүртгэлд бүртгэгдээгүй захиалагчийн эрх, одоо гэрчилгээгээ авч чадахгүй хохирч байгаа ийм асуудал үүсэж байна. Үүнээсээ болоод орон сууц захиалагч ба барьцаалуулагчийн хооронд эрх зүйн маргаан үүсэж байна.

Шүүх дээр энэ маш хүндрэлтэй байдалд оруулж байна. Сая хэлсэнчлэн 2700 орчим нийтийн орон сууцыг дуусаагүй барилгаа бүртгүүлээд тухайн барьж байгаа хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгж маань банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаалаад зээл авдаг. Объектоор нь. Тэгээд тэр орон сууцдаа иргэдээс орон сууцын захиалга аваад байдаг.

Иргэд орон сууцынхаа төлбөрийг 100 хувь төлчөөд байдаг. Одоо гэрчилгээ нь гарах ёстой. Гэрчилгээгээ авах гээд бүртгэлд очихоор тэр гэрчилгээг нь олгох ёстой объект нь бүхлээрээ банк, банк бус санхүүгийн байгууллагад барьцаа нь байгаад байгаа юм.

Тийм учраас тэр гэрчилгээг гаргахгүй болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл хэрэг дээрээ дуусаагүй барилгын бүртгэл нэг талаас хөрөнгө оруулж барьж байгаа иргэн, барилгын компани, нөгөө талаас орон сууцад захиалж байгаа тэр иргэн хоёрын хооронд маш том эрх зүйн маргааныг бий болгоод байгаа.

Үүнийг тэгээд шүүх шийдэх болохоор шүүх ер нь хэнд нь өгөх юм бэ гэдэг асуудал орж ирж байна. Хэнд нь өгөх юм бэ.

Тийм учраас одоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын хувьд би нэг сард энэ асуудлыг эрх зүйн хувьд иргэдийг хохироохгүй байх чиглэлд хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг яаман дээрээ байгуулж ажиллуулсан. Яаман дээрээ.

- Хуулийн төсөл маань боловсрогдож дууссан.
- Яамныхаа вебсайт дээр байршуулсан.
- Иргэдээс санал авч байгаа.

Нөгөөдөр буюу дөрөв дэх өдөр яамныхаа хурлын зааланд энэ хуулийн төсөлтэй холбоотой олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулах гэж байгаа.

Энэ дээр тодорхой хувилбар танилцуулах гэж байгаа. Хувилбарыг. Ямар хувилбар танилцуулах гээд байгаа вэ гэхээр барьж дуусаагүй барилгыг зураг төсөл, хаалганы дугаар, газрын кадастрын мэдээлэлгүйгээр бүхлээр нь барилгын компанийн өмчийн барьж дуусаагүй үл хөдлөх хөрөнгө гэж бүртгэдэг зээлийн барьцаанд тавьдаг. Бүх барилга улсын бүртгэлд заавал бүртгэгдэхгүй сайн дурын үндсэн дээр явагддаг. Захиалгын гэрээг заавал бүртгэх боломж хязгаарлагдмал байгаа. Бүртгэл, мэдээллийн үнэн зөв, ил тод биш байгаа.

Яагаад гэхээр хотхоноор нь барьцаалдаг. Одоо “А” барилга, “Б” барилга гээд. Тэгтэл энэ бүртгэл дээр болон иргэд, захиалагчдын хооронд жишээлбэл би зүгээр жишээ хэлье.

Ийм хотхоны “А” корпусын дуусаагүй барилга гээд нөгөө барилгын компани маань гэрчилгээгээ аваад банканд барьцаалаад зээл авдаг. Тэгэнгүүтээ нөгөөдхийгөө болохоор улсын бүртгэлд бүртгүүлээд иргэдээс орон сууцын нөгөө захиалга авахдаа нөгөө байрны дугаар өөрчлөгддөг. Дугаараа өөрчилж иргэдээс орон сууцын захиалга авдаг. Иргэн болохоор мэддэггүй.

Одоо тийм “Нар” гэдэг хотхоны “А” гэдэг одоо байрны тэдэн тоот гээд ингээд гэрээ хийдэг. Тэгтэл яг гэрчилгээгээ авахдаа болохоор “Сар” гэдэг хотхоноор ингээд өөр нэрээр. “А” гэдэг корпусаа “А”, “Б” гээд орцоор нь хоёр хуваагаад захиалгуудаа авдаг.

Яг ингээд гэрчилгээгээ авах болонгуут банк бол мэдээж тавихгүй. Хамгийн эхэлж барьцаалсан учраас давуу байдал үүсгэдэг. Иргэний хуулийнхаа дагуу. Хамгийн эхэлж тэр хөрөнгийг барьцаалж зээл олгосон этгээд маань банк, банк бус санхүүгийн байгууллага байдаг.

Нөгөө орон сууц захиалж байгаа иргэд маань болохоор тэр гэрээгээ улсын бүртгэлд бүртгүүлээгүй байдаг. Ингээд шүүх аль талд нь шийдэх вэ гэдэг асуудал.

Тэгэнгүүт энэ дээр хууль, хяналтын байгууллагууд зүгээр ямар асуудал руу ороод байдаг вэ гэхээр энэ яг иргэний эрх зүйн харилцаа байсан юм уу гэвэл уг нь гэмт хэрэг биш. Гэмт хэргийн журмаар шалгагдах ёсгүй. Гэхдээ энэ үнэхээр анхнаасаа санаа зорилготой, иргэдийг залилан мэхэлж хууль бус орлого олохоор сэдсэн, тэр байрны дугаар юмнуудаа ингэсэн байсан гэдэг ийм гэмт хэргийн санаа сэдэлтэй нөхцөл байдал тогтоогдох л юм бол явна.

Түүнээс биш уг нь энэ бол шалтгаан, нөхцөл бас янз бүр байж болно. Жишээлбэл, ялангуяа ковидын үеүдэд бараа, материалын үнэ ихэссэн, хил хаагдсан. Үүнтэй холбоотой маш олон барилгын компаниуд иргэдийн нөгөө хугацаандаа оруулна гэсэн тэр гэрээний үүргүүд хойшилсон. Олон иргэд хохирсон.

Тэгээд энэ хохирогчдын тоо бол одоо үлэмж нэмэгдэж байгаа. Цагдаагийн байгууллагад зохиомол маш их том ачаалал үүссэн байгаа. Маш том ачаалал.

Ингээд нэгэнт хэрэг үүсэхээр юу болоод байна вэ гэхээр... /минут дуусав/

О.Номинчимэг: Б.Энхбаяр сайдад баярлалаа. Мэдээллээ хийлээ.

Ингээд түрүүн оролцож байгаа албан тушаалтны нэрсийг Та бүхэндээ танилцуулсан.

Ингээд энэ асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрсээ өгье. 12 сард бид нар Өргөдлийн байнгын хороон дээр энэ асуудлыг бас хэлэлцэхэд маш олон гишүүд дэмжиж энэ үнэхээр нийгмийн асуудал болсон байна. Манай дээр ирж байгаа ер нь одоо ингээд яг бодлогын шинж чанартай өргөдлүүдийн 80 хувь нь энэ дуусаагүй барилгын орон сууцын захиалгаас болж хохирсон асуудал. Дахиж ийм юм битгий гаргаач ээ л гэдэг юм байгаа юм.

Хоёр гишүүнээр тасаллаа. Ирцээрээ юу? Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Энэ нээрээ бас маш олон иргэд яг энэ асуудлаар ханддаг юм.

Тэгээд яадаг вэ гэхээр нэг байрыг 4, 5 хүнд зарчихсан. Мөн дээрээс нь одоо метр квадратын хувьд зөрүүтэй. Зураг харуулахдаа их гоё зураг харуулна. Яг байшин бариад босоод ирэнгүүт нь цонхыг нь хаагаад, хаагаад ингээд бүр нэг ийм ширэнгэн ой шиг юм хүртэл хийдэгээс авхуулаад зөвхөн мөнгөө өгч алдахаас гадна тэр хүн өөрөө анх гэрээ хийхдээ тэр зураг төсөл юм нь хэд ч өөрчлөгддөг юм. Ийм зүйл маш их байна.

Тэгэхээр энэ тал дээр манай одоо Барилга, хот байгуулалтын яамныхан маань энэ анхны зургийг өөрчилдөг асуудал. Нөгөө талаас нь тэр иргэн ер нь тэр орчинд ийм ийм байрууд баригдахаар төлөвлөгдсөн гэдэг юмыг нь ил тод хардаг, нээлттэй байдаг, хэрэглэгч нарт нь анхааруулж өгдөг ийм зүйл байж болох уу? Ер нь одоо тэгдэг үү? Ер нь яагаад тэгдэггүй юм бэ?

Яг ний нуугүй хэлэхэд манай Яармагийг тийм болно гэж ерөөсөө бодоогүй шүү дээ бас. Эргээд маш олон барилгууд цонхыг нь хаагаад хаагаад дараагийн барилгууд нь баригдаад баригдаад явдаг.

Дээрээс нь бүртгэл хийхэд банкууд тодорхой хэмжээний хөрөнгө мөнгөний эх үүсвэр дутаж байгаа учраас банкнаас зээл авахад үл хөдлөх буюу бас тодорхой хэмжээний хөрөнгөө оруулж байгаа нь нэг талаар аргагүй. Гэхдээ нөгөө талаараа үүнийг чинь буруу талаар нь ашиглаад маш олон иргэдийг залилаад. Сүүлдээ мөнгөө олж авбал тэр юун хүү алданги бол дүүрсэн. 4, 5 жил явна. Дараа нь шүүхийн шийдвэр дээр удна. Тэгээд нөгөө иргэнийг хохироосон хүн нь болохоор сул чөлөөтэй давхиад байдаг.

Тийм учраас одоо яг хохирсон байж байгаа иргэдийн шүүхийн шийдвэр дээр маш их удаг. Яг энэ дээр одоо ял зэм авсан хэчнээн хүн байгаа вэ гэдгийг тодруулж асуумаар байна.

Мөн дээрээс нь иргэд шинээр орох гэж байгаа, захиалах гэж байгаа байруудын тэр цахим үндэстэн юм бол ороод миний энэ барилгын, байшингийн дугаар дээр байгаа байрыг харахад –

— өөр хүнд зарсан байна уу,

- барьцаанд байна уу,
- юу байна вэ гэдэг.

Үүнийг ил тод болгоход ер нь юу нь болдоггүй юм бэ?

Үүнийг одоо хянаж шалгадаг нөгөө хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах субъект гэдэг зүйл энэ барилга захиалагчийн юун дээр байна уу?

Яг ний нуугүй хэлэхэд нэг байрны хотхон хүмүүс нь сүүлдээ хотхон ашиглалтад орсны дараа тийм ч юм нь дутуу, ийм ч юм нь дутуу, тэдэн төгрөг нь ч дутуу, тэнд ч зогсоол газар нь иргэдийнх биш. Байрных нь зогсоолууд нь хүртэл өөр хүмүүсийнх болсон гээд гомдол ерөөсөө тасардаггүй.

Тэгэхээр үүнийг цэгцлэхэд яг юу нь болдоггүй юм бэ? Энэ тал дээр манай Барилга, хот байгуулалтын яамныхан төлөвлөж байгаа. Сая Хууль зүйн сайдын хэлж байгаа ийм ийм хуулиуд байна гэдэг дээр Барилгын яамныхан өөрсдөө яг юу гэж боддог юм бэ?

О.Номинчимэг: Барилгын яам, салбарын яам бодлогоо гаргаж байх ёстой яам юу хийж байна гэж байна. 3 номерын микрофон өгье. Нэр албан тушаалаа хэлээд хариултаа хэлээрэй.

Д.Батзориг: Баярлалаа. Хот байгуулалт, барилга орон сууцны яамны хэлтсийн дарга Д.Батзориг.

С.Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя.

Нэг байрыг олон хүнд зарж байгаа, метр квадратын зөрчлийн асуудал ууд гээд олон асуудлууд байгаа. Эдгээр асуудлуудыг шийдэх хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачлан боловсруулж байгаа Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагалдан –

- Барилгын тухай хууль,
- Орон сууцжуулалтын тухай хууль,
- Орон сууцны дундын өмчлөлийн тухай хууль-

-гэх зэрэг хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулж байгаа.

Тэр өөрчлөлт орж байгаа хуулийн зохицуулалт дээр яг таны саяын хэлсэн одоо бид нар энэ барилга байгууламжийн зураг төслийн магадлал хийх дүрмийг Засгийн газрын хуралдаанаар батлуулсан.

2026 оны 3 дугаар сарын 16-ны өдрөөс хэрэгжиж эхэлж байгаа. Энэ хэрэгжиж эхэлж байгаа магадлалын дүрмээр-

- > загвар зураг,
- > эх загвар зураг,

> ажлын зураг-

гэсэн ийм 3 үе шаттай баримт бичгүүд байхаар болж байна.

Эндээс энэ мэдээлэл нэмж өгөх гэж байгаа санаа нь заавал ажлын зураг дээр магадлал хийхгүй байх ийм хуулийн зохицуулалтад оруулж өгч байгаа. Эх загвар зураг дээр магадлал хийх боломжийг нь олгосон.

Ингэснээрээ нөгөө барилгын компаниуд маань зураг төсөл дээр хугацаа алдахгүй байх, мөн төслийн хэрэгжилтийн хугацаа саатахгүй байх зохицуулалтыг хийсэн.

Энэ эх загвар зураг хувийн хэвшлийн болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төсөлд эх загвар зурагт магадлал хийлгэхээсээ өмнө саяын бид нарын хэлээд байгаа тухайн төслийнхөө барилгуудыг дугаарлах, айлуудаа дугаарлах, метр квадратыг хөдлөхгүй байх энэ зохицуулалтуудыг одоо urban.gov.mn гэсэн мэдээллийн систем рүү шивээд, зураг төсөл батлагдсанаас хойш айлын тоот, метр квадрат, тэгээд айл хоорондын талбайн метр квадрат энд өөрчлөгдөхгүй байх зохицуулалтуудыг уялдуулж хийж байгаа.

Ингэснээрээ тухайн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авснаас хойш энэ зохицуулалт дээр ямар нэгэн зургийн нэмэлт, өөрчлөлт оруулахгүй гэсэн зохицуулалт явагдаж байгаа. Тэгэхгүй болохоор батлагдсан зураг, төслийнхөө дараа айлуудынхаа тоотыг өнөөдрийн байдлаар төсөл хэрэгжүүлэгч компаниуд өөрсдөө өгч байгаа.

Манай хаягжуулалтын тухай хуулийн хүрээнд хаягжуулалтын систем тухайн барилга дээрээ дугаар өгөөд, цаашаагаа айлуудынхаа тоотын дугаарыг өгөхгүй ийм зохицуулалттай юм билээ.

Тэгэхээр бид цаашдаа энэ хаягжуулалтынхаа системтэйгээ айлуудын дугааруудыг уялдуулах.

Мөн тэр urban.gov.mn рүү мэдээллүүдээ оруулснаар улсын бүртгэл, бусад холбогдох төрийн байгууллагууд мэдээллүүдээ солилцох, цаашлаад захиалагч, төсөл хэрэгжүүлэгч, иргэн хоёр хоорондоо гэрээ байгуулаад нотариат дээр очиход нотариат дээр тухайн “А” байрны нэг тоотыг захиалгын гэрээ хийсэн бол тэр маань энэ дундын мэдээллийн сан дээрээ бүртгэгддэг. Нөгөө талаасаа цахим системээрээ иргэд маань тухайн барилгын зөвшөөрлүүд нь ямар нэгэн асуудалтай байна уу, үгүй юу гэдгийг цаашлаад харах ийм нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр хамтраад ажиллаж байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Жирийн иргэн, байр захиалах гэж байгаа хүн энэ байрны тэдэн тоот нь өөр ямар нэгэн банк, санхүүгийн байгууллага болон бусад хүмүүс барьцаагүй, өөр хүнд давхар захиалагдаагүй. Мөн магадгүй заавал иргэн өөрөө

тэр гэрээ байгуулсан бол түүнийг нь хууль, эрх зүйн мэдлэгтэй, мэдлэггүй маш олон хүн байгаа шүү дээ. Заавал бүртгэдэг. Тэгж байж тэр дансны гүйлгээ, мөнгө төгрөгийнх нь асуудал шийдэгддэг ийм юмыг нь хийх асуудал байгаа юу гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт, улсын бүртгэлээс асуумаар байна. 150 метр квадрат, 100 метр квадрат байрууд байна. Моргейжийн зээл авсан. Бүртгэлийг нь аваад үзэхээр гэрчилгээ дээр нь 79 метр квадрат гээд тавьсан. Яагаад ийм зүйл хийгээд байдаг юм.

Үүний чинь цаана яаж байна вэ гэхээр зорилтот бүлгийн маш олон иргэд тэр 60, 70, 40, 50 метр квадрат байр авах гэж байгаа хүмүүс моргейжийн зээл олдохгүй байж байхад банкууд нь манай банкнаас зээлсэн ийм төслөөс зээл авбал моргейжийн зээлд хамруулж өгнө гээд Улсын бүртгэл тэрийг нь 79 метр квадрат... /минут дуусав/

О.Номинчимэг: Улсын бүртгэл хариулах уу? Хууль зүйн сайд хууль, эрх зүйн орчны талаар хариулт өгөөд. Дараа нь улсын бүртгэл тэр асуултад хариулаарай. С.Эрдэнэбат гишүүний.

Б.Энхбаяр: Баярлалаа. С.Эрдэнэбат гишүүн яг гол асуултыг нь хөндөөд байгаа юм.

Хэрвээ иргэдэд тухайн захиалж байгаа байр нь, өөрийнх нь захиалж байгаа байр нь ямар нэгэн банк, санхүүгийн байгууллагад, гуравдагч этгээдэд барьцаалагдсан байна шүү гэдгийг иргэн хүн мэдэх юм бол тэр байрыг захиалах эрсдэлээ иргэн өөрөө хүлээх гээд байгаа юм.

Энэ нь юу хэлж байна вэ гэхээр тэр эрсдэлээс сэргийлэх боломжийг иргэнд нь өгөх тухай яриад байгаа юм.

Үүнийг Улсын бүртгэлийн багц хуулийг 2017 оны хаврын чуулганаар хэлэлцэх үед яг ярьсан юм. Яг энэ асуудлыг.

Өөрөөр хэлбэл барьцаалбарын мэдээллийг нь бүхэлд нь нээлттэй болгоё. Бүртгэлийн мэдээллийг 3 түвшинд ангилж байгаа юм.

- ▶ “Нээлттэй” мэдээлэл.
- ▶ “Хязгаарлагдмал” мэдээлэл.
- ▶ “Хаалттай” мэдээлэл гэж.

“Нээлттэй мэдээлэл” гэдэг бол өөрийнх нь зөвшөөрлийг авахгүйгээр олон нийтэд нээлттэй мэдээлж байгаа энэ мэдээллийг... /минут дуусав/

О.Номинчимэг: Нэмэлтээр юм байна. Тийм үү? 1 минут нэмэлтээр. Хууль зүйн сайдын микрофон.

Б.Энхбаяр: Тэгээд бид барьцаалбарын мэдээллийг “хязгаарлагдмал мэдээлэл” гэдэг ангилалд оруулсан юм.

Өөрөөр хэлбэл яагаад гэхээр тухайн хүний гэр хаягийн мэдээлэл гарах гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр таныг хаана амьдардаг вэ гэдэг мэдээлэл олон нийтэд нээлттэй болохоор “хаягийн мэдээлэл” болчхоод байгаа юм. “Барьцаалбарын мэдээлэл” чинь.

Тийм учраас өөрийнх нь зөвшөөрлөөр гэдэг хязгаарлагдмал ангилалд оруулсан юм.

Хоёрдугаарт, энэ мэдээллийг иргэд. Одоо би бүх иргэдэд хандаж байгаа юм. Та ямар нэгэн байр худалдаж авах, захиалах гэж байгаа бол Та нотариатаас энэ мэдээллийг авч болно шүү.

Нотариат дээр очоод миний энэ захиалах гэж байгаа байр өөр хүнд барьцаалагдсан байна уу гэдэг мэдээллийг нотариат шууд дундын мэдээллийн сангаас ороод иргэнд хэлэхээр бид бүртгэлийн багц хуулиа хуульчлаад яваад байгаа юм. Үүнийг иргэд их сайн мэддэггүй учраас нотариатаас үүнийгээ асууж мэддэггүй. Ингээд давхар хохироод байдаг ийм эрсдэл... /минут дуусав/

О.Номинчимэг: 7 номер. Улсын бүртгэлийн газар.

Д.Давааням: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Давааням.

Нийтийн зориулалттай орон сууцын хэмжээ өөрчилж ипотекийн зээл, моргэжийн зээлд хамруулдаг асуудлууд улсын бүртгэлд өөрчлөлт оруулж бүртгэл хөтлөх тухай асуудал байгаа.

Орон сууцын барилгын анхны зураг төсөл буюу магадлан итгэмжлэгдсэн зураг төсөл, дээрээс нь эрх бүхий хэмжилтийн компанийн дахин хэмжилт хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн үл хөдлөх хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулж бүртгэдэг. Нотлох баримтыг үндэслэж.

Ашиг сонирхлын болон гэмт хэргийн шинжтэй бүртгэлийн асуудлуудыг хууль хяналтын байгууллагууд шилжүүлэн шийдвэрлүүлдэг байгаа.

Гэхдээ ийм бүртгэл улсын бүртгэл дээр мэдээллийн санд авагддаггүй. Улсын бүртгэл бол түрүүний хэлснээр орон сууцын хэмжээг хэмжилтийн компанийн дүгнэлт, анхны магадал, итгэмжлэгдсэн зураг. Дээрээс нь улсын комиссыг... /минут дуусав/

О.Номинчимэг: С.Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр үүнийг манайх хийдэг үү гэхээр улсын бүртгэл нь барилгын магадлан итгэмжилсэн нэг хувийн компанийн магадлан итгэмжлэлийг үндэслээд бүртгээд байдаг юм байна шүү дээ. Тийм үү?

Тэгэхээр магадгүй одоо бидний зорилтот бүлэг моргейжийн зээлийг зорилтод дундаж улам бага орлоготой иргэдэд хүргэе гэхээр энэ хөтөлбөр чинь хүрэхгүй болчихоод байгаа юм

Тийм учраас үүнийг одоо тэр энэ гэхгүйгээр давхар нягталдаг шалгадаг. Энэ чинь цаанаа ашиг сонирхол байгаа шүү дээ. 120 метр квадратыг 79 болгоод бүртгээд байна гэдэг чинь.

Тийм учраас энэ цаанаа ийм сөрөг үр дагавар гараад байгаа учраас би энэ тал дээр л улсын бүртгэл маань давхар анхаарал хандуулж, тэр хууль, эрх зүйн хувьд нь өөрчлөлт юм оруулахгүй бол болохгүй байна гэж л талаас нь хэлэх гээд байгаа учраас үүнийг асуусан юм.

О.Номинчимэг: Саналаа ерөнхийдөө хэллээ. Тийм ээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Зүй ёсны асуудал ор ж ирж байгаад баяртай байна.

Ер нь манай иргэд байр худалдаж авах биш эрсдэл худалдаж авдаг л болсон л доо. Яг өнөөдрийн нөхцөл байдал дээр.

Санхүүжилтийн баталгаагүй барилгууд ихээр баригдаж байгаа. Үүнтэй холбоотой эхэлж гэрээг нь байгуулж мөнгийг нь аваад тэр мөнгөөр нь байшин бариад хангалттай мөнгө цуглавал хангалттай хурдан баригдана. Мөнгө цуглахгүй бол тэгээд хэдэн он жилээр уддаг ийм процесс өнөөдөр ч үргэлжилж байгаа.

- Зураг төсөл анх үзүүлээд тэр зураг төслийг нь аваачаад өөрчлөөд хаядаг. Дураараа. Ийм асуудлууд байна.
- Зөвшөөрөл хяналтын уялдаа холбоо алдагдаж байгаа ийм асуудал байна.
- Иргэд бодит мэдээлэлгүйгээр гэрээ хийж байгаа. Одоо нэг ёсондоо харгуйгаар гэрээ хийж байгаа ийм процессууд байна.

Тэгээд энэ асуудлуудыг аль болох шийдэхийн төлөө байгаа болов уу гэж би ойлгож байгаа. Тэгээд ер нь эцсийн эцэст явж явж хохирогчид нь өөрсдөө иргэд болчихоод байгаа, хэрэглэгч болчихоод байгаа.

Тэгээд бид Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль дээр ч гэсэн одоо бас энэ тухай яриад л, хийх гээд л одоо юмнуудыг нь хийгээд л яваад байгаа. Тэгээд энэ зүгээр нэг тийм алдаа биш, хариуцлагын тогтолцооны л асуудал болчихоод байгаа л гэдгийг хэлэх гэж байгаа юм.

Ер нь зөвхөн орон сууцын асуудал биш ээ. Энэ газар сайгүй байна. Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сум дээр 10 жилийн сургууль бариад, ерөнхий боловсролын сургууль бариад 80 хувийн гүйцэтгэлтэй байхад нь улсын комисс хүлээгээд авсан. Улсын комисс шүү дээ. Төрийн албан хаагчид.

Булган аймгийн Хишиг-Өндөр сум дээр мэдээлэл, харилцаа холбооны тэр төрийн өмчит компани нэг байшин бариад тэр чигт нь хаясан. Одоо ч хаягдсан байгаа. Тэгээд энэ өөрөө төрөөс улбаатай асуудал л даа.

Би одоо Та бүхнээс нэг маш тодорхой юм асуух гэж байгаа юм. Хууль зөрчсөн, санхүүжилт нь баталгаагүй, зөвшөөрөл дутуу барилгын төслүүдийг яг бид хэзээнээс зогсоож чаддаг болох вэ?

Авлига хороолол гэж нэрлэгддэг энэ одоо яг хууль ёсных мөн юм уу, биш юм уу? Энд гэрээ байгуулсан иргэд тэр Авлига хорооллын байранд орж чадах юм уу, чадахгүй юм уу? Үл хөдлөх. Одоо манай улсын бүртгэлийнхэн байх шиг байна. Энэ авлига хорооллын байр гээд яригдаад байгаа энэ байшин яг улсын бүртгэлийн гэрчилгээ авч чадах юм уу, чадахгүй юм уу?

Тэгээд ийм хууль зөрчсөн үйлдлүүдтэй холбоотой барилга, байшингийн асуудлуудаа хэдүүлээ яг хэзээнээс яаж шийдвэрлэж дуусах юм бэ гэдгийг би улсын бүртгэл, Барилга, хот байгуулалтын яам хоёроос асуух гэж байгаа юм.

Хоёрдугаарт, хот төлөвлөлтийн зөрчилтэй холбоотой асуудлууд байгаа.

— Урд нь байшин барихгүй гээд л байшин барьдаг.

— Хажуу талд нь байшин барихгүй гээд л байшин барьдаг.

Ногоон байгууламж байхгүй, сургууль цэцэрлэг байхгүй, барилга хоорондын зай байхгүй. Тэгээд энэ хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө зөрчсөн барилгын асуудлуудыг ер нь цаашдаа бид яаж шийдэх юм.

Одоо тэр авлигал хороолол гээд яригдаад байгаа газар чинь усан дээр очоод барьсан шүү дээ. Туул гол дээр. Усан парк барина гэж хэлж байгаад барилга барьсан асуудал.

Тэгээд энэ холбогдох төрийн албан тушаалтнууд нь өөрсдөө иргэдийг хохироох үндэслэл суурийг тавиад байгаа. Үүнийгээ бид нар яаж шийдэх юм гэдэг дээр би хариулт авмаар байна. Эхлээд. Тэгээд тодруулъя.

О.Номинчимэг: Барилгын яам уу? Хэдэн номер вэ? Хэн хариулах вэ? 3 номер.

Д.Батзориг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Дуусаагүй барилгын асуудал үндсэндээ маш олон төрийн байгууллагууд нэлээн хамтарч үр дүнг нь үзэх ийм зохицуулалт эрчимтэй хийгдээд явж байгаа.

Энэ дуусаагүй барилгын асуудлын хүрээнд мэдээж улсын комиссын асуудлууд байна. Тэгээд хууль зөрчсөн, санхүүжилтийн асуудлаас болоод барилга, байгууламж нь цаг хугацаанд орохгүй байгаа гэх мэт олон асуудлууд байгаа.

Барилга хоорондын зайг мэдээж холбогдох хот төлөвлөлтийн норм дүрмээрээ заасан. Мэдээж барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл маань барилгын тухай хуулийнхаа дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх байдаг.

Тэгэхээр нийслэлээс хууль зөрчилтэй холбоотой, улсын комисстой холбоотой зарим асуудалд нэмэлт хариулт өгөх байх гэж бодож байна.

Мэдээж цаашдаа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас Барилгын тухай хуулийг Барилгын ерөнхий хууль гэдэг нэрээр шинэчлэн боловсруулах ажил үргэлжлээд явж байна.

Энэ хүрээнд бид Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Барилгын ерөнхий хуулийн төсөлтэй яг энэ хариуцлагын тогтолцоог маш сайн нэвтрүүлэхээр зааж өгсөн.

Өнөөдрийн эрх зүйн баримт бичгийнхээ хүрээнд 5-аас 10 сая төгрөгийн торгууль ногдуулах хэмжээний зөрчил байгаа. Санкцууд л байгаа. Зөрчлийн хуулиараа.

Тэгэхээр бид Барилгын тухай хууль дээр ямар ямар холбогдох хариуцлагын тогтолцоонуудыг нэвтрүүлж байгаа гэж дурдахад эрүүгийн хариуцлагууд руу оруулж ирж байна. Зөрчлийн хариуцлага, Төрийн албаны тухай хуулийн хариуцлагуудыг нэлээн олон санкцуудыг оруулж ирж байгаа.

Зөвшөөрөлгүй барилга барьсан, барилга хоорондын зайг зөрчиж зөвшөөрөл олгосон төрийн албан хаагчид нь хүртэл ямар арга хэмжээ авах вэ. Тухайн ажлыг гүйцэтгэсэн, зураг төслийг зохиосон инженерт нь хүртэл ямар арга хэмжээ авах вэ гээд хүнтэй нь, компанитай нь, бүх талуудтай нь холбогдох хариуцлагын тогтолцоог илүү сайжруулах бичиг баримтуудыг бүрдүүлээд хаврын чуулганд энэ хуулийнхаа төслийг өргөн барихаар ажиллаж байгаа.

Нийслэлээс нэмж тодруулж хариулт өгөх байх аа.

О.Номинчимэг: Тийм. Д.Батзориг дарга аа. Барилгын яам өмнөх олон л бас асуудал байсан байх.

Тэгээд энэ барилгын хууль тогтоомж чинь шинэчлэгдэх үү? Хариуцлагын асуудал хаана хаанаа байхгүй. Бодлогын яам гэж уг нь та хэдийг хараад байгаа. Гэхдээ бодлого ерөөсөө гарахгүй байгаа.

Энэ 2024 онд парламент байгуулагдсанаас хойш Барилгын хууль, Орон сууцжуулалтын тухай хууль, Орон сууц ашиглалтын тухай хууль хийнэ гээд л яваад л байсан.

Би хүртэл аргаа ядаад СӨХ-ны хууль санаачлаад явах гэхээр Орон сууц ашиглалтын хууль бид хийж байгаа. Давхардана гэдэг юм яриад л больсон.

Одоо ингээд 2 жил болох гэж байна. Наад хууль чинь яасан боловсруулагдаж дуусдаггүй юм бэ? Тэгээд Та бүхэн дээр барилгын хяналт чанарын асуудал, энэ норм стандарт яагаад энд алдагдаад байгаа. Үүнийг засах бодлогоо оруулж ирэхгүй бол иргэд л хохироод байна шүү дээ.

Тэгээд Э.Бат-Амгалан сайд сандал суудлын хэрүүл хийхгүй энэ бодитой хохирч байгаа иргэдийнхээ асуудлыг шийдэх асуудал дээр анхаармаар байгаа байхгүй юу. Танай яамнаас нэг ч хууль Улсын Их Хурал дээр орж ирэхгүй байна. Яасан удаан ажилладаг хууль юм бэ? Бүхэл бүтэн яам шүү дээ. Хувь гишүүн биш. Үүнийгээ хурдан анхаарч хиймээр байна.

Одоо улс төрийн хэрүүл тэмцэл энэ тэрээ боль. Бодитой иргэдэд хүртээмжтэй ажлаа хиймээр байна. Тэгээд л нэг сандал суудал болохоор бөөн хэрүүл тэмцэл.

Нийслэлээс хэн хариулах вэ? Хариулахгүй юм уу? Хууль зүйн сайд Б.Энхбаяр нэмэлт хариулт.

Б.Энхбаяр: Энэ Хот байгуулалтын тухай хууль чинь 2022 онд орж ирсэн байх. Улсын Их Хуралд. 2022 он шиг санаж байна.

Тэгээд түрүүчийн парламентын үед 2 жил дарагдаад, хэлэлцэх эсэхийг нь шийдээд ажлын хэсэг гаргаад тэгээд батлагдахгүй байсаар байгаад 2024 онд буцаад Засгийн газар луу буцаагдсан юм.

Энэ Хот байгуулалтын хууль бас дангаараа гарах ёстой хууль биш юм билээ. Газрын багц хуультай цуг гарах ёстой. Яагаад гэхээр барилга байшин бол газар дээр баригдана. Газар дээр. Тэгтэл газар дээр би наад захын жишээ ярья. Газар эзэмших, ашиглах хугацаа маань өөр байгаа.

Тэгэхээр Засгийн газар дотроо ярьж байгаа. Дөнгөж өчигдөр Барилгын хууль, Хот байгуулалтын хуулийн үзэл баримтлалыг Хууль зүйн сайд, Барилгын сайд хоёр хамтарч баталсан. /минут дуусав/

О.Номинчимэг: Тэгээд 2022 онд боловсруулсан хууль жоохон өөрчлөлт ороод одоо л орж ирэх гэж байгаа юм байна.

Үзэл баримтлал бол батлагдсан юм байна. Яаралтай оруулж ирье ээ. Одоо энэ ард иргэддээ үр дүн гаргах хуулиа хэлэлцэхгүй бол одоо энэ ер нь Та бүхэн ч гэсэн, төрийн албан хаагч ч гэсэн ямар нөхцөл байдалтай байгааг харж байгаа биз дээ.

Өнөөдөр бас л ирц хүрэхгүй гээд л Хүний хөгжлийн Байнгын хороо хуралдаж чадаагүй байна. Манай Өргөдлийн байнгын хорооны гишүүд бол хамаагүй ийм одоо идэвхтэй байдгийн хувьд ингээд манай Байнгын хороо л байж байна.

Энэ асуудлууд чинь яагаад тэгвэл мэргэжлийн Байнгын хороод дээр ерөөсөө яригдахгүй байсан юм.

Б.Энхбаяр сайд хэлж байна шүү дээ. Тэгээд өмнө нь энэ уг нь хууль хийх гэсэн чинь үүнийг ингээд байхгүй болгосон юм. Бид нар мэдэхгүй биш мэдэж байсан юм гээд. Тэгээд мэдээд 10 жил болсон байна шүү дээ. Энэ дээр эс үйлдэхүй л хийж байсан байна шүү дээ.

Тэгээд үүнийг чинь ерөөсөө эс үйлдэхүй болохгүй энэ асуудлаа шийдье гээд л энэ парламент чинь уг нь яваад байдаг. Тэгтэл тэрэнд энэ улс төрийн хэрүүл тэмцэл нь ерөөсөө энэ ажлуудаа явуулахгүй байдаг.

Энэ дээр энэ манай сайд нар бас анхаармаар байгаа юм. Нийслэлээс билүү. Авлига хороололтой холбоотой асуулт дээр. Авлига хороолол билүү, юу билээ. Акуа Гарден билүү. Тийм ээ. Энэ дээр хяналтын асуудал юу болсон бэ. Яагаад энэ чинь ингээд явчхав гэдэг дээр үл хөдлөхийн гэрчилгээ одоо гарах юм уу? Б.Энхбаяр сайд бүгдээрэн дээр нь хариулах гээд байна уу? Нийслэлийнхэн яачхаач. Нийслэл дээр энэ чинь харьяалагдаж байсан биз дээ?

9 номер. С.Энхбаяр дарга. Хяналтын дарга.

С.Энхбаяр: Өдрийн мэнд гишүүд ээ.

Авлига хороолол гэх энэ хорооллын хувьд төвөгшлийн хувьд Нийслэлийн хяналт шалгалтын газрын харьяанд байхгүй.

16-аас дээш давхартай өндөр төвөгшилтэй барилга учир энэ Барилга, хот байгуулалтын яамны харьяаллын асуудал байгаа. Нийслэлийн хяналт шалгалтынх бол Улсын комисс хяналт бол ерөөсөө цэвэр, бага, дунд, төвөгшилтэй орон сууцын барилга, байгууламж дээр хяналтыг хэрэгжүүлж улсын комиссын үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Тэгэхээр Барилгын яам хариулна.

О.Номинчимэг: Барилгын яам аа? Тэгээд л одоо бие бие рүүгээ шиддэг. Та нарын яг одоо дүр төрх ийм л байна л даа. Айн. Яах юм? Б.Бат-Эрдэнэ гишүүн.

3 номер. Өндөр өндөршилтэй барилга.

Д.Батзориг: Барилгын тухай хуулийн 20.2, Барилгын тухай хуулийн 32.1.5-д заасны дагуу 51 метрээс дээш өндөртэй барилга, байгууламжид хамаарч байгаа. 16 давхраас дээш барилга бол манай яаманд хамаарч байна.

Барилгын тухай хуульд заасны дагуу барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг Зөвшөөрлийн хуулийн дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга олгож байгаа. Ашиглалтад оруулах үйл ажиллагаа нь манай яам ашиглалтад оруулахаар манай яаманд хүсэлт ирүүлсэн байгаа.

Одоогоор яг ашиглалтад оруулах үйл ажиллагаатай холбоотой комиссын тушаал шийдвэр албан ёсоор гараагүй байна.

О.Номинчимэг: 3 номер. Комисс ажиллах юм уу? Ашиглалтад авах юм уу? Хууль, дүрэм журмынх нь дагуу ямар байгаа юм гэдэг дээр 3 номер.

Д.Батзориг: Комисс ажиллах ажиллахгүйтэй холбоотой манай хуулийн байгууллагууд, хуулийн хэлтсийнхэн холбогдох шүүхийн шийдвэр, Авлигатай тэмцэх газрын холбогдох зөвлөмжүүдийг авахаар ажиллаж байгаа.

Тэгээд барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа зохион байгуулахад ямар нэгэн эрх зүйн асуудал байна уу, үгүй юу гэдэг дээр зөвлөмж гаргаад тэгээд тэрнийхээ дагуу ажиллах байх.

Яг би бол өнөөдөр ажиллах ажиллахгүйг нь бол хэлж мэдэхгүй байна.

О.Номинчимэг: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Таны асуулттай холбоотой л хариултууд яваад байна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ уг нь миний 1 минут явах гээд байгаа байхгүй юу. Уг нь хариулмаар байгаа байхгүй юу та нар.

Тэр Авлигатай тэмцэх газар гэхээс илүү та нар тэр байгаль экологийнх нь үнэлгээтэй холбоотой асуудлыг л та нар үзэх ёстой биз дээ.

Сая Б.Энхбаяр сайд хэллээ шүү дээ. Газаргүй барилга гэж байхгүй. Тэр газрынх нь тухай барилга баригдаж болох юм уу гэдгийг та нар тодорхойлох ёстой шүү дээ. Бодлого барьж байгаа яам нь. Тэгээд ингээд бие биеэсээ шийдээд байх юм. Эсвэл та нар бүгдээрээ авлига авсан юм уу? Үгүй үгүй, инээдэм биш байхгүй юу даа. Тэнд хэдэн барилга боссон байгаа билээ? Та мэдэж байгаа юу? Хэдэн иргэн тэнд хохирох гээд байна гэдгийг л би асуугаад байгаа юм. Тэрийг л маш тодорхой хэлээд өгөөч ээ.

Тэгээд миний одоо уг нь тодруулгын 1 минутыг хасмаар байна. Би түрүүнийхээ асуултад л хариулт авмаар байгаа байхгүй юу. Тэгээд тодруулга дээр өөр юм асууя гэсэн чинь ингээд бие бие рүүгээ бухсаар байгаад энэ хүмүүс чинь асуудал өнгөрөх гэж байна шүү дээ.

Иргэд, эцсийн эцэст хэрэглэгч нар иргэд хохироод байгаа учир шалтгаан та нар өөрсдөө болчихоод байна шүү дээ. Та нар ийм үлбэгэр, ийм хариултгүй, ийм айсан, ийм байж болох юм уу?

О.Номинчимэг: Хэн хариулах юм? 4 номер. Дэд сайд.

С.Батболд: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Ер нь энэ “Акуа Гарден” гэж хотхоны зөвшөөрлийг хууль ёсны дагуу бүгдийг нь бүрдүүлээд анх барилгын ажлаа эхэлсэн юм билээ. Тэгээд явцад нь газар, бусад тэр усны сав газар, Туулын бэлх, янз бүрийн асуудлууд гарч ирээд тэгээд хэн нь ямар хариуцлага, одоо юу хийх тухай тодорхой ямар ч шийдэл байхгүй.

Өнөөдөр тухайн барилгаас одоо нийт барилгын 85 хувь нь борлогдсон гэсэн мэдээ бидэнд ирсэн байгаа.

Тэгэхээр тэнд хэчнээн хохирогч гарах нь ийм асуудал үүсээд иргэдийн мөнгөөр барьсан барилга гэж ойлгогдохоор ийм хэмжээнд хүрсэн байгаа юм.

Хууль, шүүхийн байгууллагаар гомдол, өргөдөл бусад Авлигатай тэмцэх газрын шийдвэрүүд удаашралтай байгаагаас... /минут дуусав/

О.Номинчимэг: Хууль зүйн сайд Б.Энхбаяр тодруулга өгнө.

Б.Энхбаяр: Энэ авлига хороолол байна шүү дээ. Энэ манай Газрын хууль, Барилгын хуулийн зөрчилдөөний одоо зүгээр нэг л жишээ шүү дээ.

Одоо манай Газрын хууль, Тусгай хамгаалалттай газрын хууль хоёр тусдаа. Газрын хууль нь болохоор хүмүүс ойлгохдоо хот суурин газрын хууль гэж ойлгоод байх шиг байгаа юм.

Тэгэнгүүт яг Туул голоос Богд уул хүртэлх хэдэн их наядын хөрөнгүүд чинь “Отог” гэдэг газрын зөвшөөрөлтэй байгаа шүү дээ. Газрын зөвшөөрөл нь. Энэ дээр хэдэн тэрбум, их наядын хөрөнгө байгаа. Хүмүүсийн.

Тэгэхээр хуулиа бид эхлээд л янзлах ёстой.

Тийм ч учраас би өмнө нь ярьж байхад Газрын багц хууль гээд 5 хууль өргөн барьсан байсан юм. Буцаагдаад байгаа байхгүй юу. Буцаагдаагүй. Энэ Ц.Даваасүрэн сайд татаад авсан юм.

О.Номинчимэг: Газрын багц хууль маш чухал гэдгийг бас энд ойлгож байгаа. Одоо уг нь үнэхээр өөрчлөлт, шинэчлэлт авчиръя. Бодлогоо ярьж бодлогын шинэчлэл хийе гэж байвал энэ мэт хуулиа л бид уг нь оруулмаар байгаа юм. Тийм ээ.

Б.Бат-Эрдэнэ гишүүний сүүлчийн тодруулга.

Б.Бат-Эрдэнэ: Барилга, хот байгуулалт. Манай дэд сайд албан ёсоор Та мэдэгдлээ шүү. Үгэндээ хариуцлага хүлээлгээрэй. Хуулийн дагуу явж байсан. Явцын дунд ус гарч ирсэн гээд. Та бол дэд сайд хүн шүү. Явцын дунд ус гарч ирээгүй шүү. Ус чинь байсан юм. Туул гол. Угаасаа байсан гол байхгүй юу.

Хууль ёсны дагуу авсан эсэх чинь маш олон хууль тогтоомжуудыг зөрчсөн үйлдэл байгаа. Намайг сайд болж байхад 3 давхар явж байсан юм. Тэгээд би зогсоо гэдэг чиглэлийг нийслэл рүү хэлээд энэ болохгүй гэдгийг нь хэлээд тухайн үед бөөн юм үүсээд одоо баригдаад дууссан байгаа. Та энэ үгэн дээрээ хариуцлага хүлээгээрэй гэж хэлэх гэж байгаа юм.

Хоёрдугаарт, сая Б.Энхбаяр сайдын хэлэх гэж байсныг би сүүлд нь хэлэх гэж байсан юм. Яг отоглох. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль. Өндөр барилгууд баригдсан.

2013 онд Нийслэлийн Засаг даргаар ажиллаж байсан Э.Бат-Үүл Нисэх, Яармагийг хөгжүүлэх төлөвлөгөө гаргаад 2014 онд дэд бүтцийг нь татуулаад, 2015 онд стандартаас өндөржилтийг нь авч хаяснаар энд барилгажсан байхгүй юу.

Одоо бид эд нарыг яах вэ гэдгийг Барилга, хот байгуулалтын яамнаас... /минут дуусав/

О.Номинчимэг: Энэ дээр Барилга, хот байгуулалтын яам хариулах уу? Үүнтэй холбоотой өргөдөл бас манай Байнгын хороон дээр нэлээн их ирсэн байгаа. Барилгын яамнаас хэн хариулах вэ? 3 номер. Д.Батзориг дарга.

Д.Батзориг: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Өнөөдрийн байдлаар “отоглох” гэдэг үгтэй холбоотой асуудал Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд зохицуулсан ийм олон улсын конвенцын хүрээнд зохион байгуулж, зохицуулж байгаа үг, хэлбэр юм билээ.

Мэдээж тухайн газрын зориулалт нь “отоглох” гэсэн зориулалттай боловчиг дээр нь барилга барих хүсэлт ирсний дагуу манай аймаг, нийслэлийн Засаг дарга нар барилгын ажлын зөвшөөрөл өгөөд цаашлаад ашиглалтад оруулах үйл ажиллагаа явагдаад байгаа юм.

Тэгэхээр Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд газрын зориулалтыг нь мэдээж манай Газрын харилцаа, геодези, зураг зүйн ерөнхий

газартай хамтраад энэ асуудлыг Газрын хууль дээрээ шийдвэрлэвэл боломжтой гэж харж байгаа.

Манай Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хүрээнд барилга барих үйл ажиллагаа нь хамаарчхаад байгаа юм. Ашиглалтад оруулах хүртэл.

О.Номинчимэг: Энэ асуудлаас үүдээд бас оршин суугч, тэр хавьд байр аваад амьдарч байгаа хүмүүст маш их хохирол учирч байгаа юм билээ шүү. Төлөвлөлтөд орж чадахгүй, төлөвлөгөөгөө гардаж чадахгүй. Яагаад гэвэл “отог” гээд, “тусгай хамгаалалттай газар” гээд эрх мэдлүүд нь хаана байгаа нь салсан газар дээр нийслэл ч төлөвлөлтөө хийж чадахгүй, түүнийх нь дагуу дэд бүтэц ч хийгдэж чадахгүй болохоор асуудал байна гээд олон иргэд бидэнд хандаж байгаа.

Үүгээр ер нь бид дараа дараагийн Байнгын хороон дээр мэдээлэл, шийдлийг нь ярья гэж бодож байна.

О.Номинчимэг: П.Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Чухал асуудал байна.

Би энэ дээр холбогдох хуулийн төслийг нь санаа зовоод боловсрууллаа. Засгийн газрыг маш удаан хүлээсэн. Яригдаад байгаа газрын багц хуулийг боловсруулсан хүн нь байгаа юм.

5 багц хуулийг боловсруулаад тухайн үеийн Барилгын яамны хүмүүс ерөөсөө ойлгож өгөхгүй.

Харин С.Магнайсүрэн дарга Барилгын яамны Төрийн нарийн бичгийн даргын ажилдаа буцаж ороод 2002 оны Иргэний хуулийн үзэл баримтлалд нийцүүлж энэ газрын хуулийг эрхийн төрлийг зөв болгоё. Хууль зүйн эрх болон гэрээний эрхийн төрлийг зөв болгож байж эдийн засгийн эргэлтэд оруулах юм байна гэдэг зүйлийг хийгээд Газрын багц хуулийг өргөсөн.

Яах вэ, татаж болно. Тэгэхдээ үүнийг буцаагаад Засгийн газар хийх л ёстой. Газрын багц хуулийг татсан шалтгаан нь Хот байгуулалтын хуультай хамт оруулж ирнэ л гэсэн. Одоо дахиад Хот байгуулалтын хуулийг нь дангаар нь оруулж ирээд газрын хуулиудаа хаях гэж байгаа юм байна.

Ингээд алаг цоог явбал асуудал шийдэгдэхгүй байх. Ер нь том зургаараа. Сууриараа.

Тэгэхдээ өнөө маргаашийн яах вэ орон сууц захиалга болон эргээд орон сууц захиалгын гэрээний дагуу орон сууцдаа орох болсон чинь улсын комисс ажиллах эсэх асуудал эргэлзээтэй энэ асуудлыг шийдэхийн тулд би бас Улсын бүртгэлийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон холбогдох 8 хууль болон 1

Улсын Их Хурлын тогтоолыг нэр бүхий гишүүдтэй хамтраад санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн. D-Parliament-д тавьсан байгаа.

Гол агуулга маань ерөөсөө барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл эхлэхэд л урьдчилсан хаяг олгоё гэж байгаа юм.

Урьдчилсан хаяг гэдэг бол цаашаа албажаад явна. Үнэхээр энэ барилга зураг төсвийн дагуу бол одоо нэг орцтой эсвэл хоёр орцтой 48 айлын орон сууц байвал 48 хаяг тэнд олгогдоно гэсэн үг.

Үүнтэй холбоотойгоор техникийн нөхцөлүүд нь олгож байна у, үгүй юу гэдэг нь албан ёсны болно. Тэгэхгүй хүн байр захиалдаг. Дараа нь халуун, дулаанаар хангагдах эсэх нь мэдэгдэхгүй, төлөвлөлтөд орох эсэх нь мэдэгдэхгүй ийм зүйл дээр захиалга хийж болохгүй.

Тэгэхээр анхнаасаа бид дараа нь хөрөнгө оруулагчдын эрх ашиг болоод яг энэ бизнес хийж байгаа хүмүүсийн эрх ашгийг ч гэсэн хохируулж болохгүй. Анхнаасаа зөвшөөрчхөөд дараа нь асуудал үүсэнгүүт нь бүгдийг нь цуцалчхаж чадна.

Тийм учраас энэ асуудлуудыг шийдэх үүднээс урьдчилсан хаягийн асуудлыг оруулж ирж байгаа.

Дээрээс нь тухайн барилгын тухайн тоот дээр ямар хэмжээний захиалгын гэрээ байдаг юм уу, шаардах эрхийг үүсгэсэн гэрээ хэлцэл байгаа юу, өв залгамжлалын асуудал байгаа юу, үгүй юу, барьцаанд тавигдсан уу гэдэг зүйлүүдийг мэдээллийг нягталж шалгах тэр бололцоог олгоё гэж байгаа.

Үүнтэй холбоотойгоор барьцаанд тавигдсан хэсгээр буцаагаад банк, санхүүгийн байгууллага дээр захиалга авсан 48 айлын орон сууцтай байр барилаа гэхэд 20 дээр нь захиалга авсан бол 28 дээр нь л барьцаанд тавьж болохоор орж байгаа. Тэгэхгүй нэг объект дээр 3, 4 хэрэглэгчид зардаг, банк, санхүүгийн байгууллагад ч тавьдаг. Ингээд маш их хэмжээний эрсдэлүүдийг овоолж босгож ирдэг. Дараа нь захиалагчдын дунд нь шүүхдээд ав гэдэг. Мөнгийг нь зүгээр үнэ төлбөргүй эргэлдүүлж байгаа байхгүй юу. Залилах гэмт хэрэг.

Үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хууль дээр бас залилах гэмт хэргийн бас ял хариуцлагыг нэлээн чангалж өгч байгаа. Үл хөдлөх барьцааны хууль дээр бас оруулж өгч байгаа. Гэх зэрэг энэ хуулиуд байгаа.

О.Номинчимэг: П.Сайнзориг гишүүн 1 минут.

П.Сайнзориг: Засгийн газар бас ийм хуулийн төсөл яваа юм байна. Ороод ирэхэд цаг хугацааны хувьд таарвал бас нэгтгээд хэлэлцэх асуудал энэ тэр тусдаа байх.

Тэгэхдээ аль болохоор гишүүдийн санаачилж байгаа хуулийн төслийг бас богино хугацаанд хууль тогтоомжийн хуулийн дагуу хариу өгөөч ээ. Сүүлийн үед ерөөсөө хоёр, гурван сарын хугацаа өнгөрсөн ч хариу өгөхөө больсон. Гишүүдийг хүн гэж тоохоо больсон.

Тэгэхээр үүнийг Хууль зүй, дотоод хэргийн яамны ажил хариуцаж байгаа залуучууд энэ хууль тогтоомжийн хуулийн дагуу оруулж өгөөч.

Би Тендерийн хууль дээр хариу авах гээд бараг хоёр сар, гурван сар болж байна. Одоо хүртэл өгөөгүй. Тэгээд Өргөдлийн байнгын хороон дээр бас гишүүд маань хэлэлцээд ажлын хэсгээс гарч байгаа санал, дүгнэлтийг би аваад хуулийн төслүүдээ улам чамбайруулахад бэлэн байгаа.

Өнөөдөр хоёр, гурван хүнтэй утсаар холбогдож ярилаа. Яг гэрээ байгуулан орон сууц захиалгын юун дээр жишээ нь гэрээ байгуулсан компани өөрийнхөө дансанд авдаггүй дандаа туслан гүйцэтгэгчийнх нь компаниар аваад маргаан үүсгээд явахад шүүхээр хүндрэлтэй байна гэж байна.

Тэгэхээр олон асуудлуудыг нюанстай шийдье гэсэн ийм зүйл байгаа. Тэгээд Өргөдлийн байнгын хорооны гишүүдтэй яг уг асуудал дээр хамтарч ажиллахад миний бие... /минут дуусав/

О.Номинчимэг: Хууль зүйн сайд.

Б.Энхбаяр: Намайг сая 11 сард ажил авахад Улсын Их Хурлын гишүүдээс санаачилж Засгийн газраас санал авахаар 20 орчим хуулийн төсөл овоорсон байсан. Хугацаа хэтэрсэн, дарагдсан.

Би бүх саналуудыг нь Засгийн газрын хуралдаанд оруулаад саналуудыг нь өгч байгаа.

Сайдаар томилогдсоныхоо долоо хоногийн дараах Засгийн газрын хуралдаанаар би Улсын Их Хурлын гишүүдээс санаачилсан 10 хуулийн төсөлд Засгийн газрын саналыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж саналыг нь өгсөн. Дарагдсан овоорсон.

П.Сайнзориг гишүүний хэлж байгаа Тендерийн хууль санал авахаар манай яаманд хоёр сарын өмнө ирээгүй. Өнгөрсөн долоо хоногийн өмнө бичгээр Засгийн газрын санал авах бичиг нь ирсэн.

Тэгэхээр би огноотой бичгийг нь танд өгье. Над дээр хэзээ ирсэн байна вэ гэж.

Тэгэхээр ерөөсөө дарагддаг асуудал миний зүгээс гаргадаггүй. Хамгийн боломжит хугацаагаар маш шуурхай байх. Тэгэхдээ шуурхай гэдэг нь ажил хэрэгч байх үүднээс хандаж байгаа.

Би нэг зүйлийг хэлмээр байна. Одоо Хууль зүйн яам тусгайлан өгөх саналгүй гэдэг ийм санал өгөхийг би зөвшөөрөхгүй байгаа. Ажил хэрэгч, тодорхой. Дэмжсэн бол дэмжсэн, дэмжээгүй бол яагаад дэмжээгүй гэдгээ үндэслэлээ тайлбарласан ийм саналуудыг боловсруулж өгч байх ёстой гэдэг зарчмын байр суурьтай байгаа. Хууль зүйн сайд. Ажил хэрэгч хандаж байх ёстой.

Тэгэхгүй мэддэг юм уу, мэддэггүй юм уу. Олон хүчин зүйл нөлөөлдөг юм байна гэж би ч үзсэн. Хүний нөөцийн хувьд асуудал байна. Хүнд суртал ч байх шиг байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам энэ хаврын чуулганаар 15 хуулийн төслийг өргөн барина. Та бүхэн анзаарч байгаа бол сүүлийн 3 сарын хугацаанд долоо хоног болгон Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр хуулиудын хэлэлцүүлгүүд болж байгаа. Шинэ хуулиудын. Долоо хоног болгон. Долоо хоног болгон Засгийн газрын хуралдаанаар шинэ хуулиудын төслүүдийг хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн барина.

Тийм учраас Улсын Их Хурал их завгүй болох байх. Би ачааллаар булна гэж бодож байгаа. Шинэтгэлээр. Ажил хэрэгч хандана. Бүтээлч санал шүүмжлэлүүдийг хүлээж авна.

Сая ярьж байгаа Засгийн газраас боловсруулж байгаа энэ хуулийн төсөлтэй адил агуулга бүхий хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг ахлаад бас нэр бүхий гишүүд боловсруулж байгаад би бас баяртай байна.

Энэ юу хэлж байна вэ гэхээр энэ асуудал Улсын Их Хурал дээр ажил хэрэгчээр шуурхай хэлэлцэгдэж явах боломж бүрдэх юм байна. Яагаад гэхээр хоног хоногоор энд хохирч байгаа иргэдийн тоо цаана нь байгаа юм. Хохирч байгаа иргэдийн маш их хөрөнгө байгаа юм.

Тийм учраас тогтоогч бидний бас нэг үүрэг бол хугацаа алдалгүйгээр нэгэнт өвчнөө оношилж байна. Өвчнийхөө суурь шалтгааныг мэдэж байна. Мөн эмчилгээгээ бас мэдэж байна бид нар

Тийм учраас үүнийг даруй Улсын Их Хурлын гишүүд маань энэ хуулийн төсөл ороод ирэхээр дэмжээд өгөөсэй гэж хүсэж байна.

Ганцхан зүйл дээр зүгээр хугацаа алдаад байгаа. Тэр нь Хууль тогтоомжийн тухай хуулийнхаа дагуу олон нийтийн вебсайт дээр нэг сар хэлэлцүүлэх ёстой гээд бид нэг сарынхаа хугацааг дуусгах гээд Засгийн газрын хуралдаанаар оруулж чадахгүй байгаа юм. Түүнээс бүх юмаа бэлдээд байгаа юм.

О.Номинчимэг: Зөв зөв. Баярлалаа. П.Сайнзориг гишүүн тодруулах уу?

П.Сайнзориг: Ижил агуулга гэж байх шиг байна. Таатай байна. Ороод ирэхээр нь хэдүүлээ агуулга энэ тэр нь давхцаж байвал ажлын хэсэг Өргөдлийн

байнгын хорооны гишүүд ч гэсэн асуудлыг тал талаас нь шийдэж байгаа учраас, асуудлыг мэдэж байгаа учраас идэвхтэй оролцоосой гэж хүсэж байна.

Агуулгын хувьд Хууль зүйн байнгын хороо руу орох болов уу л гэж зүгээр хүлээлттэй байгаа. Энэ дээр хэдүүлээ өмчийн асуудал байгаа учраас нарийн нюансыг нь олъё.

Ер цаашдаа хэрэглэгчийн гэрээний асуудал энэ орон сууц захиалга гэхгүй сургалтын гэрээний асуудал байгаа. Дандаа хүүхдүүдийг хохироодог. Зуучлалын гэрээний асуудал байгаа. Маш их хэмжээний эрүүл мэндийн үйлчилгээ авахаар зуучлал явдаг. Дандаа хохироод үлддэг ийм асуудал байгаа. Гэх зэргээр хэрэглэгчийн гэрээний тав, зургаан сэдэв үндсэндээ дандаа ард нь иргэд хохироод үлдэж байгаа ийм зүйл байгаад байгаа юм. Үүнийг уг нь бас нэг багцад нь авч үзэх ёстой юм байгаа.

Хоёрдугаарт, тендерийн хууль түрүү долоо хоногт яваагүй. Үүнийг Хууль зүйн сайд хариуцлагатай хэлээрэй. Ганцхан Сангийн яамны саналыг хүлээгээд байна гэж танай хүмүүс хэлсэн. Хоёр, гурван сар хэвтэж байгаа шүү.

Тэгээд би бас олон л хуулийн төслүүд явуулж байгаа. Дандаа хариу ирэхгүй байгаа. Тэгээд аль болохоор... /минут дуусав/

О.Номинчимэг: Тэгээд энэ чуулган иргэд рүүгээ чиглэсэн ажил хэрэгч чуулган байгаасай гэж хаана хаанаа хүсэж байгаа. Үүний төлөө бүгдээрээ хамтарч ажиллах ёстой. Би чи гэлгүйгээр.

Өргөдлийн байнгын хорооны хувьд энэ асуудал үнэхээр тулгамдсан асуудал байна, нийгмийн асуудал болоод байна гэдгийг гаргаж ирж байгаа.

Тэгээд шуурхай ажиллаад бас шийдлүүд гаргаж ирж байгаа Хууль зүйн сайд болон гишүүдийн бас санаачилга байж байгаа. Барилгын яам ч гэсэн энэ дээр бас саналуудаа өгөөд явж байгаа гэж ойлгосон. Тэгээд талархаж байна.

Тэгээд энэ ташрамд хууль нэгэнт боловсруулагдаад явж байгаа учраас бид өмнө нь Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоотой хамтарсан уулзалт хийсэн. Энд ирсэн манай нийслэлийнхэн, хот байгуулалтынхан, барилгын яамныхан, бүртгэлийнхэн гээд олон төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийсэн.

Тэгээд бидний хүрсэн нэг дүгнэлт зөвхөн бүртгэлийн асуудлаар урьдчилсан тэмдэглэгээ буюу энэ бүртгэлийн асуудлаар зарим асуудлыг бид шийдэж чадна. Гэхдээ барилга нь баригдаж эхлээгүй, эсвэл нөгөө компаниуд нь бүртгүүлэхгүй байгаа энэ асуудал дээр бид хэрэглэгчээ, иргэдээ хамгаалах асуудал орхигдох юм байна. Тэгээд энэ дээр нөгөө шийдлийг нь олох ёстой гэдэг юм байгаа.

Тэгээд ялангуяа энэ барилгын л салбар болохоор санхүүжилттэй холбогддог. Энэ санхүүжилтийг бид үнэхээр иргэдээс авсан, босгосон

санхүүжилтээ тэр барилгадаа зарахгүй өөр юм руу аваад, залилан ч гэдэг юм уу, санаатай юм уу санаагүй. Тийм ээ. Алга болгодог.

Энэ дээр хөндлөнгийн хяналтын механизм орж ирэхгүй бол бид бүрэн бүтэн байдлаар энэ асуудлыг шийдэж чадахгүй нь гэдэг санал, дүгнэлтэд хүрсэн. Тийм ээ. Энд оролцсон хүмүүс бүгдээрээ мэдэж байгаа.

Та нар бод л доо. IPO буюу олон нийтээс санхүүжилт татаад компани өөрийгөө санхүүжүүлээд өөрсдийгөө. Тийм ээ. Үнэлгээ гаргаад олон нийтэд мэдээллээ ил гаргадаг. Тэгтэл компани нэг муу одоо юу гэдэг юм байшин барих төсөл. Өөрөө ямар ч санхүүгийн чадавх байхгүй. Бусад энгийн иргэдээ санхүүжилт босгож байшингаа төслөө хэрэгжүүлж байгаа. Тэгэхдээ энэ дээр ил тод байдал байхгүй. Ямар нэгэн хариуцлага байхгүй. Хяналт байхгүй ийм систем л өдий хүртэл явж ирсэн байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр Та бүхэн санхүүжилттэй нь холбосон хяналтын механизм оруулж ирэх дээр анхаараарай гэдгийг хэлмээр байна.

Дээр нь хаягжилтын асуудал маш чухал гэдгийг бүртгэлийнхэн маань ч хэлж байсан, бусад оролцогчид маань ч хэлж байсан. Монгол Улсын тэр хаягжилтын тухай хууль дээрээ бас өөрчлөлтүүд орох ёстой юм билээ шүү. Энэ системийг бид хамтад нь хийх ёстой юм байна шүү гэдэг бидний хэлэлцүүлэг, уулзалтаас гарсан шийдлийн гол асуудлуудыг бас энэ ташрамд та хэддээ бас дахиад сонсгоё гэж бодлоо.

Ингээд асуулт асууж дууссан. Тэгээд үг байгаа. Тийм ээ. Энэ асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Манай хоёр гишүүн байна. Хоёр гишүүнээр тасаллаа. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

С.Эрдэнэбат: Өнөөдрийн мэдээллээс харж байхад яг ингээд хуулийн гажуудал юм уу, 16-аас дээш давхарыг Барилгын яам хариуцна, дотогш нь нийслэл хариуцна.

Тэгээд сүүлдээ байгаль орчин гээд ерөөсөө иргэд бол нэг л тодорхой зүйлийг хүсэж байгаа. Би байр захиалахад хавь орчинд нь ямар төлөвлөлт байгаа юм, газар нь баталгаатай юм уу, хууль, эрх зүйн зөрчил байгаа юм уу, миний эрсдэл надад хэр зэрэг эрсдэлтэй юм бэ гэдгийг л мэдэхийг хүсээд байна шүү дээ.

Тийм учраас бидний хувьд асуугаад учрыг нь олохгүй толгой эргээд байхад жирийн иргэд бол тун хэцүү юм байна. Тэр мэднэ, энэ мэднэ гээд бид бие бие рүүгээ шидсээр байгаад ийм байдлаар асуудалд хандаж болохгүй.

Тийм учраас манай эрхэм мэргэжилтнүүд, албан тушаалтнууд хууль боловсруулахад Та бүгд маань яг бодит тулгараад байгаа өдөр тутмын Та

бүгдийн ажил, амьдралд тулгамдаж байгаа маш олон мянган иргэд хохирсон байж байна.

Одоо бид нарыг яриад сууж байх хооронд л маш олон хүмүүс гэрээ захиалж л байгаа. Ямарваа нэгэн байрны асуудлыг хохироод л, юу руу орж байгаагаа мэдэхгүй л тэгээд л захилаа.

Түрүүн Б.Бат-Эрдэнэ гишүүн хэллээ дээ. Авлига хороолол гээд. Иргэдийн буруу биш шүү дээ. Уг нь зөвшөөрөл нь зөв байсан юм байна. Гэхдээ гэнэт үер болсон чинь асуудал болоод ийм боллоо л гэдэг. Ийм байдлаар цаашид хандаж болохгүй ээ.

Тийм учраас байгаль цаг уур, бусад маш олон хүчин зүйлийн үүднээс хууль илүү амьдралд нийцсэн байх ёстой. Тэр үүднээсээ өнөөдрийн юунаас тэр хохирсон иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль, эрх зүй рүү бүгдийг нь жихээд хаяж болохгүй ээ. Үнэхээр шүүхийн шийдвэр нь гараад байж байгаа юм бол одоо нэг иргэн нэг барилга захиалангуутаа нэг компани дампууруулаад дахиад өөр компани байгуулаад дахиад өөр тендерт ороод л явцгааж байгаа.

Тийм учраас ийм хариуцлагагүй асуудал дээр бид нөгөө талд нь хязгаарлалт хэм хэмжээг нь яаж өгөхгүй бол нэг хүний эрх нөгөө хүний эрхээр хязгаарлагдана гэдэг шиг маш олон иргэн насаараа цуглуулсан, зээлсэн. Энэ чинь цаана нь гэр бүлийн хэрүүл, маш олон зүйл цаана нь хэргүүд болж байгаа шүү дээ.

Тийм учраас энэ асуудал дээр манай албан тушаалтнууд маань бас хариуцлагатай. Хууль гаргахад Та бүгд маань бие бие рүүгээ жихэх байдлаар биш дараагийн ээлжид маш тодорхой точный хариулдаг ийм л хуулийг бичихэд өөрсдөө идэвхтэй оролцож ажиллая гэж бодож байна.

Тэгээд иргэдтэй холбоотой хуулиуд дээр орж ажиллана гэдгийг хэлмээр байна. Тэгээд одоо телевиз үзэж байгаа олон иргэд л хараад сууж байгаа байх л даа. Одоо би яах вэ гээд. Над дээр гэхэд бараг 200-аад иргэн хохирсон гээд нэлээн олон холбогдогчтой. Тл гараад байгаа нь тэр байгаа байх. Ил гараагүй маш олон хүмүүс өнөөдөр хохирч байгаагаа ч мэдэхгүй яваад байгаа юм байна. Баригдсан, орсон байгаа байшингийнх нь доод талынх нь газар “отог” нэртэй. Хэзээ нэгэн цагт ямар нэгэн шаардлагаар буулгах жагсаалтын юунд хүртэл орсон явж байгааг л мэдэхгүй явж байгаа шүү дээ.

Тийм учраас буруу орж ирсэн асуудлыг бие бие рүүгээ чихэхгүйгээр иргэдийнхээ эрх ашгийг нэн тэргүүнд тавьж ажиллая гэдгийг хэлмээр байна.

О.Номинчимэг: Үг хэллээ. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёр юм ойлголоо.

Барилгын яамны дэд сайдын болон бусад хүмүүсийн хариулж байгаа хариултаас.

Нэгдүгээрт, та нарт лизингээр байр авсан нэг ч хүн байхгүй юм байна. Та нар дандаа бэлэн мөнгөөр авдаг юм байна. Хэрвээ байр лизингээр авдаг байсан бол өнөөдрийн та нарын хариулт ийм байхгүй байсан. Би үүнийг ойлгож байна. Та нарын ярианаас

Хоёрдугаарт, усан дээр Монгол Улсын хууль тогтоомж усан дээр барилга барьж болно л доо. Асуудалгүй. Стандарт нь хангагдсан юм уу, үгүй юу гэдэг асуудал.

Гэхдээ өнөөгийн хууль тогтоомжоор боломжгүй. Тэнд ус гэнэт гарч ирээгүй. Хууль ёсны барилга гэж би ерөөсөө бодохгүй байгаа. Тэгээд дэд сайд нь хууль ёсны барилга гэдгийг албан ёсоор Байнгын хорооны хуралдаан дээр мэдэгдэж байх шиг байна.

Байгаль орчны яам Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийг хэрэгжүүлдэг, хяналт тавьдаг. Тэнд Байгаль орчны яаман дээр тусгай хамгаалалттай газар нутаг дээр зөвшөөрөл олгогдохдоо орж ирсэн төсөл нь дандаа жижиг байшин байдаг. Зочид буудал. Отоглох хэлбэрийн. Энэ хаана өөрчлөгддөг вэ гэхээр “А” даалгавар авах гэж очихдоо өндөр байшин болж хувираад миний нөгөө түрүүний хэлсэн 2013 онд Улаанбаатар хотын захирагчаар ажиллаж байсан Э.Бат-Үүл Нисэх, Яармагийг хөгжүүлэх төлөвлөлт гэж гаргаж иргэдийн хурлаараа батлуулаад, 2014 онд дулаан татах зөвшөөрлийг нь гаргаж өгөөд, 2015 онд стандарт дотроос нь 2 давхар болон түүнээс дээш өндөржилттэй баригдах хориглолтыг нь авч хаяад, ингээд 2015 оноос энэ өндөр барилга Богд хаан ууланд баригдсан байдаг юм.

Би бүгдийг нь зогсоож байсан. Өнөөдөр ч Байгаль орчны яамныхантай уулзахаар таны гайгаар энэ олон цуцлагдсан зөвшөөрөлтэй холбоотой асуудал дээр чинь бид шүүхийн харилцаа үүсгээд өмгөөлөгч нар маш завгүй ажиллаж байна гэж хэлдэг.

Байгаль орчны яамны хуулийн хэлтсийнхэн тэр чигээрээ өдөр болгон хэдэн арван шүүх хуралдаанд таны цуцалсан шийдвэрээр Захиргааны хэргийн шүүх асуудал үүссэн учраас бид очиж орж байгаа гэж ярьдаг байхгүй юу.

Өнөөдөр Богд хаан ууланд баригдаж байгаа өндөржилттэй олон барилгууд байгаа. Гүний устай шүү дээ. Та нар мэдэх үү. Та нар мэдэхгүй байх. Гүний устай. Дулаан нь асуудалтай. Нөгөө хэлээд байгаа та нарын барилгын стандарт тэнд бүгд зөрчигдөж байгаа.

Хоёрдугаарт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар тэд нар төлбөр төлдөг. Газрын төлбөр. Өндөр төлбөр төлдөг. Одоо бусад газрыг бодвол. Тэр мөнгийг нь авч чадахгүй хэлбэр дээр Газрын татварын алба, бүгд орсон байгаа.

Та нарын хариултаас сонсох юм бол Барилга, хот байгуулалтын яам гэж байх хэрэг байгаа юм уу. Та нар юу ч мэддэггүй юм байна шүү дээ. Юу ч хийдэггүй юм байна шүү дээ та нар. Өөрсдөө хариуцлагаа хүлээгээд Монгол Улсын барилгажилтын норм, дүрэм стандартыг бариулаад хууль, эрх зүйн орчин дээр бид нарт болохгүй байгаа асуудлууд нь энэ байна гээд бодлогын хувьд хууль, эрх зүйн орчноо өөрчлөхийн төлөө та нар ажилладаггүй юм байна шүү дээ.

Ийм олон дарга албан тушаалтнууд суучхаад нийслэл рүү чихээд сууж байна шүү дээ. Та нар. Одоо аймаг дээр байсан бол аймаг руу эх юм байна л даа. Тэгвэл та нараар яах юм. Та нар Барилга, хот байгуулалтын яам руу яамныхаа бүх эрх мэдлийг нийслэл рүү шилжүүл. Бүгдийг нь шилжүүл. Та нарт ч хэрэггүй шүү дээ. Ажлаасаа гарцгаа. Ний үг хэлэхэд. Дэд сайд хүн ингэж хариулж болохгүй шүү. С.Энхболд дэд сайд аа. Та дэд сайд хүн шүү. Газрын дарга биш, хэлтсийн дарга биш.

Тэгээд шийд. Шийд гэж таныг дэд сайд дээр тавьсан. Дэд сайдынхаа албан тушаалын эрх үүргийн хүрээнд асуудлыг шийдэж чадахгүй бол ажлаа өгөх хэрэгтэй.

Иймэрхүү юмнуудаа хэдүүлээ шийдээд явах хэрэгтэй. Одоо тэгээд авлигал хорооллыг албан ёсны гэж зарласан бараг анхны хурал байх. Би олон удаагийн хуралд орж байсан. Энэ хэрэглэгч, иргэдийн хохирол учирвал Та нар хариуцаарай.

О.Номинчимэг: Өнөөдөр хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асууж, үг хэлэх гишүүд ингээд дууслаа.

Өнөөдөр бас энэ асуудалд биечилж оролцсон Хууль зүйн сайд одоо удахгүй хуулиа өргөн барих юм байна. Бодлого дээр ажиллаж байгаа оролцсон яам, Тамгын газрынхандаа баярлалаа.

Тэгээд хамгийн гол нь бид иргэдийнхээ асуудлыг шийдэхийн төлөө хамтарч хурдтай ажиллах хэрэгтэй байна. Хугацаа их алдаж байна. Тэгээд энэ дээр л бид бодлого боловсруулагчдынхаа анхааралд үүнийг оруулж хамтарч ажиллаж, шийдэл гаргах тал дээр л ажиллаж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Өнөөдрийн Өргөдлийн байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хурал хаагдсаныг мэдэгдье ээ. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 4 цаг 12 минут үргэлжилж, 16 цаг 57 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД